

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 7 ДУГААР САРЫН  
5-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудас</b>
<b>1.</b>	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-24
<b>2.</b>	<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	25-103
	1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	25-103

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 7 дугаар сарын  
05-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 38 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: О.Баасанхүү, Б.Наранхүү, Д.Эрдэнэбат;  
Тасалсан: Б.Жавхлан.

**Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, дэд хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат асан, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, дэд хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат асан, Улсын Бага Хурал, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, дэд хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга асан, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, хууль зүйн ухааны доктор Ц.Цогт, дэд хэсгийн ахлагч, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор, Хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа, референт Б.Золбоо, Ж.Ганчимэг нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд иргэд, олон нийт, улс төрийн намуудаас ирүүлсэн саналыг Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танилцуулав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол, Өргөдлийн байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нар тус тус танилцуулав.

*Хуралдаан 13 цаг 40 минутад түр завсарлаж, 15 цаг 20 минутаас үргэлжлэв.*

Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчаас Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг, Ж.Батзандан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн эхийг баригч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Болд маргаантай зарим саналыг нээлттэйгээр үлдээж, санал хураалгахгүй байх, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан саналуудыг багцалж санал хураалгах горимын саналуудыг гаргав.

**С.Бямбацогт:** 1.Улсын Их Хурлын гишүүн Л.Болдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул маргаантай саналуудыг санал хураалгахгүй үлдээхээр болов.

2. Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	6
Бүгд:	13

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул саналуудыг багцалж хураалгахаар болов.

*Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаар ажлын хэсэг, Байнгын хороодоос гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулав.*

**НЭГ.Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт:**

## **1.Төслийн 2 дугаар зүйл буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн. Төрөөс байгалийн баялгийг ашиглахдаа тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах зарчмыг баримтална.” гэсэн төслийн заалт болон хамт гарсан багц саналуудыг дахин ярилцахаар санал хураалтыг хойшлуулав.

## **2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес<sup>1</sup> дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг:**

“**19<sup>1.1</sup>**.Нам иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна.

**19<sup>1.2</sup>**.Намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх сурвалж болон зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүжилт, ил тод байдал, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх болзлыг хуулиар тогтооно.” гэсэн төслийн заалт болон хамт гарсан багц саналуудыг дахин ярилцахаар санал хураалтыг хойшлуулав.

Дээрх саналтай холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан санал хэлэв.

## **3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг:**

“21.4.Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо, журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэсэн төслийн заалт болон хамт гарсан багц саналуудыг дахин ярилцахаар санал хураалтыг хойшлуулав.

## **С.Бямбацогт: 4. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:**

“3.Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлснээс дөчин тав хоногийн дотор, эсхүл Ерөнхий сайдыг шинээр томилох нөхцөл үүссэн өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхий сайдыг томилоогүй бол Улсын Их Хурлыг тараах шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана.

4.Энэ зүйлийн 2, эсхүл 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр гаргаснаас хойш Улсын Их Хурал арав хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж, жар хоногийн дотор явуулна. Шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хадгална.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	14
Бүгд:	14

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн санал хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, Н.Энхболд нар хуралдааны дэгтэй холбогдуулан санал хэлэв.

**4.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“3.Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш дөчин тав хоногийн дотор, эсхүл Үндсэн хуулийн дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш гуч хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	3
Бүгд:	14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**5.Төслийн 4 дүгээр зүйл буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтаас “Засгийн газрын гишүүд,” гэснийг хасах гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	2
Бүгд:	14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**5.1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлээс “Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд” гэснийг “Ерөнхий сайд,” гэж,” гэснийг хасах гэсэн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн:	1
Татгалзсан:	13
Бүгд:	14

7.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**6. Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:**

“25.1.7.төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах. Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын

зөвшөөрөлгүй зардлын шинэ төрөл үүсгэж, зарлага нэмэгдүүлэхгүй. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно;" гэсэн төслийн заалт болон хамт гарсан багц саналуудыг дахин ярилцахаар санал хураалтыг хойшлуулав.

**7.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“27.6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар батална.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан санал хэлэв.

**7.1.**Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг “Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар хуулийг бүхэлд нь эцэслэн батална” гэж өөрчлөн найруулах гэсэн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	2
Бүгд:	13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**8.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг:**

“**28.2.**Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.

**28.3.**Хянан шалгах түр хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн, хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй. Түр хороо дүгнэлт гаргаж, шаардлагатай бол тухайн асуудлыг эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлж болно. Түр хорооны дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй. Хорооны хэлэлцсэн баримтыг нотлох баримтад тооцох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

28.4.Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн төслийн заалт болон хамт гарсан багц саналуудыг дахин ярилцахаар санал хураалтыг хойшлуулав.

**9.Төслийн 4 дүгээр зүйл буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх заалт:**

9.1.Төслийн 4 дүгээр зүйлийн буюу Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь” гэснийг “Улсын Их Хурлын гишүүн нь Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол албан үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль зөрчсөнийг Үндсэн хуулийн цэц тогтоож, эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол тухайн гишүүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэж өөрчлөн найруулах гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.2.Төслийн 4 дүгээр зүйлийн ““Ерөнхий сайд,” гэж,” гэсний дараа мөн заалтын “өөрчлөх,” гэснийг “чөлөөлөх,” гэж нэмэх гэсэн саналаа Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар тайлбарлаж татаж авав.

Төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	10
Бүгд:	13

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

***ХОЁР.Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт:***

**1.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн төслийн заалт болон хамт гарсан багц саналуудыг дахин ярилцахаар санал хураалтыг хойшлуулав.

**1.1.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн нь Улсын Их Хурлын гишүүн байж болно.” гэсэн төслийн заалт болон хамт гарсан багц саналуудыг дахин ярилцахаар санал хураалтыг хойшлуулав.

**2.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.1.**Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “өөрөө” гэснийг “шууд” гэж өөрчлөх гэсэн саналаа Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар тайлбарлаж, татаж авав.

**2.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	1
Бүгд:	12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.1.**Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	0
Бүгд:	11

100 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.2.**Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	1
Татгалзсан:	10
Бүгд:	11

76.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.



**3.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулж, шинэ Ерөнхий сайдыг томилох тухай саналыг хамтад нь албан ёсоор тавивал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонх уг саналыг дэмжсэн бол шинэ Ерөнхий сайдыг томилох, өмнөх Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцно.” гэсэн төслийн заалт болон хамт гарсан багц саналуудыг дахин ярилцахаар санал хураалтыг хойшлуулав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат санал хэлэв.

**4. Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу Дөчин зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийн хэсэг:**

“4.Төрийн жинхэнэ алба нь мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай байх, шатлан дэвших зарчимд үндэслэнэ. Төрийн албан хаагчийг улс төрийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, сонгуулийн үр дүнгээр, эсхүл хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, халахыг хориглоно. Төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилтэд тавих хяналт хараат бус байна.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	11
Бүгд:	11

0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**4.1.**“4.Төрийн жинхэнэ алба нь мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай байх, шатлан дэвших чадахуйн зарчимд үндэслэх бөгөөд түүний хэрэгжилтэд хяналт тавих байгууллага хараат бусаар ажиллана. Төрийн жинхэнэ албан хаагчийг хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, халахыг хориглоно.” гэсэн ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**4.2.** дахь саналыг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

**4.3.** “4.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн Дөчин зургаадугаар зүйлийн 4 дэх хэсгийн “шатлан дэвших” гэснийг хасах гэсэн Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
-------------	---

Татгалзсан: 11  
Бүгд: 11  
0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**5. Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“Ерөнхийлөгчөөр тавин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 7  
Бүгд: 11  
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**5. Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“Ерөнхийлөгчөөр тавин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн саналаар дахин санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 7  
Бүгд: 11  
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**5.1.** Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь, М.Оюунчимэг нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавин таван” гэснийг “тавин” гэж өөрчлөх гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй, Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй, Өргөдлийн байнгын хорооны дэмжсэн төслийн заалтыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**5.1.** Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавин таван” гэснийг “тавин” гэж өөрчлөх гэсэн Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь, М.Оюунчимэг нарын гаргасан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй, Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй, Өргөдлийн байнгын хорооны дэмжсэн төслийн заалтыг дэмжье гэсэн саналаар дахин санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**5.1.** Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь, М.Оюунчимэг нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавин таван” гэснийг “тавин” гэж өөрчлөх гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй, Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй, Өргөдлийн байнгын хорооны дэмжсэн төслийн заалтыг дэмжье гэсэн саналаар дахин санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**6.Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно.” төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**6.1.**Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “энэ зүйлд” гэснийг “Үндсэн хуульд” гэж өөрчлөх гэсэн саналаа Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар тайлбарлаж, татаж авав.

Дээрх саналтай холбогдуулан дэд хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав тайлбар хийв.

***ГУРАВ.Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт:***

**1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалт:**

“1/Шүүхийн ерөнхий зөвлөл арван гишүүнээс бүрдэнэ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллана;” төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

1. Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын “арван гишүүнээс бүрдэнэ.” гэснийг “арван таван гишүүнээс бүрдэнэ.” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	1
Татгалзсан:	10
Бүгд:	11

9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан саналаа тайлбарлав.

1.2. Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан, С.Бямбацогт нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын “бүрдэнэ” гэснийг “бүрдэх бөгөөд ажлаа Улсын дээд шүүхэд танилцуулна.” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	7
Бүгд:	11

36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

1.2. Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан, С.Бямбацогт нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын “бүрдэнэ” гэснийг “бүрдэх бөгөөд ажлаа Улсын дээд шүүхэд танилцуулна.” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналаар дахин санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	2
Татгалзсан:	9
Бүгд:	11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбатын тавьсан асуултад Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, хууль зүйн ухааны доктор Ц.Цогт хариулж, тайлбар хийв.

**2.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалт:**

“2/Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нэр дэвшүүлэн томилгооны сонсгол хийж, Улсын Их Хурал хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар томилно. Тэдгээр нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэн байна;” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 11  
Бүгд: 11  
0.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтын эхний өгүүлбэрийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“2/Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн гурвыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, нэгийг Засгийн газар, нэгийг мэргэжлийн холбооноос тус тус нээлттэйгээр нэр дэвшүүлж, Улсын Их Хурал томилгооны сонголт хийн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар томилно.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.2.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтын эхний өгүүлбэрийг “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо” гэснийг “Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүдийн гурвыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо” гэж өөрчлөх гэсэн саналаа Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан татаж авав.**

**3.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Шүүгчийн хариуцлагын зөвлөл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон бусад шийтгэл ногдуулах, чөлөөлөх шийдвэр гаргана.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**3.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Шүүгчийн хариуцлагын зөвлөл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон бусад шийтгэл ногдуулах, чөлөөлөх шийдвэр гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар дахин санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 11  
Бүгд: 11

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**3.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“6.Шүүгчийн хариуцлагын зөвлөл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах шийдвэр гаргана. Уг шийдвэр нь Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэг, дөчин есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх маргааныг хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан өргөдлөөр Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.” гэсэн ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**3.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“6.Шүүгчийн хариуцлагын зөвлөл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах шийдвэр гаргана. Уг шийдвэр нь Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэг, дөчин есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх маргааныг хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан өргөдлөөр Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.” гэсэн ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан саналыг дэмжье гэсэн саналаар дахин санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**4.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын Дөчин есдүгээр зүйлийн 7 дахь хэсэг:**

“7.Шүүгчийн хариуцлагын зөвлөл есөн гишүүнтэй байна. Тэдгээрийн гурав нь шүүн таслах ажлын туршлагатай хуульч; гурав нь хууль зүйн эрдэмтэн; гурав нь иргэдийн төлөөлөл байна. Зөвлөлийн гишүүд нь зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно.” гэсэн төслийн заалт болон хамт гарсан багц саналуудыг дахин ярилцахаар санал хураалтыг хойшлуулав.

**5.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын Дөчин есдүгээр зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах бусад

шаардлагыг хуулиар тогтооно.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	10
Бүгд:	11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, **5.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“8.Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүгчийн хариуцлагын зөвлөл ажлаа Улсын Дээд Шүүхэд тайлагнана.” гэсэн Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	10
Бүгд:	11

0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, **5.2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“8.Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүгчийн хариуцлагын зөвлөл ажлаа Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд тайлагнах бөгөөд тэдгээрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	11
Бүгд:	11

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**6.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалтын Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, хорин нэгэн шүүгчээс бүрдэнэ.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**6.1.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хорин нэгэн” гэснийг хасах гэсэн Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан, Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 10  
Бүгд: 11  
9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар саналаа тайлбарлав.

**7.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалтын Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр таваас доошгүй жил ажилласан, гучин нас хүрсэн Монгол Улсын иргэнийг анхан шатны шүүхийн шүүгчээр томилно. Давж заалдах шатны шүүхийн шүүгч нь тухайн шүүн таслах ажлын төрлөөр дагнан анхан шатны шүүхэд зургаагаас доошгүй жил шүүгчээр ажилласан байна. Улсын дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан, дөчин нас хүрсэн Монгол Улсын иргэнийг арван хоёр жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа томилно.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 1  
Бүгд: 11  
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**7.1.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын иргэнийг 12 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа томилно.” гэсний дараа “Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн гуравны хоёр нь шүүн таслах ажлын туршлагатай байна.” гэж нэмэх гэсэн Улсын Их Хурлын гишүүн О.Батнасангийн гаргасан Хууль зүйн байнгын хороо дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан саналаа тайлбарлав.

Дээрх саналтай холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан, 7.2.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хуульчийн мэргэжлээр арван таван жил ажилласан” гэснийг “давж заалдах шатны шүүхэд арваас доошгүй жил ажилласан” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 11



Бүгд: 11  
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан, **7.3.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан” гэснийг “арваас доошгүй жил шүүгчээр ажилласан” гэж өөрчилж, “арван хоёр жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа” гэснийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 8  
Бүгд: 11  
27.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан, **7.4.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан,” гэснийг “Улсын дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан, анхан буюу давж заалдах шатны шүүхэд зургаагаас доошгүй жил ажилласан,” гэж өөрчлөх гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 10  
Бүгд: 10  
0.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан, **7.5.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан” гэснийг “давж заалдах шатны шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан” гэж өөрчлөх гэсэн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 10  
Бүгд: 10  
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**8.Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор томилгооны сонсгол хийж Улсын Их Хурал нийт гишүүний олонхын саналаар есөн жилийн хугацаатай томилно. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр дахин томилохыг хориглоно.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатар, Ж.Мөнхбат нарын тавьсан асуултад Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, хууль зүйн ухааны доктор Ц.Цогт, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор, Хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан, **8.1.Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “есөн жилийн хугацаатай” гэснийг “есөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа” гэж өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 0  
Бүгд: 11  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

**9.Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу Жаран тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арван таваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 0  
Бүгд: 11  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Л.Болд нарын гаргасан, **9.1.Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу Жаран тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “ажилласан” гэсний дараа “сүүлийн арван жил улс төрийн намын харьяалалтай байгаагүй” гэж нэмэх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 9  
Бүгд: 11  
18.2 хувийн саналаар дэмжигдлээ.

**ДӨРӨВ. Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт:**

**1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрт хамаарах асуудлаар хуульд заасан, эсхүл сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргана.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	11
Бүгд:	11

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**1.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хасах** гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

0.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу Жардугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргыг хуульд заасан үндэслэл, журмаар чөлөөлж, огцруулна. Сум, дүүргийн Засаг даргыг огцруулсан бол бүрэн эрхийн үлдсэн хугацаанд ажиллах Засаг даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга томилно.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	0
Бүгд:	11

100 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу Жардугаар зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“4.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. Тэдгээрийг хуульд заасан үндэслэл, журмаар чөлөөлж, огцруулна. Бүх шатны Засаг даргын бүрэн эрхийн хугацаа дараагийн Засаг даргын бүрэн эрх эхэлснээр дуусгавар болно.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	11
Бүгд:	11

0.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **3.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долоодугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Улсын болон орон нутгийн харьяалалтай хот, тосгоны эрх зүйн үндэс, тэдгээрийн өөрийн удирдлагын болон засаг захиргааны зохион байгуулалтын зарчмыг хуулиар тогтооно.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	0
Бүгд:	11

100 хувийн саналаар дэмжигдлээ.

### **3.1.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долоодугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“2.Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот; тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	4
Бүгд:	12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, О.Содбилэг нар тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, **3.2.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долоодугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасах** гэсэн Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	1
Татгалзсан:	11
Бүгд:	12

8.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

### **4.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Монгол Улсын нутгийн өөрийн удирдлагын үндсэн байгууллага нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал мөн. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн болон татвар тогтоох эрхтэй байна. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг иргэд сонгох журмыг хуулиар тогтооно.” гэсэн төслийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 11  
Бүгд: 11  
0.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**4.1.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“2.Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, **4.2.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эхний өгүүлбэрийг** “Монгол Улсын нутгийн өөрийн удирдлагын үндсэн нэгж нь сум, дүүрэг мөн.” гэж өөрчлөн найруулах гэсэн Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 10  
Бүгд: 11  
9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**5.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалтын Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурал нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дөрвөн жилийн хугацаагаар сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 10  
Бүгд: 11  
9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**5.1.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалтын Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийг хасах** гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 1  
Бүгд: 11  
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат санал хэлэв.

**6.Төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалтын Жардугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Аймаг, нийслэлийн Засаг даргыг аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлаас нэр дэвшүүлж Ерөнхий сайд; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно. Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлд заасан журмаар дахин нэг удаа нэр дэвшүүлж Ерөнхий сайд томилно.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал тайлбар хийв.

**6.1.Төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалтын Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“2.Аймаг, нийслэлийн Засаг даргыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нэр дэвшүүлж Ерөнхий сайд; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус томилно. Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлд заасан журмаар дахин нэг удаа нэр дэвшүүлж томилно.” гэсэн саналаа ажлын хэсэг татаж авав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, Д.Тогтохсүрэн нарын тавьсан асуултад дэд хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат асан, Улсын Бага Хурал, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, **6.2.Төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалт буюу Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн “; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус” гэснийг хасах** гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 12  
Бүгд: 13

7.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**7.Төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалтын Жардугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Сум, дүүргийн Засаг даргыг тухайн нутаг дэвсгэрийн иргэд дөрвөн жилийн хугацаагаар сонгож, аймаг, нийслэлийн Засаг дарга арван тав хоногийн дотор батламжилна. Сум, дүүргийн Засаг даргын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 12  
Бүгд: 13  
7.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Болд санал хэлэв.

**7.1.Төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалтын Жардугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“3.Сумын Засаг даргыг тухайн нутаг дэвсгэрийн иргэд хуулиар тогтоосон журмын дагуу сонгож, аймгийн Засаг дарга арван тав хоногийн дотор батламжилна. Дүүргийн Засаг даргыг сонгох, эсхүл томилох журмыг хуулиар тогтооно.” гэсэн ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 0  
Бүгд: 13  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

*Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулав.*

**С.Бямбацогт:** 1.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, 60.2 –т Аймаг, нийслэлийн Засаг даргыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нэр дэвшүүлж, Ерөнхий сайд баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга томилно.

Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлд заасан журмаар дахин нэр дэвшүүлэхдээ Ерөнхий сайдтай зөвшилцөн нэр дэвшүүлж томилно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 2  
Бүгд: 13  
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт 22.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй саналаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж шийдвэрлэсэн бол тухайн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх дуусгавар болсонд тооцно гэж өөрчлөн найруулах.

Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг саналаа тайлбарлаж, татаж авав.

Дээрх саналтай холбогдуулан дэд хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав тайлбар хийв.

3.Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт, 27.2-т 75-с доошгүй гэсний дараа ээлжит чуулганы ажлын өдрийг тухайн жилийн 3 дугаар сарын 1-ээс мөн 7 дугаарын сарын 29-с тоолно гэсэн өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 27.2 дахь хэсэгт “75-аас доошгүй” гэсний дараа “ээлжит чуулганы ажлын өдрийг тухайн жилийн 3 дугаар сарын 01-нээс мөн 7 дугаарын сарын 29-өөс тоолно” гэсэн өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	7
Бүгд:	11

36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэгийн гаргасан, 57.2-н эхэнд хүн амын их хэмжээний төвлөрөл бий болсон нутаг дэвсгэрийг улсын зэрэглэлтэй хот гэж үзэж нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж гэж тооцон эрх зүйн байдлыг нь хуулиар тогтооно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар /2/3-оор/ дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, Ж.Батзандан нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 13 дахь заалт буюу 60 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг өөрчлөх.



“Сум дүүргийн Засаг даргыг өөрчлөх” гэснийг “сум дүүргийн Засаг даргад” “тухайн аймаг нийслэлд, сум, дүүргийн Засаг даргыг” гэснийг “сум, дүүргийн Засаг даргад тухайн аймаг, нийслэлд сүүлийн 5-с доошгүй жил оршин сууж байгаа бөгөөд тухайн сум, дүүргийн сонгогчдын 50-с доошгүй хувийн дэмжлэгийг авсан иргэнийг нэр дэвшүүлж, тухайн 5-аас доошгүй хувийн дэмжлэгийг авсан иргэнийг нэр дэвшүүлж тухайн сум, дүүргийн иргэд 4 жилийн хугацаагаар сонгож аймаг, нийслэлийн Засаг дарга 15 хоногийн дотор батламжилна. Сум, дүүргийн Засаг даргын сонгуулийн журмыг хуулиар тогтооно гэж өөрчлөх” гэсэн саналыг дахин ярилцахаар санал хураалтыг хойшлуулав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Болд саналаа тайлбарлав.

*Хуралдаан 3 цаг 36 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн ирж, 73.6 хувийн ирцтэйгээр 18 цаг 52 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 7 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**С.Бямбацогт:** Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдааны нийт гишүүдийн хуралдаан эхлэх ирц бүрдсэн байна. 19 гишүүнээс 11 нь хүрэлцэн ирсэн 57.9 хувийн ирцтэй байна. Тэгээд хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.2-т бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө гэж заасан байгаа. Үүний дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос бусад Байнгын хороодын санал, дүгнэлтийг танилцуулна.

Үүний урд бас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.3-т Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад төсөл санаачлах үеэс эцэслэн батлах хүртэл бүхий л үйл ажиллагаанд иргэд, улс төрийн нам, олон нийтийн байгууллагын оролцоог хангах, иргэдэд төслийн талаар саналаа чөлөөтэй хэлэх бололцоог олгох гэж заасан байдаг. Үүний дагуу Монгол Улсын Их Хурлын дарга дээр ирсэн саналууд нэгтгэгдсэн байгаа. Тэгээд иргэд, олон нийт, улс төрийн намуудын ирүүлсэн саналын танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын дарга Занданшатар дарга хийнэ. Занданшатар даргын микрофоныг өгье.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу иргэд, байгууллагууд, улс төрийн намуудаас олон арван саналууд ирж байна. Энэ дотроо Улсын Их Хурлын чуулган, Төрийн байгуулалтын байнгын хороон дээр саналаа танилцуулж өгөхийг улс төрийн намуудаас хүссэн. Тухайлбал, нэр бүхий 15 нам, Иргэний зориг-Ногоон нах, ХҮН нам гэхэд 15 нам Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг дэмжээд, 6.1 дээр оруулах заалт дээр саналаа ирүүлсэн.

Энэ саналуудаа улс төрийн намууд, Байнгын хороо чуулганы хуралдаан дээр танилцуулж өгөөч гэдэг хүсэлт тавьсан. 2 дугаар хэлэлцүүлгийн үед чуулган дээр танилцуулах боломжгүй учраас Байнгын хороон дээр танилцуулж байна.

1."ХҮН" намаас ирүүлсэн санал болон бусад улс төрийн намуудаас ирүүлсэн санал багцлаад ирсэн саналын агуулгыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаарх Хөдөлмөрийн үндэсний намын байр суурийг хүргүүлэх тухай. Улсын Их Хурал нь 20 гишүүний саналаар хууль баталдаг. Гишүүд нь Улсын нэгдсэн төсвийг сонгогдсон тойрогтоо тэрбум тэрбумаар нь хувааж авахаар улайран дайрдаг, Засгийн газар нь дунджаар 1.8 жил ажилладаг, Ерөнхийлөгч нь хараат бус ажиллах ёстой шүүгчдэд томилгоогоор дамжуулан нөлөөлдөг. Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх нь Монгол Улсад шударга ёсыг тогтоох гэхээс илүү эзэндээ үйлчилдэг, Улсын Их Хурлын сонгууль бүрийг өөр тогтолцоогоор явуулдаг, товчоор хэлбэл, Монголын төр хямарсан нь нэгэнт тодорхой болсон. Иймд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, төрийн эрх мэдлийн хуваарилалтыг тодорхой болгохыг Хөдөлмөрийн үндэсний нам дэмжиж байна.

Харин тодруулбал гээд энэ бүх заалтуудыг дэмжиж байгаа зохицуулалт хийх шаардлагатай гэдгээ бичээд, харин хоёр асуудал дээр төслийн үзэл баримтлалаас бид өөр байр суурьтай байгааг анхаарч үзээч ээ гэсэн санал ирүүлсэн байна. Энэ нь Монгол Улс Улсын Их Хурлын сонгуулийн холимог тогтолцоог авч Үндсэн хуульд тодорхой зааж өгөх, орон нутгийн удирдлагатай холбоотой асуудлыг энэ удаа авч үзэхгүй, Монгол Улсын хөгжлийн загвар бодлоготой хамт нийт Монголчууд стратеги судлаачид, нийгэм, эдийн засгийн хөгжлийн мэргэжилтнүүдийг оролцуулан дангаар нь одоогийн төслөөс тусад нь хэлэлцэж шийдэх асуудал гэж үзэж байна гэсэн ийм саналыг ирүүлсэн байна.

Монголын хуульчдын холбоо төрийн эрх мэдлийн хуваарилалт тэнцлийн хүрээнд Хуульчдын холбоо бол Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Хуульчдын холбооны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн хурлаараа хэлэлцээд тодорхой санал гаргаж ирүүлсэн. Нэгдүгээрт нь, төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнийг хавсран гүйцэтгэхийг бүрэн хориглох нь зүйтэй. Энэ талаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 96, 98, 2000 онд гаргасан шийдвэрүүдийг харгалзан үзэх шаардлагатай гэсэн нэг дэх санал.

Хоёрт, шүүх эрх мэдэлтэй холбоотой зохицуулалтын хүрээнд Улсын дээд шүүх, Ерөнхий шүүгч 21 шүүгчээс бүрдэнэ гэж тоо заасныг өөрчилж, тоо заахгүй болгоё. Одоо Улсын дээд шүүхийн 3 танхим байгаа ч танхим дотроо дагнан төрөлжих асуудал гарахыг үгүйсгэх аргагүй. Иймд Улсын дээд шүүхийн шүүгчдийн тоог хатуу тогтоож, хязгаарлах боломжгүй юм аа. Тэгээд өнөөдөр байгаа 21-ээс илүү тооны шүүгчийг ямар шалгуураар хэрхэн өөрчлөх нь тодорхойгүй байна гэж ийм шүүхтэй холбоотой ийм саналууд ирснийг ажлын хэсэгт хүргүүлсэн. Энийг санал ирүүлсэн хүмүүст мэдэгдэж байна.

Монгол Ардын Хувьсгалт намаас 6.2 дахь заалтад оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт дээр ард түмний дундын өмч гэж өөрчлөх, дээд боловсролыг үнэ төлбөргүй болгохыг заах гэх мэт 6 санал ирүүлснийг Энхтүвшин даргатай ажлын хэсэгт хүргүүлсэн. МАХН энэ нэмэлт, өөрчлөлтийг дангаараа хийж болохгүй, бидний саналыг заавал харгалзан үзээч ээ гэсэн утгатай саналыг ирүүлсэн байна. Байгалийн баялгийг ард түмний дундын өмч мөн гэдгийг хуульчлан тогтоох гэсэн үндсэн саналтай. Томьёололгүй, ер нь их, дээд сургууль, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, үнэ төлбөргүй болгох гэсэн ийм тодорхой саналуудаар ажлын хэсэгтэй уулзаж ярилцах, тайлбарлах ийм саналтай байгаа ирүүлжээ.

Ард иргэдээс зарим газруудад санал асуулга явуулсан. Баянхонгор аймагт явуулсан санал асуулгаар иргэдийн дунд энэ бүх зүйл, заалтаар дэмжих, дэмжихгүй, мэдэхгүй байна, түдгэлзэж байна гэсэн 4 хариултаар авахад 18530 санал дэмжиж, 2219 санал дэмжээгүй, 6245 санал ирүүлээгүй байна. Нийт 59377 санал ирснээс 2219 санал нь дэмжээгүй, 6245 санал нь хариулаагүй гэсэн ийм хариултауд ирсэн байна.

Танилцуулж дууслаа.

**С.Бямбацогт:** Занданшатар даргад баярлалаа. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд заасны дагуу Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэг эхэлснээс хойш эцэслэн батлах хүртэл хугацаанд ард иргэдийн, олон нийтийн байгууллагуудын, улс төрийн намуудын саналуудыг чөлөөтэй авахаар ингэж заасан байгаа. Үүний дагуу саналууд авагдах үйл ажиллагаа 6 сарын 06-наас эхэлсэн. Одоо ч гэсэн авагдаж байгаа, цаашдаа ч гэсэн хэлэлцэж, эцэслэн батлах хүртэл авах бололцоо нээлттэй байгаа.

7 сарын 01-ний байдлаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд 7795 иргэнээс 200 гаруй мянган санал ирсэн байгаа гэдгийг нэмээд хэлье. Цаашдаа иргэд маань саналаа өгөх нь нээлттэй байгаа, бүх саналыг авах бололцоо боломж нээлттэй гэдгийг хэлье.

Одоо та бүхэндээ ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын 68 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн ахлагчаар Энхтүвшин, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Л.Болд, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар, Д.Оюунхорол, Л.Оюун-Эрдэнэ, Я.Санжмятав, Г.Солтан, Д.Тогтохсүрэн, Д.Эрдэнэбат гэсэн 14 гишүүн ажлын үндсэн хэсгийн гишүүдээр ажиллаж байгаа.

Дэд ажлын хэсгээс хүрэлцэн ирсэн хүмүүсийг танилцуулъя. Дэд ажлын хэсгийн ахлагч Өлзийсайхан Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хүрэлцэн ирсэн байна. Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн ажлын дэд хэсгийг ахалж байгаа Хатанбаатар гуай Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан хүрэлцэн ирсэн байна. Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд хэсгийн ахлагч Лувсанжав Монгол Улсын гавьяат хуульч хүрэлцэн ирсэн байна. Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд хэсгийн ахлагч Мөнхсайхан Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор хүрэлцэн ирсэн байна. Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд хэсгийн ахлагч Товуусүрэн Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан хүрэлцэн ирсэн байна. Дээрээс нь шүүгч Цогт хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийг та бүхэнд танилцууллаа.

Одоо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх бусад Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонсоно.

Нэгдүгээрт нь, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд танилцуулна.

**Н.Энхболд:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2019 оны 6 дугаар сарын 14, 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24<sup>4</sup> дүгээр зүйлийн 24<sup>4.1</sup> дэх хэсэгт тус тус зааснаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2019 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцлээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд орж байгаа сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн болон татвар тогтоох эрхтэй байх тухай, сум, дүүргийн Засаг даргыг тухайн нутаг дэвсгэрийн иргэд дөрвөн жилийн хугацаагаар сонгож байгаа талаар, гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд орж байгаа төрийн албаны зарчим, төрийн албан хаагчийг чөлөөлөх, халахтай холбоотой зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Батболд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд нийгмийн зөвшилцлийг хэрхэн хангаж байгаа талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудалд хариуцлагатай хандах, санал хураалтын босгыг өндөр байлгах мөн цахим санал хураалт эрсдэлтэй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлийн 9<sup>1.2</sup>-т заасны дагуу Байнгын хорооны хуралдаан дээр ил санал хураалтыг гар өргөж шийдвэрлэхээр горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Б.Энх-Амгалан, Н.Оюундарь, А.Ундраа, Б.Бат-Эрдэнэ нар зарчмын зөрүүтэй санал гаргаж, саналын томъёолол, үндэслэл, шаардлагаа танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Аймаг, нийслэлийн Засаг даргыг аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлаас нэр дэвшүүлж Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нэр дэвшүүлж харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно.

3.Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргад нэр дэвшигчийг, аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлд заасан журмаар дахин нэг удаа нэр дэвшүүлж Ерөнхий сайд, харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус томилно.” гэсэн саналыг гаргаж, дараах үндэслэл, шаардлагыг танилцуулав.

Сум, дүүргийн Засаг даргыг иргэдээс сонгодог болсноор аймаг, нийслэлийн Засаг даргадаа захирагдахгүй болно. Түүнчлэн сум, дүүрэгт өмчийн болон татвар тогтоох эрхийг өгөх нь буруу гэлээ. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан саналын шаардлага, үндэслэлээ танилцуулсны дараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл дэх хувилбарыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураахад хуралдаанд оролцсон гишүүдийн 83 хувь, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн саналын томьёоллыг хуралдаанд оролцсон гишүүдийн 17 хувь нь тус тус дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу Дечин зургаадугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төрийн албан хаагчийг улс төрийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, сонгуулийн үр дүнгээр, эсхүл хуульд зааснаас бусад үндэслэлээр чөлөөлөх, халахыг хориглоно. Төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилтэд тавих хяналт хараат бус байна.” гэснийг хасах санал гаргаж, энэ нь нэгэнт Төрийн албаны тухай хуулиар нарийвчлан зохицуулдаг тул ингэж төрийн албан хаагчийг Үндсэн хуульд дархлаажуулж болохгүй гэсэн үндэслэлийг танилцуулав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл дэх хувилбарыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураахад хуралдаанд оролцсон гишүүдийн 92 хувь, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн саналын томьёоллыг хуралдаанд оролцсон гишүүдийн 8 хувь нь тус тус дэмжив.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “тогтолцоо, ” гэснийг хасах санал гаргаж дараах үндэслэл, шаардлагыг танилцуулав. Энэ нь Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2-т заасан Монгол Улсын иргэд шууд сонгох эрхийг зөрчих төдийгүй энэ талаар өмнө нь гарсан Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй зөрчилдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл дэх хувилбарт өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайханы гаргасан саналын томьёоллыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавин тав нас хүрсэн” гэснийг “тавин нас хүрсэн” гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасан. Тэрээр зарчмын зөрүүтэй саналын томьёоллын үндэслэлдээ жендерийн тэгш эрхийг

хангах, монгол хүний дундаж наслалт болон монголын хүн амын онцлог, дэлхийн нийтийн хандлагыг тус тус харгалзсан талаар танилцуулж, Монгол Улсын хүн амын дийлэнх хувийг залуучууд эзэлж байгааг анхаарах нь зүйтэй гэсэн тайлбар хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл дэх хувилбарыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураахад хуралдаанд оролцсон гишүүдийн 58 хувь, Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарийн саналын томъёоллыг хуралдаанд оролцсон гишүүдийн 42 хувь нь тус тус дэмжив. Аль ч саналын томъёолол хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын дэмжлэг аваагүй тул дахин санал хураалт явуулахад хоёр дахь санал хураалтаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл дэх хувилбарыг гишүүдийн 58 хувь, Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарийн саналыг 42 хувь нь дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа, Төслийн 3 дугаар зүйлийн 10 заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан,” гэснийг “Улсын дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан, анхан буюу давж заалдах шатны шүүхэд зургаагаас доошгүй жил ажилласан,” гэж өөрчлөх санал гаргаж, Улсын Дээд шүүхийн шүүгчээр ажиллахын тулд анхан болон давж заалдах шатны шүүхэд ажилласан туршлагатай байх шаардлагыг иргэдтэй уулзах үед тавьж байсныг дэмжиж байгаагаа танилцуулсан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл дэх хувилбарыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураахад хуралдаанд оролцсон гишүүдийн 82 хувь, Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн саналын томъёоллыг хуралдаанд оролцсон гишүүдийн 36 хувь нь тус тус дэмжсэн.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуульд нам эсхүл иргэн бие даан нэр дэвшүүлж оролцоно.” гэж нэмэх зарчмын зөрүүтэй саналыг гаргасан. Тэрээр Улсын Их Хурлын сонгуульд нам эсхүл иргэн бие даан нэр дэвшүүлж оролцоноор нам эвсэл болж сонгуульд оролцоод дараа нь тардаг байдал арилна. Өөрөөр хэлбэл төрийг тогтворгүй болгодог байсан алдаа, дутагдал арилна гэж тайлбарласан.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 45 хувь нь дэмжсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжиж, нэгдсэн хуралдаанаар төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг болон зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, дэмжээгүйгээр бүлэглэн Та хүргүүлж байна.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Энхболд гишүүнд баярлалаа. Одоо Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг танилцуулна. Саранчимэг гишүүний микрофоныг өгье.

**Б.Саранчимэг:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүнээс 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2019 оны 6 дугаар сарын 14, 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24<sup>4</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2019 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцлээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Сүхбат төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “эвсэл” гэдэг үг олон давтагдсан байгааг анхаарах, нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд сум, дүүргийн Засаг даргыг томилох, огцруулах зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуулийг зөрчсөн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд нийгмийн зөвшилцлийг хангах, ард нийтийн санал, асуулгыг зохион байгуулах, анхан шатны засаг захиргааны нэгжийн зохион байгуулалт, бүтцийг авч үзэх, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг дагаж ямар ямар хуульд өөрчлөлт орох, Улсын Их Хурлын гишүүн А.Сүхбат, Х.Болорчулуун нар төслийн 2 дугаар зүйл буюу Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн томъёолол ойлгомжгүй байгаа тул дахин нягтлах талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх үед зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 76,9 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,



Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Саранчимэг гишүүнд баярлалаа. Одоо Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Д.Оюунхорол танилцуулна.

**Д.Оюунхорол:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2019 оны 6 дугаар сарын 14, 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24<sup>4</sup> дүгээр зүйлийн 24<sup>4.1</sup> дэх хэсэгт тус тус заасны дагуу Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2019 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцлээ.

Хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ц.Мөнх-Оргил, Б.Саранчимэг нар хууль санаачлагчаас асуулт асууж, орон нутаг, тойргийн иргэдээс ирүүлсэн саналын талаар танилцуулав. Тухайлбал, нутаг дэвсгэрийн иргэдийн саналаар сонгогдсон сумын Засаг даргыг аймгийн Засаг дарга тодорхой шалтгаанаар чөлөөлөх асуудал гарч болзошгүй гэдэгт иргэд санаа зовж байгаа тухай Ё.Баатарбилэг гишүүн дуулгасан бол Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болохоор тусгасныг өөрчлөн тоог нь цөөлөх нь зүйтэй гэсэн саналыг иргэд олноор ирүүлсэн тухай, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг орон нутагт улс төржилтийг багасгах, сум, дүүргийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчийг улс төрийн шалтгаанаар халахгүй байхыг хуульчлах асуудлаар иргэдээс ирүүлсэн саналыг танилцуулж, тодорхой хариултыг авлаа.

Улсын Их Хурлын гишүүдээс төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулсан бөгөөд Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын 2019 оны 68 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ө.Энхтүвшин ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналуудын талаар товч мэдээлэл хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, С.Чинзориг, Н.Учрал нар зарчмын зөрүүтэй санал гаргаж, саналын томьёоллыг үндэслэн танилцууллаа.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил төслийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын нутгийн өөрийн удирдлагын үндсэн байгууллага нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал мөн.” гэснийг “Монгол Улсын нутгийн өөрөө удирдлагын үндсэн нэгж нь сум, дүүрэг байна.” гэж өөрчлөх санал нь хуралдаанд оролцсон гишүүдийн 84.6 хувиар, төслийн Хорин долоодугаар зүйлийн 6 дахь хэсгийн сүүлийн өгүүлбэрийн “олонхын саналаар батална” гэснийг “олонхын саналаар хуулийг бүхэлд нь эцэслэн батална” гэж өөрчлөх санал нь санал хураалтад оролцсон гишүүдийн 69.2 хувиар, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн төслийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “баримтална” гэснийг “баримтлах бөгөөд энэхүү зорилгоор баялгийн сантай байна. Сангийн хуримтлал бий болгох, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмыг хуулиар тогтооно” гэж өөрчлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар тус тус дэмжсэн.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилийн төслийн Дөчин есдүгээр зүйлийн 8 дахь хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүгчийн хариуцлагын зөвлөл ажлаа Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд тайлагнах бөгөөд тэдгээрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж өөрчлөн найруулах, төслийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийг “Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэж өөрчлөх, төслийн Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, төслийн Тавин долоодугаар зүйлийн 2 дахь хэсэг, төслийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Засгийн газрын гишүүд” гэснийг тус тус хасах, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг төслийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхийлөгчөөр тавин таван нас” гэснийг “Ерөнхийлөгчөөр тавин нас” гэж, төслийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь” гэснийг “Улсын Их Хурлын гишүүдийн олонх нь эсвэл 29 гишүүн нь” гэж тус тус өөрчлөх, төслийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн “баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно.” гэснийг “багийн Засаг даргыг харьяалах сумын Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаатайгаар томилж, баг, хорооны Засаг даргыг харьяалах хорооны иргэд дөрвөн жилийн хугацаатайгаар сонгоно.” гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал төслийн Дөчин зургаадугаар зүйлийн 4 дэх хэсгийн “шатлан дэвших” гэснийг хасах, төслийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийг шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан” гэснийг “давж заалдах шатны шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан” гэж өөрчлөх саналуудыг гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжээгүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжиж, нэгдсэн хуралдаанаар төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, дэмжээгүйгээр бүлэглэн хүргүүлж байна.

Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Оюунхорол гишүүнд баярлалаа. Одоо Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулна.

**Д.Тогтохсүрэн:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүнээс 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2019 оны 6 дугаар сарын 14, 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24<sup>4</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар Өргөдлийн байнгын хороо 2019 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт аваагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдэд төслийг танилцуулах үеэр иргэдээс жендерийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулах санал гаргасан тул төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавин таван нас” гэснийг “тавин нас” гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 88,9 хувийн саналаар дэмжсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Тогтохсүрэн гишүүнд баярлалаа. Одоо Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн танилцуулна.

**Д.Тогтохсүрэн:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүнээс 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2019 оны 6 дугаар сарын 14, 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24<sup>1</sup> дэх хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хороо 2019 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд Хянан шалгах түр хороо байгуулах, нам иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах, төрийн жинхэнэ алба нь шатлан дэвших зарчимд үндэслэх асуудлыг төсөлд тусгах шаардлагатай эсэх, Улсын Дээд шүүхийн шүүгчид анхан болон давж заалдах шатны шүүгчээс өөр шалгуур тавьсан асуудлаар, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 10 гишүүний санал тэнцсэн тохиолдолд хэрхэн асуудлыг шийдвэрлэх, Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн гишүүдийг хэн санал болгох, тус Зөвлөлд шүүгчийг чөлөөлөх бүрэн эрх олгосон асуудал нь зөв эсэх, Үндсэн Хуулийн Цэцийн гишүүнд тавигдах шаардлагаас улс төрч байх шалгуурыг хассан шалтгаан, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтолцоо, улсын болон орон нутгийн харьяалалтай хот, тосгоны талаар, сум, дүүргийн Засаг даргыг огцруулахтай холбоотой асуудлаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн төсөлд иргэдийн өдөр тутмын амьдралд холбоотой асуудлыг тусгасан эсэх, баг, хорооны Засаг даргыг иргэдээс сонгодог болох талаар, Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болох талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Үндсэн хуулиар зохицуулсан хүний эрх, үүргийн харилцан хамаарал, түүнтэй холбоотой судалгааны талаар, Үндсэн хуульд хөгжлийн бодлого төлөвлөлт, салбар хоорондын уялдааг хангах асуудлыг тусгах талаар, Үндсэн хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ц.Даваасүрэн, Ч.Улаан, Г.Тэмүүлэн, О.Батнасан нар зарчмын зөрүүтэй санал гаргасан бөгөөд зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураахдаа төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр хамтатган санал хураасан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Төслийн “Нам иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна” гэсэн арван ес<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг хасах санал гаргаж, түүнийхээ үндэслэлийг тайлбарлан үг хэлж санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Улаан нар, Төслийн 2 дугаар зүйл буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төрөөс байгалийн баялгийг ашиглахдаа тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах зарчмыг баримтална.” гэсэн хоёр дахь өгүүлбэр нэмэх гэсний дараа “Стратегийн ордын 51-ээс доошгүй хувь нь ард түмний мэдэлд байж, төр эзэмшинэ.” гэсэн өгүүлбэр нэмэх санал гаргаж, түүнийхээ үндэслэлийг тайлбарлан үг хэлж санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Г.Тэмүүлэн, Төслийн “Хянан шалгах түр хороо нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу мэргэжлийн, хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй. Түр хороо дүгнэлт гаргаж, шаардлагатай бол тухайн асуудлыг эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлж болно. Түр хорооны дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй. Хорооны хэлэлцсэн баримтыг нотлох баримтад тооцох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.” гэсэн Хорин наймдугаар зүйлийн 3 дахь хэсгийг хасах санал гаргаж, түүнийхээ үндэслэлийг тайлбарлан үг хэлж санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Төслийн “Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүний давхар албан тушаалыг хавсарч болно.” гэж өөрчлөх санал гаргаж, түүнийхээ үндэслэлийг тайлбарлан үг хэлж, санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан, Ш.Раднаасэд, Төслийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн гуравны хоёр нь шүүн таслах ажлын туршлагатай байна” гэсэн 3 дахь өгүүлбэр нэмэх санал гаргаж, түүнийхээ үндэслэлийг тайлбарлан үг хэлж саналаа татаж авсан тул Байнгын хорооны хуралдаанаар санал хураалгаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Төслийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн “баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус

тус” гэснийг хасах санал гаргаж, түүнийхээ үндэслэлийг тайлбарлан үг хэлж санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 81.8 хувийн саналаар буюу гуравны хоёроос доошгүй нь дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Одоо Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил танилцуулна.

**Ц.Мөнх-Оргил:** Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүнээс 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2019 оны 6 дугаар сарын 14, 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24<sup>4</sup> дүгээр зүйлийн 24<sup>4.1</sup> дэх хэсэгт тус тус зааснаар Хууль зүйн байнгын хороо 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд шүүгчийг хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах, чөлөөлөх шийдвэрийг гаргах эрх бүхий Шүүгчийн хариуцлагын зөвлөлд иргэд болон хууль зүйн эрдэмтдийн төлөөлөл орохоор төсөлд тусгасан байх бөгөөд эдгээр нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль зүйн үндэслэлтэй хянаж чадах эсэх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүгчийн хариуцлагын зөвлөлд ажиллах гишүүд орон тооны, эсхүл орон тооны бус байх талаар болон улс орны тусгаар тогтнол, ард иргэдийн эв нэгдлийг хангах зохицуулалт туссан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Л.Болд шүүх бие даасан, хараат бусаар ажиллах, ард түмний язгуур эрх, ашгийг хамгаалах талаар зохицуулалт туссан эсэх, улс төрийн намын зохион байгуулалт, хөрөнгө, орлогын зарцуулалт, санхүүжилт ил тод байх талаар,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар эдийн засгийн харилцааг дэмжихтэй холбоотой заалт төсөлд туссан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг төлөвшүүлэх зорилгоор Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хязгаарлах нь зөв эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Улсын Их Хурал, Засгийн газрын хоорондын харилцан хяналт-тэнцэл, Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болох шалтгаан үндэслэлийн талаар, мөн шүүхийн үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, хариуцлагыг нэмэгдүүлэх талаар, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн ажлын уялдаа холбооны талаар төсөлд туссан эсэх талаар хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан, Ж.Батзандан, Л.Болд, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Н.Оюундарь, Ш.Раднаасэд нар зарчмын зөрүүтэй санал гаргасан бөгөөд зарчмын санал хураахдаа төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр төсөл болон зарчмын зөрүүтэй саналыг хамтатган хураалгасан болно.

**Нэг.Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд:**

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтыг төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах. Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын нийт дүнг Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр нэмэгдүүлэхгүй. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно, эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах. Хөгжлийн бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг хангах, тогтвортой байдалд тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж өөрчлөн найруулах санал гаргаж, саналын үндэслэлээ тайлбарлан үг хэлж санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг нам нь улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэн сайн дураараа эвлэлдэн нэгдсэн иргэдийн нэгдэл юм гэж өөрчлөн найруулах, төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нийт гишүүний олонхын саналаар” гэж нэмэх, төслийн 2 дугаар зүйлийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр зардлын шинэ төрөл үүсгэж, зарлага нэмэгдүүлэхгүй” гэснийг хасах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Л.Болд нар төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес<sup>1</sup> дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Намын зохион байгуулалт нь хатуу гишүүнчлэлгүй байх бөгөөд зөвхөн дэмжигчид дээр суурилж, иргэдэд шударга, тэгш үйлчилж, ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд суурилж үйл ажиллагаа явуулна” гэж нэмэх, төслийн 2 дугаар зүйл буюу Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт

“Баялагийн сан байгуулж, стратегийн ордын тавин нэгээс доошгүй хувийг ард түмэнд өмчлүүлнэ” гэсэн 3 дахь өгүүлбэр нэмэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар төслийн 4 дүгээр зүйлийн “Хорин долоодугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавиас доошгүй” гэснийг “далан таваас доошгүй” гэж,” гэснийг хасах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долоодугаар зүйлийн 6 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг “Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хуулийг бүхэлд нь эцэслэн батална” гэж өөрчлөн найруулах, төслийн 4 дүгээр зүйлийн “Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Засгийн газрын” гэснийг хасах саналыг тус тус гаргаж, гишүүд гаргасан саналын үндэслэлээ тайлбарлан үг хэлж санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй болно.

**Хоёр.Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд:**

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу Дөчин зургаадугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төрийн албаны” гэснийг “Төрийн жинхэнэ албаны” гэж өөрчлөх, төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “энэ зүйлд” гэснийг “Үндсэн хуульд” гэж өөрчлөх, төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “өөрөө” гэснийг “шууд” гэж өөрчлөх, төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “гурав хоногийн дараа” гэснийг “дөрөв хоногийн дотор” гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн Ерөнхийлөгчийн тавин таван насыг тавин нас гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийг “Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг тус тус гаргаж, гишүүд гаргасан саналын үндэслэлээ тайлбарлан үг хэлж санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй болно.

**Гурав.Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд:**

Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтын “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо” гэснийг “Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүдийн гурвыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо” гэж өөрчлөх, 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн гуравны хоёр нь шүүн таслах ажлын туршлагатай байна гэж нэмэх гэсэн санал гаргаж, саналын үндэслэлээ тайлбарлан үг хэлж санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан, С.Бямбацогт нар төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “бүрдэнэ” гэснийг “бүрдэх бөгөөд ажлаа Улсын дээд шүүхэд танилцуулна.” гэж өөрчлөх,



Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Л.Болд нар төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “хууль зүйн эрдэмтэн” гэсний өмнө “улс төрийн намын харьяалалгүй” гэж, “иргэдийн төлөөлөл” гэсний өмнө “сүүлийн арван жил улс төрийн намын харьяалалгүй байсан” гэж тус тус нэмэх, төслийн 1 дүгээр зүйлтийн 7 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 5 дахь хэсгийг Ерөнхий шүүгчийг Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёрын саналаар томилох.

Улсын Дээд Шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн дотроос нийт шүүгчдийн олонхын саналаар гурван жилийн хугацаагаар сонгоно. Ерөнхий шүүгчийг тухайн шүүхэд нэг удаа улируулан сонгож болно гэж өөрчлөн найруулах, төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтын шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд хууль зүйн өндөр мэргэжилтэй байхаар өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 7 дахь хэсгийг Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн гишүүдийн гурвыг мэргэжлийн холбоо, гурвыг шүүн таслах ажлын туршлагатай хуульчид дотроосоо, гурвыг Улсын Их Хурлаас бүрдүүлнэ гэж өөрчлөн найруулах, төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын “арван гишүүнээс бүрдэнэ” гэснийг “арван таван гишүүнээс бүрдэнэ” гэж өөрчлөх, төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хуульчийн мэргэжлээр арван таван жил ажилласан” гэснийг “давж заалдах шатны шүүхэд арваас доошгүй жил ажилласан” гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хорин нэгэн” гэснийг хасах, 2 дахь хэсгийн “томилох” гэснийг “томилуулах” гэж, “сонсголд оруулж” гэснийг “сонсгол хийж” гэж өөрчлөх, 3 дахь хэсгийн “хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан” гэснийг “арваас доошгүй жил шүүгчээр ажилласан” гэж өөрчилж, “арван хоёр жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа” гэснийг хасах, төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “есөн жилийн хугацаатай” гэснийг “есөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа” гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 8 дахь хэсгийг Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүгчийн хариуцлагын зөвлөл ажлаа Улсын дээд шүүхэд тайлагнана гэж өөрчлөн найруулах саналыг тус тус гаргаж, гишүүд гаргасан саналын үндэслэлээ тайлбарлан үг хэлж санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй болно.

**Дөрөв.Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд:**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Л.Болд нар төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу Жаран тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “сүүлийн арван жил улс төрийн намын харьяалалтай байгаагүй” гэж нэмэх, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалт буюу Жардугаар зүйлийн 3 дахь хэсгийн “даргын сонгуулийн журмыг” гэснийг “даргыг сонгох журмыг” гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долоодугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасах, 12 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эхний өгүүлбэрийг “Монгол Улсын нутгийн өөрийн удирдлагын үндсэн нэгж нь сум,

дүүрэг мөн." гэж өөрчлөн найруулах саналыг тус тус гаргаж, гишүүд гаргасан саналын үндэслэлээ тайлбарлан үг хэлж санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 70 хувийн саналаар дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Мөнх-Оргил гишүүнд баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр танилцуулна.

**Б.Баттөмөр:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн Улсын Их Хуралд 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2019 оны 6 дугаар сарын 14, 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24<sup>4</sup> дүгээр зүйлийн 24<sup>4.1</sup> дэх хэсэгт тус тус заасны дагуу Эдийн засгийн байнгын хороо төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлсон, аль ч Засгийн газар, Их Хурал нь хэрэгжүүлдэг урт, дунд хугацааны бодлоготой байх талаар төсөлд тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан улсын статустай хотын эрх хэмжээ, бүтэц, баг, хорооны Засаг даргын томилгооны талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Дамба-Очир улсын болон аймгийн зэрэглэлтэй хот, тосгон, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Д.Тэрбишдагва нар урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотой заалт төсөлд нэмж тусгах талаар, гишүүн Ж.Ганбаатар эдийн засгийн харилцааг дэмжих заалт оруулж болох эсэх, гишүүн М.Оюунчимэг эдийн засгийн бодлогыг дэмжсэн, түүнийг хариуцах байгууллагын

талаарх зохицуулалтыг төсөлд нэмж тусгах талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Б.Жавхлан, Ж.Ганбаатар, М.Оюунчимэг, Д.Дамба-Очир, Б.Ундармаа нар зарчмын зөрүүтэй санал гаргаж, саналын томьёолол, үндэслэл, шаардлагаа танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар: Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын буюу Арван ес<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “илэрхийлж,” гэсний дараа “улс орны нийтлэг эрх ашиг, үндэсний аюулгүй байдлыг дээдлэн, Үндсэн хуулийн хүрээнд” гэж нэмэх гэсэн зарчмын зөрүүтэй саналыг гаргаж, дараах үндэслэл, шаардлагыг танилцуулав.

Монгол Улс улс төрийн намын чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагааны зарчмыг анх удаа үндсэн хуульдаа тусгаж байна. Улс төрийн нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлээд зогсохгүй улс орны нийтлэг эрх ашгийг дээдэлж, үндэсний аюулгүй байдлыг хангаж, Үндсэн хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах ёстой. Улсын хэмжээнд янз бүрийн чиг зорилготой, шашны болон олон улсад хориглодог үзэл санааг дэмжсэн намууд гарч байгаа нь үндэсний эрх ашиг, эв нэгдлийг дээдлэх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах шаардлагыг бий болгож байна гэж үзжээ.

Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатарын гаргасан саналын томьёоллоор хоёр удаа санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 81.8 хувь нь тус тус дэмжив.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ: Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг буюу Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хуулиар тогтооно” гэсний дараа “Улсын Их Хурлын сонгуульд нам, эсхүл иргэн бие даан нэр дэвшүүлж оролцоно.” гэж нэмэх санал гаргасан.

Намын хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх, намын төлөвшлийг хангах, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалдаг улс төрийн намтай байх асуудал нь жижиг намууд сонгуульд бие даан оролцож, ард түмний өмнө үүрэг, хариуцлага хүлээдэг байхаас эхэлнэ гэж үндэслэлийг танилцуулсан.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн саналыг санал хураалтад оролцсон гишүүдийн 83.3 хувь нь дэмжив.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Д.Дамба-Очир, Б.Жавхлан, М.Оюунчимэг, Д.Тэрбишдагва, Б.Ундармаа, Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “батлах” гэсний дараа “Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ. Энэхүү бодлого, төлөвлөлтийг тогтвортой залгамж чанартай хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллагатай байна.” гэж нэмэх санал гаргасан.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан саналын үндэслэлийг тайлбарлахдаа Улсын Их Хурлын гишүүд Засгийн газраас оруулж ирсэн төсвийг дураараа өөрчилж, нэмдэг зохицуулалтыг хязгаарлахад төлөвлөлт чухал байгааг, гишүүн Б.Баттөмөр төрийн бодлого зохицуулалт, төлөвлөлт улс орны

хөгжилд чухал шаардлагатайг, гишүүн Ж.Бат-Эрдэнэ манай улсад эдийн засаг, нийгмийг урт, дунд хугацаанд хөгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлт алдагдсанаас бодлогын залгамж чанар муудаж, хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байгаа үндэслэлүүдийг танилцуулсан.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Д.Дамба-Очир, Б.Жавхлан, М.Оюунчимэг, Д.Тэрбишдагва, Б.Ундармаа нарын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “бодлого” гэснийг “дунд, урт хугацааны бодлого” гэж өөрчлөх санал гаргалаа. Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр эдийн засгийн хямрал, ажилгүйдлийг зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр зохицуулах боломжгүй, төрийн бодлого, төлөвлөлт зайлшгүй шаардлагатай тухай, гишүүн Ж.Бат-Эрдэнэ бодлогоо урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлж, түүнийг дагаж нийгэм, эдийн засаг хөгждөг, сонгуулийн амлалтын дагуу бодлого өөрчлөгддөг байдлыг болиулах шаардлагатайг тодруулж тайлбарлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ нарын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 58.3 хувь нь дэмжив.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 2 дугаар зүйлийн буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “бодлого” гэснийг “бодлого, төлөвлөлт” гэж өөрчлөх санал гаргаж, бодлого гэдэгт дунд, урт хугацааны буюу 15-20 жилийн дараах бидний хүрэх бүх зорилгыг нэгтгээд хэлж байна, харин төлөвлөлт нь салбар бүртээ ямар арга замаар уг бодлогод хүрэхийг ойлгоно гэж тайлбарлав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 58.3 хувь нь дэмжив.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 4 дүгээр зүйлийн “Хорин долоодугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавиас доошгүй” гэснийг “далан таваас доошгүй” гэж,” гэснийг хасах санал гаргаж, Монгол Улсад хууль хангалттай байгаа, хуралдаан их байх тусам ажил сайн байна гэсэн ойлголт буруу юм. Чуулганы үргэлжлэх хугацаа 50-аас доошгүй гэдэгт ажлын 75, 80 өдөр мөн багтах тул Үндсэн хуульд энэ өөрчлөлтийг оруулах шаардлагагүй гэж үзэж байна. Олон хууль санаачлах нь сайн гэсэн үг биш, хууль нь ард түмний амьдралд хэрэг болох нь чухал гэсэн үндэслэлээр уг саналыг гаргаж байгаагаа танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын саналын томъёоллоор гурван удаа санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 50 хувь, 75 хувь, 33.3 хувь нь тус тус дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Я.Содбаатар, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “батлах” гэсний дараа “Эдийн

засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, хөгжлийн бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг хангах байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар хөгжлийн бодлогоо тодорхойлох, төлөвлөлт хийх, нэгдсэн удирдлагаар хангах, эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогоо авч явах байгууллагын талаар Үндсэн хуульд тусгах шаардлагатай гэсэн гишүүдийн саналын дагуу ийнхүү ерөнхий байдлаар томъёолсон тухайгаа танилцууллаа.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Я.Содбаатар нарын саналын томъёоллоор хоёр удаа санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 36.4 хувь, 63.6 хувь нь тус тус дэмжсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн 72.7 хувийн саналаар дэмжиж, нэгдсэн хуралдаанаар төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн Та бүхэнд тараасан.

Байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураан шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Баттөмөр гишүүнд баярлалаа. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос бусад долоон Байнгын хорооны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэнтэй холбоотой санал, дүгнэлтүүдийг сонслоо. Байнгын хороо санал, дүгнэлтээ бэлтгэхдээ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх мэдээлэл, мөн зарчмын зөрүүтэй саналын томъёолол, үндэслэл, шаардлагыг нэг бүрчлэн тусгах, санал хураалтын дүнг нэг бүрчлэн тусгах гээд одоо ийм тусгай дэгтэй байдаг учраас нэлээн уртхан танилцуулга хийгдлээ.

Одоо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Гурван гишүүн нэрс өгсөн байна. 13 цаг 40 минут болж байна. Үдийн цайны завсарлага хийгээд, 15 цагаас хууль санаачлагчаас асуух асуултаа асуугаад, хуралдаанаа үргэлжлүүлье. Түр завсарлага.

ЗАВСАРЛАГА

**С.Бямбацогт:** Гишүүдийг Байнгын хорооны хуралдаанд орж ирэхийг урьж байна. 15 цаг өнгөрч байна. Хуралдаанаа үргэлжлүүлье. Манай ажлын хэсгийнхэн гишүүдээ дуудаарай. Асуулт тавих гишүүд Содбилэг, Батзандан, Мөнх-Оргил гишүүн ирээгүй байна. Түрүүн Байнгын хороодын санал, дүгнэлтийг танилцуулж дууссан. Одоо Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулж хууль санаачлагчаас гишүүд асуултаа асууж хариултаа авна. Содбилэг гишүүн асуултаа асууя.

**О.Содбилэг:** Гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Би Үндсэн хуулийн төслийн ажлын хэсэгт Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хотоор тооцож түүний эрх зүйн байдлыг нь Улаанбаатар хоттой адилтгах байдлаар томьёолж Үндсэн хуульд тусгах нь зүйтэй гэж саналаа хэлсэн. Ямар учиртай юм бэ гэхээр яг Улаанбаатар хот шиг хоттой ижил хот, дүүрэг, хороогоор ингэж захирагдаж явдаг өөрийн гэсэн захиргаатай, өөрийн гэсэн газар нутагтай. Тэгээд өөрийн гэсэн төсөв бүрдүүлдэг ийм субъект болгож яг л хот шиг хот болгоё гэж манай Эрдэнэтийнхний олон жил ярьж байгаа зүйлийг энэ төсөлд тусгах гээд болж өгөхгүй байна л даа.

Эрдэнэт хот байгуулагдсан цагаасаа хойш мөн 1992 оны шинэ Үндсэн хууль хүртэл ер нь яг л Эрдэнэт хот гэж нэрлэгдэж хот шиг зохион байгуулалттай ингэж явж ирсэн. Тэрийг манай иргэд бүгд сайн мэдэж байгаа. Монголчууд өнөөдрийг хүртэл Эрдэнэтийг Эрдэнэт хот гэж мэддэг болохоос биш Орхон аймгийн Баян-Өндөр сум гэж хэлдэггүй ээ.

Би Эрдэнэт явлаа, манай хамаатан Эрдэнэтэд амьдардаг, би Эрдэнэтэд төрсөн, би Эрдэнэтийн вагонд суугаад явж байна ч гэдэг юм уу, дандаа тэгж л ярьдаг. Тэгэхээр энэ 3 сая хүн энэ Эрдэнэт хотоо хот гээд бүр сэтгэл санаандаа хүлээн зөвшөөрчихсөн, тэгээд энэ нь өөрөө яг хот шиг хот амьдралаар амьдрах гээд энэ иргэд нь хүслээ сая хэлэлцүүлгийн үед уулзсан бүх иргэд энэ саналаа хэлсэн.

Ингээд ийм болгоё гээд байхаар төслийн хүрээнд хангалттай ороогүй байна гэж би бодоод байна. Манай гишүүд хүртэл Содбилэг ээ, тэр Украины Ерөнхийлөгч болсон Зеленский хүртэл танай Эрдэнэт хотод амьдарч байсан юм байна гээд, Эрдэнэт хот гэдэг нэрээр нь яриад байгаа байхгүй юу. Бүгд тэрийг Эрдэнэт хот гэж хэлж нэршиж сурчихсан мөртлөө Эрдэнэтийн амьдарч байгаа хүмүүсийнх нь хүслийг нь хүртэл энд уламжлаад байхад Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн энэ томьёололдоо сайн оруулаагүй байна. Миний дээр дурдсан саналыг ажлын хэсэг аваагүй байна.

Ийм учраас би аргагүйн эрхэнд ингээд өөрийн анхны өгсөн томьёоллоосоо татгалзаж Эрдэнэт хотыг нэрээр нь заахаа больё, харин одоогийн байгаа эрх зүйн статусыг нь жаахан өргөж аймгаас арай дээгүүр, нийслэлээс арай доогуур улсын чанартай ийм, заавал Монгол Улсын бие даасан нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж байхаар бодож энэ томьёоллоо өнөөдрийн Байнгын хорооны гишүүдэд би тараасан байгаа. Та бүгд бас энийг дэмжээч ээ гэж хүсэж байна. Ингэснээрээ 57.1-тэйгээ зөрчилдөхгүй, 57.2 дээрээ өнөөдрийн байгаа 100 мянган хүнтэй Эрдэнэт, Дархан хотууд бас тодорхой статустай болох ийм боломж нээгдэж байгаа юм гэдгийг бас хэлмээр байна.

Одоо байгаа энэ томьёолол нь чухам яаж бий болсон юм бэ гэхээр их олон цаг, өдөр хуралдаж бий болсон гэж тайлбар яваад байгаа. Тэгэхдээ хэрвээ энэ улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгон нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэг, бүрэн эрхийг олгох бөгөөд уг асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж энэн доор Эрдэнэтийн оруулах юм бол өнөөдрийн аймгийн статустай байгаа нь ч байхгүй болоод бид нарын Эрдэнэтийнхний хүсээд байгаа хот байгаа нь ч биш болоод аль ч үгүй болох гээд байна шүү. Энийг одоо яаж тайлбарлах юм бэ?

Статус нь аль ч үгүй болоод бүр дордохоор байгаад байна. Тэгэхээр одоо Их Хурлын хууль тогтоох зарчмын алтан дүрэм байгаа, дордуулж болохгүй гэдэг ийм дүрэм байгаа шүү дээ. Энийгээ зөрчөөд байгаа юм гарах гээд байна. Ингэж болохгүй учраас Эрдэнэт хотын ард иргэд энэ одоогийн байгаа томьёоллыг хүлээн зөвшөөрөхгүй гэж би хэлээд байна.

Бид нар хэлэлцүүлэг, уулзалт хийгээд явж байхад уулзсан манай Орхон аймгийн, өнөөдрийн Эрдэнэтийнхэн бүгд Эрдэнэт хотоо хот болгоё, хот шиг хот болгоё гэдэг дээр 100 хувь санал нэгтэй надад үүрэг даалгавар болгож энэ төсөлд оруулаарай гэж явуулсан юм. Тийм учраас би ингээд хэлээд байна. Ажлын хэсэгт нь орж ажиллаж саналуудаа өглөө. Орсонгүй. Манай тойргоос иргэдийн өгсөн саналыг бас оруулах гэж өчигдрийн ажлын хэсгийн хуралд суулаа. Орсонгүй ээ. Энэ байгаа томьёоллоороо явахгүй шүү гэдгийг бас хэлмээр байна. Тэгэхээр ямар гаргалгаа яаж хийгдэх юм бэ гэж асуумаар байна.

**С.Бямбацогт:** Содбилэг гишүүний асуултад хууль санаачлагч, Их Хурлын гишүүн Лүндээжанцан хариулна.

**Д.Лүндээжанцан:** Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Манай Содбилэг гишүүн Улсын Их Хурлын чуулган дээр нэгдүгээр хэлэлцүүлгийн үед мөн энэ асуудлаа тавьсан. Өмнө нь бас Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дээр тавьсан.

Бид бол Улаанбаатар, Дархан, Эрдэнэт гэж ийм гурван хотыг нэр зааж оруулахаар төсөл явж байсан. Гэтэл дараа нь дахиад шинэ хот гараад ирвэл энэ чинь өнөө, маргаашийн хууль биш 30, 40 жил үйлчлэх хууль учраас нэрээр шууд зааж оруулах нь зохимжгүй юм. Гадаад орнуудад ч гэсэн нэр заахыг зарчмыг нь оруулаад хот байна, энэнд нь, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг чиг үүрэг, бүрэн эрхийг эдлүүлэхийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийддэг байя. Үндсэн хуульд бол засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулах, өөрчлөх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийднэ гээд Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд цагаан дээр хараар ингээд бичээд заачихсан байж байгаа.

Цаашдаа улсын хэмжээний хот гараад ирвэл тухайлбал, Улаанбаатар хот дотроо, Улаанбаатар гэдэг үг бол зөвхөн үгнээс цаашгүй байгаа юм. Монгол Улсын нийслэл бол Улаанбаатар хот мөн гэдэг үг л байгаа болохоос биш яг Дархан, Эрдэнэттэй адилхан Улаанбаатарынхан бас хот гэдэг юмыг нэхээд байгаа байхгүй юу. Хотын өөрийн удирдлага, чиг үүрэг, зохион байгуулалтын

зарчмыг нэхэж байгаа юм. Ийм учраас Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль гараад ямар ч амь орсонгүй ээ, энэ хугацаанд.

Ийм учраас нэр заахаа больё. Жишээлбэл, Улаанбаатар хотод Баянзүрх, Сонгинохайрхан хот гарч болж болно шүү дээ. Ийм, ийм үндэслэлүүд байна. Дээр нь Чойбалсан ч байдаг юм уу, Өмнөговь аймагт яваандаа хот босож магадгүй гэж яриад байгаа. Босох, босохгүй нь бүү мэд. Ямар ч байсан том хотууд бий болно. Тэгэхээр холбооны улсуудад хотыг засаг захиргааны нэгж гэж томьёолсон зүйлүүд байна. Жишээ нь ОХУ-д Москва, Санкт-Петербург, Севастопол гээд. Германд болоод ирэхээр Хамбург, Бремен, Берлин гээд ингээд заачихсан тохиолдлууд байна. Америкт бол Вашингтон DC-гээ болохоор Колумбын тойрог гээд төлөөлөгчдийнхөө танхим дотор нэмэлт нэг илүү суудал төлөөлөгчдийн танхимдаа хуваарилдаг тийм зохицуулалтууд байна.

Ингээд үзэхээр манай нэгдмэл улсад хотыг бол нэр зааж оруулах нь зохимжгүй юм гэж манай судлаачид, ажлын хэсгийнхэн их ярьсан. Дархан, Эрдэнэт хоёрыгоо нүд үзүүрлэдэг тийм юм байхгүй гэдгийг харин би энийг албан ёсоор хэлчихье. Өөрөөр хэлбэл, Монголд хотжих процесс явагдаж бидний нүдэн дээр Монгол Улсын бүтээн байгуулалтад болж гарч ирсэн энэ хоёр хот бол цаашдаа хотынх нь статусыг нь өгье. Тийм ч учраас улсын хэмжээний болон орон нутгийн зэрэглэлтэй хот байя. Тэр дотроо Дархан, Эрдэнэт хоёр бол улсын зэрэглэлтэй хот байх болно.

Түүний өөрийн удирдлага гэдэг үгийг оруулж өгч байна. Хот бол өөрийн удирдлагатай байх ёстой, хотын чиг үүрэгтэй байх ёстой. Мөн засаг захиргаа, нутаг дэвсгэрийнх нь зарчмыг тэр эрхийг шилжүүлж Засгийн газрын өргөн мэдүүлснээр Их Хурал тогтоохоор нээж өгч байна. Энийг манайхан ойлгож байгаа байх аа гэж бодож байна. Би ялангуяа Дархан, Эрдэнэтээс сонгогдсон Их Хурлын гишүүд энийг сайн ойлгох байх.

Энэ нэмэлт, өөрчлөлт батлагдсаны дараа бараг энэ заалтыг хэрэгжүүлэх анхны Засгийн газрын өргөн мэдүүлэх төсөл бол Дархан, Эрдэнэт хотыг улсын хэмжээний зэрэглэлтэй хот мөн, түүнд тийм, тийм эрхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бүрэн эрхийг олгоно гэдэг энэ тогтоолын төсөл Их Хурлаар орж ирж хэлэлцэгдэх ёстой. Түүний дараагаар бас хүмүүс хүлээж байгаа. Олон аймгийн төвүүд бас орон нутгийн зэрэглэлтэй хот болохоор хүлээж байгаа асуудлууд байна.

Тухайлбал, Багануур, Налайх ч гэдэг юм уу. Эдгээр нь дараагийн ээлжинд орж ирнэ. Түүний дараа том тосгонуудын асуудал орж ирэх ёстой. Өөрөөр хэлбэл тосгоны эрх зүйн байдлыг бас 20 гаруй тосгоны асуудал байгаа. Ингээд орж ирэх юм. Яагаад ингэж заачихсан байхад орж ирэх ямар ч найдлагагүй гээд, боломжгүй болчихлоо гэж ингэж сэтгэл гутралын байдлаар асуудалд хандаж болохгүй.

Энэ протоколд үлдэж байгаа. Органик хуулиараа бүх юм зохицуулагдана. Тэгэхээр өөрийн бодол өөртөө зөв. Өөрийн чинь бодол байж болно, бас хатгаас, янз бүрийн хүмүүс энэ талаасаа байж болно. Бид өнөөдөр энэ заалтыг оруулахгүй, гаргахгүй бол харин 1992 оноос хойш үргэлжилж байгаа хот, тосгоны эрх зүйн байдлын асуудалд ямар ч өөрчлөлт орохгүй үлдэх гээд байгаа юм.



Аймаг, нийслэлтэй адилхан хотыг засаг захиргааны нэгж болгоод явах гэхээр тэр 24 зүйлд өөрчлөлт орох болоод байгаа хот гэдгийг урд талд нь оруулахаар 9 зүйл нэмэгдэж орох гээд ингээд манай 35 хувь давчгаад болохгүй болчихоод ийм байдалд орсон. Энэ байдлаараа явъя гэж.

Хэрвээ энд орохгүй бол аль ч үгүй болоод бахь байдгаараа үлдэж хоцрох учраас би бол ямар ч байсан 100 хувийн дэмжлэг байхгүй байлаа гэхэд, бидний зорилгод хүрээгүй байхад энэ бол 70 хувьтай байгаа гэдгийг би баттай хэлж чадна.

Дараагийн нэг асуудал юу байна вэ гэхээр энд нийслэлтэй адилхан байна гэж яриад байгаа юм. Улаанбаатар хотынхон бол бас сэтгэл дундуур. Хот гэдэг юмыг оруулаад өгөөч ээ, нийслэл Улаанбаатар хот мөн гэсэн болохоос биш хотын эрх зүйн байдал, өөрийн удирдлагын юм тусаагүй. Тийм учраас Улаанбаатарын бас хүлээж байгаа юм нь энэ. Яг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт гурав бол адилхан Монгол Улсын одоогийн улсын хэмжээний гурван хот нь учраас Улаанбаатарт давуу юм олгосон юм ерөөсөө байдаггүй.

Нийслэлийн эрх зүйн байдлыг хуулиар зохицуулна гэсэн ганц юм байдаг. Тэгтэл нийслэл нь болохоор засаг захиргааны нэгжийн л асуудал байгаа болохоос биш. Тэгээд энд нь төрийн дээд байгууллагууд байнга оршдог газрыг нийслэл гэнэ гэж. Ер нь нийслэл нь Улаанбаатар гэдэг нэртэй байхаас арга алга байна. Тэр нь Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Баянгол, Хан-Уул дүүрэг дөрөв нийлээд Улаанбаатар хот болдог юм уу. Ийм асуудлууд гарахыг бас үгүйсгэхгүй байгаа юм.

Баянзүрх, Сонгинохайрхан нь улсын зэрэглэлтэй хот. Багануур, Налайх нь орон нутгийн зэрэглэлтэй гэсэн ийм зүйлүүд рүү алсдаа явахаар л бид органик хууль дээр нь Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль болон Нутгийн удирдлагын хууль болоод энэ дагуу Засгийн газраас Их Хуралд өргөн мэдүүлж орж ирнэ.

Энд ямар ч найдлагагүй боллоо гээд байдаг. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулчихсан байхад Дархан, Эрдэнэт хоёрыг оруулахгүй өөр.

**С.Бямбацогт:** Содбилэг гишүүн тодруулъя. Нэмэлт 2 минут.

**О.Содбилэг:** Эрдэнэтэд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үеэр яг 1992 оны Үндсэн хуулийг батлалцаж байсан улсууд оролцсон. Тэд нар бүр тусгайлан захисан юм. Энийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд яг Эрдэнэт хотын статусыг нь ойлгомжтой болгож, тодорхой болгож, яг хот шиг хотын ийм дүрс хэлбэртэй, утга агуулгатай болгохгүй бол 1992 онд бид нарт органик хуулиараа шийдвэрлэнэ гэж хэлсээр байгаад одоо зальдуулчихсан шүү. Дахиж тийм юм байхгүй шүү гэж надад захиж явуулсан юм. Тийм учраас би бас энийг хэлээд байгаа юм. Тэгэхгүй бол органик хуулиараа гэдэг юм шүү, цаадуул чинь гэж бүр тусгайлан захисан. Яг тэр үеийн Үндсэн хууль батлалцаж байсан улсууд.

Өнөөдөр бас яг тийм юм сонсоод байна л даа. Зүгээр ээ, ингээд гомдож тунирхах юм байхгүй, Эрдэнэт чинь дараа нь ингээд органик хуулиараа

статустай болчихно гэж байгаа юм. 57.2-ын одоогийн байгаа найруулгаараа Эрдэнэтийн статус нь бүр дордчихож байгаа байхгүй юу. Аль ч биш болчихож байгаа юм. Аймаг ч биш, хот ч биш болчихоод байгаа юм. Тийм учраас би Байнгын хорооны гишүүдэд ийм найруулга өгсөн. Тэр нь Улаанбаатарын томоохон дүүргүүд бас хот болох гээд зарим улсууд яриад байгаа ч гэсэн нийцсэн. Та нар сайн хараарай, манай Байнгын хорооны гишүүд. 57.2-ын энэ саналаар би та бүхэнд тараасан байгаа.

Тэгж байж энэ Эрдэнэтээ, Дарханаа, Улаанбаатарыг үнэхээр гурван өөр том хотоос өөр хот сүүлийн 30 жил байгуулагдсангүй. Дахиад хэзээ ч байгуулагдах юм бэ? Яг ийм дэд бүтэцтэй, хот гэдэг ойлголттой, тэнд байгаа хүмүүс нь хотод амьдарч байгаа гэж бас ухамсарладаг ийм байдалтай хот Монголд өөр байхгүй байна шүү дээ. Энэ нь ингээд ард иргэд нь, 3 сая хүн нь хүлээн зөвшөөрчхөөд байхад Үндсэн хуулийнхаа өөрчлөлтөд оруулахгүй байна гэдэг нь үнэхээр болохгүй зүйл байна гэж би бас дахиж.

**С.Бямбацогт:** Нэмэлт хариулт байгаа юу? Содбилэг гишүүн та нэмэлт хариулт авах уу? Хууль санаачлагч Нямбаатар гишүүн хариулъя.

**Х.Нямбаатар:** Содбилэг гишүүн яг энэнтэй холбоотой саналын томъёолол гаргаж ирсэн. Содбилэг гишүүний гаргаж ирж байгаа саналын томъёолол бол 57.1-тэй зөрчилдөөд байгаа юм. Өөрөөр хэлбэл, 57.1 дээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн үндсэн чиг төрөл, хэлбэрүүдийг зааж өгсөн. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо.

57.2-оор одоогийн ажлын хэсгийн гаргасан томъёолол нь өөрөө хот, тосгон байх эрх зүйн үндсийг тодорхойлоод зогсохгүй дээрх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргүүдийг уг хотод шилжүүлснээрээ 1994 оны Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль амилах ийм эрх зүйн үндсийг бүрдүүлж өгч байгаа юм.

Ажлын хэсгийн гишүүн Товуусүрэн гуай их тодорхой жишээ авсан. Сэлэнгэ аймгийн Мандал сум хоёр тосгонтой. Баруунхараа, Зүүнхараа. Баруунхараа нь засаг захиргааныхаа нэгжээс 40 км алсад байдаг. Тэгээд маш энгийн ердийн иргэний бүртгэлийн тодорхойлолт, лавлагаа авахын тулд Баруунхараа тосгоны иргэд Мандал сум руугаа 40 км явж байгаа юм.

Бид нар бол Эрдэнэтийн тохиолдол дээр юу гэж ярьж байгаа вэ гэвэл энэ хоёр хувилбартай байж болно. Тэрийг тухайн орон нутгийн иргэд шийднэ. Орхон-Уул аймаг гэдэг засаг захиргааны нэгжид орших Эрдэнэт хотын асуудал байж болно. Эсхүл Орхон-Уул аймгийнх нь чиг үүргийг бүхэлдээ шилжүүлж авсан Эрдэнэт хот гэдэг тийм өөрөө хот, тэгээд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг шилжүүлж аваад ингээд явах боломжтой ийм хоёр чиг үүргийг нэг дор шилжүүлээд ингэвэл амилна.

Хөдөө, орон нутгуудад уул уурхайн бүсүүдэд байгаа суурьшлууд өөрөө орон нутгийн шинж чанартай хот, тосгод болж тэр сумын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргүүдийг өөртөө шилжүүлж авна. 21 аймаг. Ийм агуулгаар орж ирж байгаа юм.

**С.Бямбацогт:** Энэ орон нутгийн удирдлагатай холбоотой тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой заалт дээр бол энэ улсын чанартай хот байх

уу, орон нутгийн чанартай хот байх уу. Бас тодорхой заалт байгаа. Тэгээд тухайн үед санал хураагдах байх. О.Содбилэг гишүүний санал болон ажлын хэсгийн саналууд хураагдана. Тэр дээр бас нэмээд ярих бас боломж байгаа.

Одоо Ж.Батзандан гишүүн асуулт асууя.

**Ж.Батзандан:** Үндсэн хуулийн хэлэлцүүлэг үргэлжилж байна. Мэдээж бас нааштай ганц хоёр заалтууд орж байгааг үгүйсгэх арга байхгүй. Ялангуяа Үндсэн хуулийн цэцтэй холбоотой Шүүхийн ерөнхий зөвлөлтэй холбоотой, Шүүхийн хариуцлагын зөвлөлтэй холбоотой заалтууд бол яалт ч үгүй бас шүүхийн шинэчлэлийн хүрээнд орох ёстой заалтуудаа гэж би харж байгаа.

Гэхдээ олон чухал заалтуудыг оруулахгүй хаяж байгаа нь өөрөө учир дутагдалтай байна гэж бид болон иргэд, олон түмэн үзэж байна. Өр зээлийн асуудал, эдийн засгийн асуудлууд, Үндсэн хуулийн эдийн засаг гэдэг ойлголт энэ нэмэлт, өөрчлөлтөөр ерөөсөө орж ирсэнгүй. Судлаачид эрдэмтэн болгон ярьж байгаа. Монгол Улсын Үндсэн хууль эдийн засгийн тодорхой зохицуулалтгүй Үндсэн хууль гэж. Үндсэн хуулийн эдийн засгаа мартчихсан Үндсэн хууль гэж олон жил ярьж байгаа. Тухайлбал, Монгол Улсын өрийн хэмжээ дэлхийд тэргүүлж байна. Нэг хүнд оногдох өрийн хэмжээгээрээ. Засгийн газар жилээс жилд Монгол Улсын өрийг нэмэгдүүлдэг. Засгийн газраас сонгууль дөхөхөөр Монгол Улсын өрийн хэмжээг төсвийг алдагдалтай батлах замаар Монгол Улсын эдийн засгийг дампууруулдаг. Ийм л 30 жилийг бид нар туулсан. Яаж энэ Засгийн газрын дураараа авирладгийг зогсоох юм бэ гэдэг асуудал дээр энэ Үндсэн хуулийн өөрчлөлт хариулт өгөхгүй байна.

Би ажлын хэсгийн нөхдүүдэд олон удаа хэлсэн. Дотоод нийт бүтээгдэхүүний 50 хувиас илүү дээр өр нэмэгдүүлсэн төсвийн төслийг Засгийн газраас оруулж ирэх юм бол энийг Улсын Их Хурал батлахгүй буцаах эрхээ авч үлдэх ёстой. Улсын Их Хурал төсөвтэй холбоотой өөрийнхөө эрхийг хязгаарлаж байгаа нь сайн хэрэг. Тэгвэл Засгийн газрын дураараа авирлалтыг хязгаарлах чиглэлд өр зээлийг дураараа нэмэгдүүлдэг явдлыг таслан зогсоох чиглэлд нэг ч олигтой заалт оруулж ирсэнгүйд харамсаж байгаагаа илэрхийлье.

Засаг захиргааны нэгжийн шинэчлэлтэй холбоотой томоохон реформ хийгдэх болов уу гэж хүлээж байсан боловч бас олигтой заалт орж ирсэнгүй. Монголын эдийн засгийг дампууруулж байгаа хамгийн гол асуудал бол 330 суманд улсын төсвийг хуваарилдаг байгаа. Социализмын үеийн энэ засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг хийхгүй юм уу? Эрх баригчдаа. 21 аймаг, 330 сум руугаа улсын төсвийг талаар нэг тараадаг тогтолцоогоо цааш нь 30 жил үргэлжлүүлэх юм уу?

Миний бие Үндсэн хуулийн өөрчлөлтийн хүрээнд Засаг захиргааны томоохон өөрчлөлт, реформ орж ирэх болов уу гэж хүлээж байсан боловч улсын төсвийг талаар нэг тараадаг явдлыг таслан зогсоох чиглэлд олигтой нэг ч заалт орж ирсэнгүй. Харамсал илэрхийлье.

Монгол оронд тулгамдаад байгаа гурав дахь том асуудал бол уул уурхайн асуудал. Экологийн сүйрэл. Сум болгонд лиценз олгочихсон. Говийн нэг суманд ойролцоогоор 110 лиценз олгогдсон. Говийн нэг суманд ойролцоогоор 30 уурхай ажиллуулж байгааг экологийн сүйрэл гэж бид нар

нэрлээд байгаа юм. Экологийн тэнцвэрт байдал алдагдсан гэж бид үзээд байгаа юм.

Монгол орныг экологийн сүйрлээс аврах Үндсэн хуулийн том бодлого орж ирэх болов уу гэж бид итгэж хүлээж байсан. Экологийн сүйрлийг зогсоох чиглэлд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нэг ч заалт орж ирсэнгүй. Би харамсаж байгаагаа илэрхийлье. Үнэхээр харамсалтай байна.

Дөрөв дэх том асуудал Монголыг сүйрүүлж байгаа дөрөв дэх том асуудал бол хэрээс хэтэрсэн улс төржилт, хэрээс хэтэрсэн намчирхал гэж бид харж байгаа юм. Энэ 30 жил намчирхсан нам төв улс төрийн тогтолцоог өөрчлөхийн тулд томоохон реформын заалтууд орж ирэх болов уу гэж бид хүлээж байлаа.

Намын хатуу гишүүнчлэлийг байхгүй болгоё. Хатуу гишүүнчлэлтэй намын тогтолцоог устгая. Зөвхөн чөлөөт дэмжигчид дээр суурилсан улс төрийн тогтолцоог бий болгоё. Иргэн төвтэй улс төрийн тогтолцоог бий болгоё гэж би олон удаа ажлын хэсэг дээр хэлсэн. Харамсалтай нь бидний саналыг хүлээж авахгүй байна.

Цаашдаа өнгөрсөн 30 жилийн намчирхсан тогтолцоог ахиад 30 жил үргэлжлүүлэхээр Үндсэн хуулийн өөрчлөлт явж байна гэж бид харж байна. Энэ маягаар Монгол өөрчлөгдөхгүй. Ийм маягаар Монгол Улс хөгжихгүй. Харамсаж байгаа илэрхийлье.

Авлига, албан тушаалын гэмт хэрэг. Энэ төрийн үрэлгэн байдал. 30 жилийн завхралыг зогсоох чиглэлд томоохон дорвитой өөрчлөлтийг эрх баригч нам оруулж ирэхгүй байна. Бас дэмжихгүй байгаа нь бидний сонирхлыг татаж байна.

Д.Лүндээжанцан доктор бол Үндсэн хуулийн эрх зүйгээр мэргэшсэн хүн. Харамсалтай нь орж ирж байгаа ажлын хэсэг дээр Үндсэн хуулийг хэлэлцэж байгаа байдлаас харахад энд Монголын ард түмний хүсэн хүлээсэн олон чухал заалтуудыг, өөрчлөлтүүдийг оруулахгүй зүгээр халтуурдах, хууран мэхлэх, хэлбэрдэх төдийгөөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж байна уу даа гэдэг бодол бидэнд төрж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлсэн саналыг хүлээж авах нь зүйтэй. Наадам дөхөж байгаа. Зуны халууныг далимдуулж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэх нь зүйтэй биш гэж Монгол Улсын Ерөнхийлөгч хэлсэн.

Наадмын дараа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг дахин нухацтай хэлэлцэж байж ард түмний, ард олны хүсэн хүлээсэн заалтуудыг шударга Монголыг бий болгох, авлигагүй Монголыг бий болгох, баялгийн шударга хуваарилалтыг бий болгох, намчирхалгүй Монголыг бий болгох чиглэлд томоохон өөрчлөлтийг оруулж ирээсэй гэж хүсэж байгаагаа илэрхийлье.

Л.Болд гишүүн бид хоёрын гаргасан саналуудаас баялгийн сангийн тухай, стратегийн ордуудын 51 хувиас доошгүйг нь Монголын ард түмэндээ эзэмшүүлэх баялгийн сангийн тухай заалтыг эрх баригч нам хүлээж авах тал дээр бас дэмжиж ажиллаж байгаад талархал илэрхийлье.

Мөн Л.Болд гишүүн болон Шударга иргэдийн нэгдсэн эвслээс оруулж байгаа ганц хоёр заалтуудыг бас дэмжиж авах талдаа ажлын хэсэг ажиллаж байгааг бас хараад итгэж байгаагаа илэрхийлье. Гэхдээ олон түмнээс, олон түмний зүгээс, иргэдийн зүгээс энэ Үндсэн хуулийг энэ 65 суудалтай намаар батлуулж болохгүй шүү. Заавал ард нийтийн санал асуулгаар оруулаарай гэж иргэд, олон түмний дийлэнх олонх нь захиж байгааг бас илэрхийлэхийг хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Нэлээн хэдэн асуулт асуулаа. Бас иргэдэд зөв ойлголт өгөх ёстой байх. Д.Лүндээжанцан гишүүн. Хууль санаачлагч хариулъя.

**Д.Лүндээжанцан:** Ж.Батзандан гишүүн, Л.Болд гишүүн нар бол энэ төслийг анх одоо эхэлсэн цагаас нь хойш хамтарч ажиллаж ирсэн. Ардчилсан намын төлөөлөл байхдаа. Одоо шинэ намын төлөөлөл болоод энэ комисст, ажлын хэсэгт орж ажиллаж байна.

Тэгээд бид бүхэн зөндөө олон зүйлийг ярьсан. Үндсэн хуулийн эдийн засгийн асуудалтай холбогдуулаад манайхан хариулах байх. Ямар ямар зүйлүүд оров гэдгийг. Би бол тэр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн реформын тухай ярихад бол энэ бол одоо байна шүү дээ хаалттай асуудал бол биш байгаа юм. Үе үеийн Засгийн газар ерөөсөө л улс төрийн шалтгаанаар оруулж ирэхгүй л байгаа юм шүү дээ. Их Хурал.

2000 оны эхэнд Булган аймаг дээр очиж Засгийн газрын Хэрэг эрхлэх газар очиж хуралдуулаад тэгээд л одоо жаал иргэдийн санаа бодол зөрүүтэйгээс шалтгаалаад больсон. Тэгээд яадаг вэ гэхээр энэ жил сонгууль болох гэж байна. Орон нутгийн сонгуультай. Одоо энэ асуудлыг ярихгүй. Хойтон жил нь бол дараагийн жил нь Ерөнхийлөгчийн сонгуультай. Ингээд тэгээд одоо ер нь бол дараагийн сонгууль дөхөж байна. Ийм л асуудалтай явж ирсэн. Тэрнээс биш одоо манай Үндсэн хуульд бол би түрүүн О.Содбилэгийн асуултад хэлж байсан. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг батлах, өөрчлөх асуудал одоо Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

Мөн одоо 57 дугаар зүйлийн 3-т засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулах, өөрчлөх асуудлыг одоо Улсын Их Хурал шийдвэрлэнэ гээд ингээд тухай тухайн газар нь бол заалт нь бол одоо ч байж байна. Яагаад гэхээр бол одоо тэнд одоо эзгүйрнэ ч гэдэг юм уу. За одоо юу гэх вэ, хөдөлгөөд юу гэх вэ. Энэ бол одоо улс төрийн долгион, давлагаа үүсчихнэ гээд оруулж ирэхгүй байгаагаас биш зохицуулалт нь бол байгаа юм гэдгийг хэлье.

Байгаль орчны асуудлаар бол дөрвөн газар Үндсэн хуульд заалт байна. Одоогийн байдлаар. Одоо орж ирж байгаа энэ заалт дотор бол одоо тэр тогтвортой хөгжил болоод мөн одоо энэ байгалийн тэнцэл алдагдуулахгүйгээр байгалийн баялаг буюу ашигт малтмалыг ашиглах асуудлын зарчим бас сууж өгч байгаа.

Энэ дөрвөн заалтаа яаж харин амьдрал дээр хэрэгжүүлээд явахаас л бүх зүйл шалтгаалж байна. Энэ хэрэгжүүлдэг хяналт тэнцвэрийн механизмыг нь засья гэж бид энд оруулж ирж байгаа юм гэдгийг одоо би товчхон хариулъя. Тэгээд хамтарч одоо нэгэнтээ ажлын хэсэгт хамт байгаа. Энэ хэлэлцүүлэх

шатны Ө.Энхтүвшин даргаар ахлуулсан. Ингээд цаашдаа хамтраад ажиллаад явж болох байхаа гэж бодож байна.

**С.Бямбацогт:** Нэмэлт хариулт байгаа юу? Алга байна. Болсон уу? Тийм ээ. Асуулт асууж, хариулт авлаа. Ц.Мөнх-Оргил гишүүн алга байна.

Сая Ж.Батзандан гишүүний хэлсэнтэй холбогдуулаад Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг бид хүлээж авч байгаа. Төрийн байгуулалтын байнгын хороо өнөөдөр хуралдана. Ирэх долоо хоногт хуралдана. Мөн бас наадмын дараа 7 сарын 16-нд хуралдана.

Аль болох одоо ард иргэдийнхээ олон санал бодлыг сонсож олон нийтийн хэлэлцүүлэг хийж хамгийн одоо нөгөө бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэдэг зарчмыг барьж Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, заалт болгоныг нухацтай ярилцъя гэж байгаа. Өнөөдөр ч энэ үүднээсээ бас ойлголцохгүй саналуудыг хойш нь тавиад одоо зарчмын хувьд ойлголцож байгаа. Нэгдсэн ойлголцолд хүрсэн саналуудаа хураагаад ийм байдлаар бас ажлаа жаахан нугалах байдлаас хэлэлцүүлгийг хийж явна гэдгээ бас нэмээд хэлчихье.

Улсын Их Хурлын гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Санал хураалт явуулахаас өмнө бас горимын санал. Л.Болд гишүүн горимын санал гаргая.

**Л.Болд:** Баярлалаа. Тэгэхээр одоо ингээд шууд санал хураалт руу орох гээд байна л даа. Энэ олон саналууд байгаа. Тэгээд өчигдөр ажлын хэсэг бас нэлээд оройтож сууж ажиллаад тэгээд ингэсэн юм. Хэд хэдэн одоо яг эцэслээгүй асуудлуудаа нээлттэй Байнгын хороо руу явуулсан юм. Одоо жишээ нь энэ баялгийн сангийн асуудал. За тэгээд тэр орон нутгийн удирдлагатай холбоотой гээд хэд хэдэн асуудлуудыг. Ингээд ийм задгай орж ирж байгаа.

Одоо энийг тэгээд энд хүчээр түрээд санал хураагаад явах юм бол энэ өөрөө бол би бол маш буруу практик руу явах байх гэж хараад байгаа. Ажлын хэсгийн тэр. Ерөнхийдөө энэ дээр ойлголцол руу явах бололцоог нь олгох гээд ингээд хойшлуулсныг бас Байнгын хороо ч гэсэн хүлээж аваад. Мэдээж хэрэг одоо энэ хүн хүн саналаа тайлбарлая. Тэгээд энийг бол өнөөдөр ингэж хүчиндэж тэгж тийм ээ одоо шууд одоо хүч хэрэглэн нэг талдаа гаргаж ингэж санал хурааснаас яг ийм маргаантай асуудлуудаа дахиж нэг ойлголцож. Тэртээ тэргүй 16-нд бид нар эргээд уулзана. Ажлын хэсэг ч хуралдана.

Тэгээд хэд хэдэн цөөхөн асуудал бий дээ. Харин зүгээр энэ ойлголцсон, нэгдсэн, саналаа татсан нэлээд олон асуудал байгаа. Энэ маш олон хуудас юм байна шүү дээ. Эд нарыгаа аль болохоор одоо эхлээд тийм үү маргаангүй юмаа нэг жаахан багцалж явуулчхаад зөрөлдөөнтэй асуудлуудаа дахиж нэг цөмөөрөө 16-н гэхэд нягтлахаар л ийм л горимын санал оруулж байгаа юм. Тэгээд та Байнгын хороон дарга та өөрөө яах вэ яриулж байгаад явц дунд үнэхээр бололцоотой бол өнөөдөртөө энэ асуудлууд дээр санал хураахгүй эргэж нэг яримаар гэсэн ийм л санал байгаад байгаа юм л даа. За баярлалаа.

**С.Бямбацогт:** Д.Лүндээжанцан гишүүн бас горимын санал гаргая гэж байна. Горимын саналыг сонсьё.

**Д.Лүндээжанцан:** Зарчмын зөрүүтэй санал хураах дарааллын талаар. Тэр төслийн талаар гарсан зарчмын зөрүүтэй саналыг хураахдаа агуулгын хувьд цогц байдлаар 4 хэсэгт ангилан парламентынх, тэгээд гүйцэтгэх эрх мэдлийг, шүүх эрх мэдлийнх, нутгийн удирдлагын гэсэн байдлаар бүлэглээд агуулгын хувьд дэс дараалан хураалгавал яасан юм бэ.

Өөрөөр хэлбэл одоо за төсөл нь үлдэх үү гэхээр нөгөө нэмэлт оруулах гэж байгаа саналууд чинь тийм үү унах гээд байдаг. Тийм учраас багцлаад дэс дараагаар нь ухраагаад ингээд одоо агуулгын хувьд цогц байдлаар ингээд 4 хуваагаад явбал яасан юм бэ гэж.

Л.Болд гишүүний гаргасан санал дээр бол яах вэ өчигдөр бид даалгавар аваад ажиллаад нэг томъёоллууд хэд хэдэн хувилбартай томъёоллууд хийж байна. Одоо жишээ нь байгалийн баялаг гэдгийг ашигт малтмалыг болгоё гээд. Тийм үү. Ингээд гарсан шүү дээ өчигдөр бид. Гээд тэгэхдээ баялгийн сангийн асуудал дээр жишээ нь одоо зөрүүтэй ойлголтууд байна. Яг юугаа хэлдэг юм, яадаг юм гээд. Жишээ нь, одоо нэг 15 улсын энэ байгалийн баялаг нэлээнтэй. Тэгээд их зөв яваад байгаа гээд байгаа одоо баялгийн сан бүхий томоохон 15 улсын Үндсэн хуулийн байгалийн баялагтай холбоотой зохицуулсан харилцааг бол одоо материалыг л та бүхэнд тараасан байж байгаа.

Ингээд энэ дээрээ бол нэлээн нухацтай ярих шаардлага гараад байгаа юм. Би бас одоо энэ Л.Болд гишүүний саналыг дэмжиж байна. Ер нь бол энэ одоо дараагийн юун дээрээ бас дахиад л сайн ажиллацгаая. Томъёолол дээр. Яг юу гэж хэлэх вэ. Яах вэ гээд. Хэдэн хувилбараас чинь байна шүү дээ яг юуг нь ажлын хэсэг оруулж ирэх юм. Тэгээд ямар ч байсан ажлын хэсэг дээрээ нэгдмэл нэг ойлголттой болоод тэгээд Төрийн байгуулалтын хороо руу орвол, шийдүүлбэл арай илүү. Тийм үү. Хүлээн зөвшөөрөгдөж зөвшилцөх тал нь илүү байж магадгүй гэж миний хувьд ойлгож байна. Тэгээд яах вэ нээлттэй. Бид бол өнөөдөр бүрэн хурлаа бол дуусгаж чадахгүй байх. Гэхдээ энэ олон санал хураалтаа бол явуулах нь зүйтэй. Нэлээдийг нь одоо явуулаад энэ гишүүдийн гаргасан саналууд, ажлын хэсгийн саналуудаа бол хураах нь зүйтэй гэж ингэж үзэж байна.

**С.Бямбацогт:** Гишүүд горимын санал гаргалаа. Нэгдүгээрт нь, Л.Болд гишүүн бас маргаантай асуудлуудаа хойшлуулъя. Бас нэлээн сайн хэлэлцье, ярилцъя. Маргаангүй асуудлаараа санал хураая. Хураагаад явж байя гэсэн. Өнөөдөр энэ долоо хоногт хуралдана. Ирэх долоо хоногт хуралдана. Наадмын дараа хуралдах юм чинь бас нэлээн нухацтай хэлэлцье гэсэн санал гаргаж байна.

Тэгэхээр ямар нэгэн байдлаар хүч түрэхгүй явах нь зөв шүү гэсэн саналыг Л.Болд гишүүн хэлж байна. Тэгэхээр маргаантай асуудлуудаа хойш нь тавиад. Маргаангүй нэгдсэн ойлголцолд хүрсэн асуудлуудаараа саналаа хураагаад явж байя гэсэн Л.Болд гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Горимын саналаар.

Горимын саналыг дэмжиж байгаа гишүүд дэмжсэн кнопоо дарна уу. Дэмжээд явчих нь зөв байхаа гэж бодож байна. Тэгээд маргаантай асуудлуудаа

хойш нь тавиад. Маргаангүй асуудлуудаар саналаа хураагаад явчихъя гэж байна. Санал хураалт.

Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 69.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараад нь Д.Лүндээжанцан гишүүн бас горимын санал гаргасан. 4 багц асуудлын хүрээнд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл, нутгийн удирдлага гэсэн саналууд маань яг дэс дарааллаараа, зүйл, заалтаар хураах юм бол бас агуулгын хувьд жаахан ойлгомжгүй болох гээд байна. Тийм болохоор багц багцаар нь тийм үү. Яг агуулгын хувьд бас ойлгомжтой цэгцтэй ойлголт үүсэх үүднээс нутгийн удирдлага тусдаа, гүйцэтгэх засаглалынх тусдаа, хууль тогтоох тусдаа гэсэн байдлаар одоо санал хураая. Энэ нь илүү бас ойлгомжтой. Багцаар нь ярихад бас тодорхой болох байх гэсэн санал гаргасан.

Д.Лүндээжанцан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Дэмжиж байгаа гишүүд нь саналаа өгнө үү.

Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 7 гишүүн зөвшөөрч, 53.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Горимын санал учраас ердийн горимоор явна. Одоо яг зарчмын зөрүүтэй саналууд бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн зарчмын зөрүүтэй саналууд нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар дэмжигдэж явна. Тийм болохоор хуралдаанд ирцдээ орсон гишүүд хүрэлцэн ирэхийг урьж байна. Мөн одоо бас ирцдээ орох бололцоотой, боломжтой гишүүд бас ирмээр байна. Улсын Их Хурлын дарга ирээгүй байна. Н.Амарзаяа гишүүн байхгүй байна. Д.Тогтохсүрэн дарга иргээгүй байна. Хуралдаа ирэхийг урьж байна.

Ирээгүй гишүүдээс хэн хэн ирээгүй билээ. О.Баасанхүү гишүүн, Б.Наранхүү гишүүн, Л.Оюун-Эрдэнэ гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Д.Эрдэнэбат гэсэн гишүүд хүрэлцэн ирнэ үү. Ж.Эрдэнэбат гишүүн бас хуралдаа хүрэлцэн ирнэ үү.

Одоо хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар. 14 гишүүн. 13 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Одоогоор. Санал хураалт явуулах уу?

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаар ажлын хэсэг, Байнгын хороодоос гарсан зарчмын зөрүүтэй саналууд.

Нэг. Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт.

### **1.Төслийн 2 дугаар зүйл буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн. Төрөөс байгалийн баялгийг ашиглахдаа тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах зарчмыг баримтална.”



Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн саналын томъёолол. Цаашид “Төслийн заалт” гэж нэрлэх гэсэн санал байна.

Мөн одоо үүнтэй холбоотой ажлын хэсгээс бас гарсан саналууд байгаа. Найруулсан. Бас өөрчилсөн. Ажлын хэсэг буюу одоо Ө.Энхтүвшин, Ж.Батзандан, Л.Болд, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Х.Нямбаатар, Д.Оюунхорол, Л.Оюун-Эрдэнэ, Д.Тогтохсүрэн. Цаашид бас ажлын хэсэг гэж нэрлэгдэх ийм саналууд байна.

Мөн одоо бас үүнтэй холбоотой Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг гишүүний гаргасан санал байна. Мөн одоо Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Л.Болд нарын гишүүдийн санал байгаа. Мөн одоо Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Улаан гишүүдийн санал байгаа. Мөн одоо бас үүнтэй холбоотой Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны гаргасан саналууд байгаа.

Нийтдээ үндсэндээ төслийн 2 дугаар зүйл буюу 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй холбоотой тав, зургаан санал байгаа. Энэ 6 санал дээр одоо бас нэгдсэн ойлголцолд хүрье гэдэг сая Л.Болд гишүүний санал гарсан. Түүнтэй холбоотойгоор энийг санал хураалт явуулахгүй хойшлуулъя.

Энэ бас зургаа, долоон төрлийн санал байгаа. Энийг нэгтгэх, бас ойлголцох шаардлагатай. Хугацаа авах хэрэгтэй. Бас нэлээн сайн бодох шаардлагатай байх гэж бодож байна.

Ингээд энэ нэг дэх саналыг хойшлууллаа. Хоёрдугаарт нь, **Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес<sup>1</sup> дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг:**

“**19<sup>1</sup>.1.**Нам иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна.

**19<sup>1</sup>.2.**Намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх сурвалж болон зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүжилт, ил тод байдал, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх болзлыг хуулиар тогтооно.” гэсэн төслийн заалт байна.

Энэ санал дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. За Д.Лүндээжанцан гишүүн.

**Д.Лүндээжанцан:** Тэгэхээр байна шүү дээ. Өчигдөр ажлын хэсэг дээр ажлын хэсгийнхээ саналыг одоо уншмаар байгаа юм. Хамтад нь. Өөрөөр хэлбэл энэ төслийн энэ эхний 19<sup>1</sup> дээр бол одоо ийм ийм санал оруулъя гээд Л.Мөнхбаатар гишүүн, Я.Содбаатар гишүүн нар саналаа гаргачихсан.

Тэгтэл тэр саналууд бол Байнгын хороон дээр зарим нь дэмжлэг аваад, дэмжлэг аваагүй. Энийг бол одоо бид хоёр гишүүн нь татаж авч байгаа гэж. Харин Ш.Раднаасэд гишүүн бол 19.1-ийг хасья гэдэг санал одоо гаргасан. Тэр дээр нь энэ хоёр гишүүн бол хамтраад энэ гурван гишүүн одоо 19<sup>1</sup>-ийг бол хасья. 1.1-ийг хасья гэдэг. 2-оор нь бол үлдээе гэдэг ийм санал дээр ажлын хэсэг өчигдөр дэмжсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр төслөөр нь хураагаад ингээд дэмждэг. Хоёр адилхан босоо саналтай болох гээд байдаг. Тийм учраас бид бүхэн бол байна шүү дээ ингэмээр л байгаа юм. Хэрвээ хэн хоёрын санал яг одоо бид хуулийнхаа энэ дэгийн хуулийн логик хармаар байгаа байхгүй юу. Манай ажилтнууд ч гэсэн энийг сайн сонсож бай.

Энэ хоёр гишүүн татаад авчихсан. Ш.Раднаасэд, Л.Мөнхбаатар, Я.Содбаатар гурав бол нэгийг хасъя гэдэг зарчмын зөрүүтэй саналаар санал хураагаад энэ дэмжлэг авах юм бол төслийн нөгөө үлдэж байгаа зүйл дээр санал дахиж хураагаад. Төслөөр нь тийм үү. Яг дэгийнхээ дагуу хураагаад ингээд хамтатган ингээд хамтатган хураагаад явж байгаа нь бол болж байна гэж. Ойлгож байна уу? Хамтатган хураана гэсэн үг байгаа биз. Тийм.

Тэгэхээр яах вэ гэхээр эхлээд нэгийг нь хураачхаад. Нэг дээр нь одоо хэрвээ дэмжлэг авбал нэг үлдсэнийг нь хураагаад. Нөгөө нэг хоёрдугаар. Хүчинтэй үлдэж хоцорч байгаа төслийнхөө. Өмнөх нь хураагдахгүй бол дэмжлэг авахгүй бол нэг, хоёроор нь нийлүүлээд саяын таны уншсанаар хамт хураагаад ингэж явбал байна шүү дээ. Яг хуулийнхаа логик хамтатган хураах нь бол болж байгаа юм. Үүний дараагаар бол манай Батзандан гишүүн, Болд гишүүн нарын саналыг хураана гээд дамжаад дамжаад явна гэж. Ойлгосон уу миний яриаг.

**С.Бямбацогт:** Тэгэхээр Лүндээжанцан гишүүний хэлж байгааг ойлгож байгаа. Өчигдөр ажлын хэсгийн хуралдаан дээр бол яригдсан. Гэхдээ манай дэд ажлын хэсгийнхэн яригдсан болохоос биш санал хураалт явагдаагүй татъя гэсэн саналыг нэгдүгээрт тайлбар хэлж байна.

Хоёрдугаарт нь тэрийг сайн мэдэхгүй байна. Дэд ажлын хэсгээс сайн асуугаарай. Ажлын хэсгийн гишүүд ээ.

Хоёрдугаарт нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд төслийн хоёр дахь хэлэлцүүлэг хийхдээ гарсан саналуудыг хамтатган хэлэлцэнэ гэсэн заалт байгаа. Хамтатган хэлэлцэхдээ бас нэгдүгээрт нь төслийн саналаар санал хураалт явуулна.

Хоёрдугаарт нь ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулна.

Гуравдугаарт бусад Байнгын хороо гишүүдийн гаргасан саналаар санал хураалт явуулна гэсэн дэгтэй. Тийм болохоор зайлшгүй гарсан санал бүрээр санал хураалт явуулахаас өөр аргагүй. Ингээд бас санал хураалт явуулахад бидэнд бас нэг асуудал байгаа нь саяын ярьж байгаа асуудал. Улс төрийн нам улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна гэдэг маань үндсэндээ сум бүрд аймагт бүрд улс төрийн намууд байгуулагдах өөр одоо улс төржих үзэгдлийг даамжруулах нь нэг талаас ярьж байгаа. Нөгөө талаасаа Үндсэн хууль санаачилсан төслийн санаачлагч нар бол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна гэдэг маань харин ч аймгийн нам, бүсийн нам, үндэстэн, ястны нам гарахгүй байх ийм бололцоо боломжийг бий болгож байгаа гэдэг үүднээс тайлбарлаж байсан. Тийм болохоор энэ асуудал маань бас нэгдүгээрт нь дэгийн хуулийн асуудлыг харах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт нь ажлын хэсэг дээр тодорхой бус байна.

Гуравдугаарт нь саяын ярьж байгаа зүйл заалтууд дээр бас үзэл баримтлалын бас ялгаанууд зөрчилтэй зүйлүүд байна. Тийм болохоор энэ саналыг санал хураалт явуулахгүй хойшлуулъя.

Хойшлуулаад явъя. Ойлголцож байж хураая. Бид нар горимын санал гаргаад ойлголцсон асуудал дээрээ явна. Ойлголцоогүй асуудал дээр явахгүй гэж тохирсон.

Гурав дахь санал хураалт.

### **3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг:**

“21.4.Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо, журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.”

Гэсэн заалт. Үүнтэй холбоотой бас нэлээд олон гишүүд санал гаргасан. Нийтдээ таван санал байна. Тийм болохоор энийг бас дахиад ажлын хэсэг дээр сайн ярилцъя. Энийг бас хойшлуулъя.

### **4. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:**

“3.Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлснээс дөчин тав хоногийн дотор, эсхүл Ерөнхий сайдыг шинээр томилох нөхцөл үүссэн өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхий сайдыг томилоогүй бол Улсын Их Хурлыг тараах шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана.

4.Энэ зүйлийн 2, эсхүл 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр гаргаснаас хойш Улсын Их Хурал арав хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж, жар хоногийн дотор явуулна. Шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хадгална.”гэсэн төслийн заалт байна. Энэ төслийн заалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Дараа нь бас хураана.

Гурав дахь хэлэлцүүлгийн явцад энэ ажлын хэсгийн төслийн заалт, ажлын хэсгийн санал, гишүүдийн гаргасан санал, гурвуулаа боссон тохиолдолд, гурвуулаа унасан тохиолдолд гурав дахь хэлэлцүүлгийн үед ингэж цэгцэлнэ гэсэн журмын тухай хуулийн заалт байж байгаа.

Тайлбарла даа Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Одоо бол ингэж явах юм гишүүд ээ. Дэгээрээ одоо жишээлбэл саяын заалт дээр бид нар төслийнхөө заалтыг дэмжихгүй унагаад ажлын хэсгийн саналыг дэмжих юм. Ажлын хэсгийн санал нь илүү нөгөө найруулаад чамбайруулсан байхгүй юу. Тийм учраас бол гишүүд яах вэ хоёуланг нь дэмжиж болохгүй, хоёуланг нь унагаж болохгүй. Тэгэх юм бол цаашид явахад хэцүү болно. Тийм учраас би Байнгын хорооны гишүүдээс юу гэх гэж байна вэ гэхээр саяын 4 дүгээр зүйл дээр төслийн заалтыг унагаад ажлын хэсгийн саналыг дэмжээд явбал энэ зөв хувилбартай болох юм байгаа юм шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Дэг өөрөө ийм учраас хоёулангаар нь санал хураалт хийнэ.

**С.Бямбацогт:** Мөнхбат гишүүн.

**Ж.Мөнхбат:** Өдрийн мэнд хүргэе. Үндсэн хууль хэлэлцэж байгаа нэмэлт, өөрчлөлт. Энэ бол хариуцлагатай хууль. Тэгэхээр би одоо ямар горимын санал гаргах гэж байна вэ гэхээр өчигдөр ажлын хэсэг дээр нэг баахан юм яриад санал хураасан. Тэгээд тэр саналууд аль нь дэмжигдсэн бэ, аль нь дэмжигдээгүй байгаад байгаа юм. Нэг ийм юмнууд чинь байхгүй, тодорхойгүй болоод байна. Тийм учраас ажлын хэсгийн даргыг суулгамаар байна. Ажлын хэсгийн дарга, ажлын хэсэгтэйгээ суугаад энэ заалт дээр энэ дэмжигдсэн, энэ дэмжигдээгүй, энийг энийг ингэж ингэж шийдэхээр болсон гээд Лүндээ даргын яриад байгаа юмыг тайлбарлаад явмаар байх юм. Тэгэхгүй болохоор энэ чинь ингээд 4, 5 санал, 2, 3 саналаас буруу саналыг нь дэмжээд нөгөө дэмжих санал нь унаад ингээд явчихвал та нар чинь эргэж засаж чадахгүй юм болно шүү.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн даргыг дуудъя. Мөнхбат гишүүний хэлж байгаа бас зөв. Хуралдаан даргалж байгаа улсууд хуралдааны дэгийг бариад хуулиа бариад хуралдана. Гэхдээ ажлын хэсэг маань бас төслийн санал хууль санаачлагчдын санал, ажлын хэсгийн санал, гишүүдийн саналаас энэ нь үндэслэлтэй, энэ нь дэмжих ёстой. Ийм учраас энийг ингэж өөрчилсөн, ингэж дэмжсэн гэдгээ тайлбарлаад явбал гишүүд бас ойлголт бий болно. Тийм болохоор бид нар бас ажлын хэсгийн даргыг дуудъя. Хуралдаанд оролцоод санал бүр дээр тайлбараа хэлээд ийм учиртай ийм 5 саналаас тэр нь тийм бид нар ингэж шийдсэн гэдгээ хэлээд явах нь зөв байх.

Ажлын хэсгийн даргыг дуудъя Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Би нэг ийм яг дэгтэй холбоотой нэг ийм юм хэлэх гэсэн юм. Мөнхөө хүлээж байгаарай. Энийг сайн тайлбарлахгүй бол ялангуяа дотор байгаа гишүүд маань эргэлзээд байгаа юм чинь гадна энийг хараад сонсож байгаа хүмүүс ч гэсэн эргэлзээд байж магадгүй. Үндсэн хуулийн энэ хоёрдугаар хэлэлцүүлгийг явуулахдаа санал хураахдаа төслөөр нь ч хураагаад шинээр гарсан саналаар нь ч хоёуланг нь заавал хураадаг ийм дэгтэй. Тэгэхээр хуучин бид нар бол жишээ нь үндсэн төсөл нь энэ байгаа юм. Шинээр гарсан ажлын хэсгээс гарсан санал гээд ажлын хэсгийн санал дэмжигдвэл хуучныг нь дэмжигдээгүй гээд хасаад явдаг байсан бол энэ удаа болохгүй заавал хоёулангаар нь эхлээд төслөөр нь дараа нь шинээр гарсан саналаар нь санал хураагаад ингээд шийдээд явна. Одоо жишээ нь ажлын хэсэг дээрээ төслөө больё.

Ажлын хэсгийн саналаар явъя гэсэн бол төслөө унагаагаад хоёр дахиа дэмжээд ингээд яваад байх ийм дэгтэй юм билээ шүү. Тэгэхгүй бол ялангуяа телевизээр үзэж байгаа хүмүүс ойлгохгүй яагаад адилхан юмыг ингээд дахин дахин хураагаад байгаа юм бэ гэж бодож магадгүй. Тэгээд ч ер нь энийгээ сайн анхаарч хураагаад саналаа хураахдаа ажлын хэсгийн зохицсон хувилбар нь аль юм гэдгээ сайн ойлгож байгаад энийгээ дэмжих юм байна гэвэл анхныхааныг унагаагаад хоёр дахь нь дэмжигдээгүй бол анхныхыгаа дэмжээд явах энийгээ сайн бодож явах хэрэгтэй юм билээ шүү гэдгийг бас гишүүддээ ч сануулж байгаа юм. Бас сонирхоод анхаарал тавиад үзэж байгаа гаднаас харж байгаа хүмүүстээ ч зориулж хэлж байгаа юм.

**С.Бямбацогт:** Гишүүд ерөнхийдөө бас хэлж байна. Төслийн санал, ажлын хэсгийн санал, гишүүдийн гаргасан санал гэсэн саналууд байгаа. Бүгдийг нь хамтатган хэлэлцэх хуультай. Ингэхдээ мэдээж ажлын хэсэг ажиллаж байгаа юм. Төслийн саналыг өөр сайжруулъя. Тэгээд энэ гишүүдийн гаргасан саналаас ийм томъёоллуудыг нь авъя гэдэг байдлаар ажлын хэсэг маань саналаа гаргасан байгаа. Тэгэхээр аль болох одоо ажлын хэсгийн саналаа дэмжих бусад саналууд дээр бас анхаарах ийм байдлаар явах нь зөв гэсэн саналыг хэлж байна. Би хуралдаан даргалагчийн хувьд чиглэл өгөөд байж болохгүй. Тийм болохоор гишүүдийн хэлж байгаа саналыг товч ойлгомжтой тайлбарлаж хэлэх юм бол ийм саналууд хэлж байна. Тэгээд энийг гишүүд маань анхааралдаа аваад явна уу.

Ажлын хэсгийн ахлагч маань наадмын комиссын хуралдаан болж байгаа болохоор Лүндээжанцан гишүүн бас орлоод энэ санал дээр тодорхой саналуудыг хэлээд явж байх уу. Энхтүвшин даргыг иртэл. Ингээд төслийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг гээд уншсан. Энэ төслийн заалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Төслийн заалт дэмжигдсэнгүй. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос татгалзсан 100 хувийн саналаар татгалзсан байна.

Одоо 4.1 ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулъя.

**4.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“3.Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш дөчин тав хоногийн дотор, эсхүл Үндсэн хуулийн дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш гуч хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана.” Санал гаргасан ажлын хэсэг гэсэн санал байна. Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн санал.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 78.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

**5.Төслийн 4 дүгээр зүйл буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтаас “Засгийн газрын гишүүд,” гэснийг хасах.**

Энийг Мөнх-Оргил гишүүн бас санал гаргасан байгаа. Энэ дээр бас эргэж ярилцъя гэсэн. Энэ нөгөө давхар дээл, дан дээлтэй холбоотой асуудал. Тийм болохоор эргэж ярилцъя гээд. Хойшлууллаа. Тийм ээ тийм давхар дээл дан дээлтэй холбоотой, мөн мөн.

Биш байна уучлаарай.

**5. Төслийн 4 дүгээр зүйл буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтаас “Засгийн газрын гишүүд,” гэснийг хасах. Төслийн заалт.**

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 85.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**5.1. Төслийн 4 дүгээр зүйлээс “Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд” гэснийг “Ерөнхий сайд,” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй.**

Дэмжье гэснээр санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 92.9 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

**6. Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:**

“25.1.7.төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах. Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын зөвшөөрөлгүй зардлын шинэ төрөл үүсгэж, зарлага нэмэгдүүлэхгүй. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно;” гэсэн санал байгаа. Үүнтэй холбоотой нэлээд олон гишүүд санал гаргасан. Тийм болохоор энэ санал хураалтыг хойшлуулъя.

Найман санал байгаа юм байна. Энэ 8 саналыг хамтад нь хойшлуулсан.

**7. Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“27.6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар батална.” Гэсэн төслийн заалт байна.

Лүндээжанцан гишүүнд микрофон өгье.

**Д.Лүндээжанцан:** Тэгэхээр энэ эцэслэн батална. Бүхэлд нь эцэслэн батална гэдэг үгтэй явж байгаад өргөн баригдах үед бол энийг нь хасагдсан байгаа юм. Тэгээд Мөнх-Оргил гишүүн бол яг хуульд өөрөөр заагаагүй бол Мөнх-Оргил гишүүн Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хуулийг бүхэлд нь эцэслэн батална гэдэг үгийг найруулгаар оруулъя гэдэг ийм санал гаргасныг өчигдөр ажлын хэсэг дээр бид дэмжсэн. Яагаад энэ дээр үг ороод ирсэн байна. Тэгэхээр энэ төслийг бүхэлд нь дэмжээд тэгээд дээр нь Мөнх-

Оргил гишүүний саналыг дэмжчихвэл одоо найруулгын санал дэмжигдсэн гэж би протоколд тэмдэглүүлэх гээд байна.

Бямбацогт дарга аа ингэе. Төслийн саналыг дэмжье. Тэгээд бүхэлд нь эцэслэн гэдэг үгийг Мөнх-Оргилын саналыг давхар дэмжээд тэгээд засаад ингээд редакцлаад чуулгандаа оруулъя гэдэг ийм л саналтай байгаа юм.

**С.Бямбацогт:** Мөнх-Оргил гишүүн санал гаргасан байгаа. Тэгэхээр аль аль нь дэмжээд явах ёстой юм байна.

Санал хураалт явуулъя. Төслийн саналыг аан Лүндээжанцан гишүүний хэлсэн томъёоллоор дэмжье.

**Д.Лүндээжанцан:** Хоёуланг нь дэмжинэ гэсэн үг.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 10 гишүүн буюу 76.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

**7.1.**Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг “Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар хуулийг бүхэлд нь эцэслэн батална” гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн. Санал хураалт явуулъя.

Саяын Лүндээ гишүүний хэлснээр дэмжээд явъя гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 11 гишүүн энэ саналыг дэмжлээ.

**8.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг:**

**“28.2.**Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.

**28.3.**Хянан шалгах түр хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн, хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй. Түр хороо дүгнэлт гаргаж, шаардлагатай бол тухайн асуудлыг эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлж болно. Түр хорооны дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй. Хорооны хэлэлцсэн баримтыг нотлох баримтад тооцох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

**28.4.**Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” Төслийн заалт байна. Төслийн заалтыг дэмжье гэсэн томъёоллоор.

Үг хэлье. Энэ чинь төслийн заалт. Дараа нь ажлын хэсгийн санал гэж байх ёстой. Гэтэл ажлын хэсгийн санал чинь байхгүй байна. Би юу гэж ойлгох вэ.

Энэ саналыг хойшлуулъя.

## **9.Төслийн 4 дүгээр зүйл буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх заалт:**

**9.1.**Төслийн 4 дүгээр зүйлийн буюу Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь” гэснийг “Улсын Их Хурлын гишүүн нь Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол албан үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль зөрчсөнийг Үндсэн хуулийн цэц тогтоож, эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол тухайн гишүүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэж өөрчлөн найруулах. Энэ давхар дээлтэй холбоотой.

Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжих ёстой заалт.

Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 76.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

**9.2.**Төслийн 4 дүгээр зүйлийн ““Ерөнхий сайд,” гэж,” гэсний дараа мөн заалтын “өөрчлөх,” гэснийг “чөлөөлөх,” гэж нэмэх. Саналыг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар гаргасан.

Саналаа тайлбарлая гэсэн Мөнхбаатар гишүүн. Мөнхбаатар гишүүний микрофоныг өгье. Ирцэндээ орсон уу, хурууны хээгээ уншуулж.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны гишүүдийн амрыг ирье. Энэ Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.1 дэх хэсгийн 6 дахь заалт гэснийг өөрчлөх, чөлөөлөх гэж бас өөрчилье гэсэн ийм санал гаргасан байгаа. Энэ санал бол агуулгын хувьд Үндсэн хуулийн төсөлд бол байхгүй. Гэхдээ Үндсэн хуулийн 25-ын 1.6 дээр Улсын их хуралд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд хуульд зааснаараа Улсын их хуралд ажлаа хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах гэдэг энэ заалтаас нь Засгийн газрын гишүүд гэдгийг нь бол бид авч байгаа. Ийм учраас энэ заалт нь өөрөө хөндөгдсөн заалт юм. Тэгэхээр энэ бол зарчмын зөрүүтэй өөр заалт гарах боломж нь нээгдэж байгаа юм аа. 1 дүгээрт.

Ер нь бас энийг ойлголтыг нь нэг мөр цэгцлээд цаашаа явчих ёстой гэж бодоод байгаа юм. За. Ингэхээр энд ямар зүйл удирдах вэ гэхээрээ 25.1.6 гэдэг энэ Үндсэн хуулийн заалтаас харахад хэлбэрийнхээ хувьд бол одоо Улсын их хурлаас гаргадаг шийдвэрийн томъёоллоор одоо ингээд өөрчлөөд явах нь зүйтэй гэж бодоод байгаа юм. Тухайлбал томилох, огцруулах шийдвэрийг бол явцынх бол гаргаж байгаа юм. Өөрчлөх гэдэг ийм шийдвэр ерөөсөө гардаггүй ээ, Их хурлаас өөрчлөх гэдэг шийдвэр гардаггүй. Чөлөөлөх гэдэг шийдвэр гарч байгаа ш дээ тийм ээ.

За томилох, огцруулах гэдэг бол тодорхой одоо албан тушаалын бүрэн эрх үүсгэх, за, бүрэн эрхийг нь байхгүй болгох ийм хууль зүйн үр дагавартай



маш тодорхой ойлголт байгаад байгаа юм. Гэтэл өөрчлөх гэдэг бол тодорхой албан тушаалтны хувьд нэг хүнийг нөгөө хүнээр солих гэсэн агуулга байгаа юм шиг харагдаж байгаа боловч хэнд ч эрх үүрэг үүсгэхгүй байгаад байгаа юм аа. Эрх үүрэг үүсгэхгүй байгаа юм. Ийм учраас энэ өөрчлөх гэдэг чинь өөрөө огцруулах гэдэг юм уу чөлөөлөх, томилох гэсэн энэ байдлаар одоо томъёологдож явна ш дээ. Их хурлаар ч гэсэн одоо ингээд чөлөөлөгдөх гэсэн шийдвэр гарна.

Ер нь бол тодорхой заадаг ш дээ. Манай Үндсэн хууль дээр чинь түдгэлзүүлэх, халах, чөлөөлөх, огцруулах гэдэгтэйгээ адилхан нэг мөр болгоё оо гэсэн санаа юм байгаа юм. Манай гишүүд бас ойлгоод энийг авчихвал би их зүгээрээ гэж бодож энэ саналыг л гаргасан юм л даа. За ер нь одоо Улсын их хурлаас байгуулагддаг 1 байгууллагыг татан буулгалаа гэхэд тэр байгууллагын даргыг огцруулахгүй тийм ээ, огцруулах шийдвэр огт гарахгүй ш дээ. За ингээд дараач нь томилох шийдвэр байхгүй. Байгууллага нь байхгүй болчихсон байхад. Тэгэхээр түүнийг чөлөөлөх л болно. Хэн нэгэн албан тушаалтныг одоо огцруулаагүй тохиолдолд чөлөөлөх, эрүүл мэндийн шалтгаанаас гэж бодоход чөлөөлөх л шийдвэр гарч таарна ш дээ. Чөлөөлөхгүй бол өөр огцруулах шийдвэр гэж гарч болохгүй. Тэгэхээр огцруулах гэдэг үгээ өөрөө ингээд оруулаад явчихъя аа. Үүгээрээ бас Үндсэн хуулийнхаа нэр томъёог нэгтгэж жигдэлж байгаа юм, 2 дугаарт илүү ойлгомжтой болж байгаа юм. Өөрчлөх гэдэг шийдвэр гардаггүй учраас чөлөөлөх гээд тодорхой бичье ээ гэсэн Ийм санал байгаа юм аа. Ийм учраас манай төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд бас энийг анхаарч үзээрэй гэдгийг хэлье.

**С.Бямбацогт:** За, Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Энэ дээр санал хурааж болохгүй. Буруу юмыг буруу юманд аваачаад тавьчихсан байгаа юм. Мөнхбаатарын ярьж байгаа санал чинь 25 дугаар зүйлийн одоогийн Үндсэн хуулийн 25.1.6-г ярьж байгаа юм. Одоо бид нарын санал хураах гээд байгаа заалт чинь 29 дүгээр зүйлийн заалт дээр ярьж байгаа юм аа. Өөрөөр хэлбэл Улсын их хурлын гишүүний хариуцлагын асуудал ярьж байгаа юм. Мөнхбаатарын саяны ярьсан бол Засгийн газрын болон түүний харьяа байгууллагын бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөхтэй холбоотой асуудал байгаа юм. Мөнхбаатар гишүүний саналыг 1 дүгээрт нь яривал түрүүн тэр Мөнх-оргил гишүүний Засгийн газрын гишүүнийг хасна гэдэг үгтэй хамт санал хураагдах ёстой. Урд. 1 дүгээрт тэр.

2 дугаарт болбол ийм нэг юм байгаа юм. Яах вэ Мөнхбаатар гишүүн бол өөрчлөх гэдэг үгийг чөлөөлөх гэдэг үгээр сольё гээд байгаа юм. Өмнө нь нэг ийм үг байгаа юм аа. Байгууллагын бүрдэлдэхүүнийг гэж байгаа юм. Тэгэхээр бүрэлдэхүүнийг өөрчлөх бас асуудал байж болно. Бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөх асуудал байхыг үгүйсгэхгүй. Тийм учраас болбол энийг бодвол энэ 92 онд хэлэлцэж баталж оруулахдаа бүрэлдэхүүнийг өөрчлөх асуудал байх тохиолдолд хариуцлагаа тайлагнадаг байгууллагын бүрэлдэхүүн гэж байгаа учраас бүрэлдэхүүн гэдгээр нь авч үзэх юм болбо өөрчлөх гэдэг үг байж болохоор байгаа юм.

Албан тушаалтны хувьд ярих юм болбол өөрчлөх гэдэг үг байж болохгүй байж болох юм байгаа юм. Тийм учраас бодвол энэ 92 онд бол энийг би бүрэлдэхүүнийг гэдэг агуулгаар нь оруулж ирсэн юм болов уу гэж бодож байгаа

юм. Тийм учраас би Бямбацогт даргыг Мөнхбаатар гишүүний саяны саналыг яривал тэр өмнөх санал дээр очиж ярих ёстой гэж бодож байна.

**С.Бямбацогт:** За, ойлголоо бас. Энэ дээр бас Мөнхбаатар гишүүн санал гаргасан тэгээд сая бас ойлголцох зарим зүйл заалтыг эргэж ярих шаардлагатай байгаа учраас энэ саналыг хойшлууллаа.

Одоо төслийн заалтаар Мөнхбат гишүүн түрүүн бас хэлсэн. Төслийн заалтаараа санал хураачихъя. Уул нь татсан гэж та нар ойлгосон юм байна лээ ш дээ. Дахиад та хэд дахиад ярилцчихаарай. Уул татахаар ярьсан гэж ярилцсан сая. Татахгүй гэж байна тэгээд. Тийм.

За. 29.1. Улсын их хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын их хурлын гишүүн нь Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол албан үүрэгт нь үл хамаарах ажил албан тушаалыг хавсарч болохгүй ээ. Зөв үү төслийн заалт мөн үү. Одоо энүүгээр санал хураалт явна. Төслийн заалтаа бид нар ажлын хэсгийн заалт дэмжигдсэн. За. Мөнхбат гишүүн.

**Ж.Мөнхбат:** Энэ өмнө нь санал хураасан 9.1-тэй холбогдуулж энэ зүйлийг ярьж байх шиг байна аа гэж олгож байгаа. Төслийн заалтаа одоо санал хурааж, хураах ёстой гэсэн ийм зарчмын байр сууринаас орж ирж байна гэж ойлгож байна. Ер нь бол энэ төслийн 9.1 буюу Үндсэн хуулийн одоо 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг бол энэ ажлын хэсгийн саналаар бол сайжруулсан. Сая Улсын их хурлын гишүүд тойрогтоо ажилласан, ард түмэн иргэд сонгогчдоосоо захиа даалгаврыг нь авсан. Хэлэлцүүлэг хийсэн.

Энэ дээр бол энэ Үндсэн хуулийн төсөл дээр бол Улсын их хурлын гишүүнийг эгүүлэн татдаг, хууль зөрчсөн бол Үндсэн хууль зөрчсөн бол эгүүлэн татдаг заалт энэ нэмэлт өөрчлөлт чинь орж ирээгүй байна аа гэсэн энэ асуудал яригдсан учраас энэ намын бүлэг, олонхын бүлэг дээр ярьж байгаад за ажлын хэсэг дээр ярьж байгаад энэ Улсын их хурлын гишүүнийг эгүүлэн татдаг ийм саналын заалт орж ирж байгаа. Улсын их хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль зөрчсөнийг Үндсэн хуулийн цэц тогтоож, эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол тухайн гишүүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын их хурлын гишүүд Их хурал 2/3-ын доошгүй саналаар хэлэлцэн шийдвэрлэнэ гэсэн ийм заалт орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ заалт батлагдсантай холбогдоод төслийн заалтыг ..... юм байна аа. Санал хураах юм байна аа гэж ойлгож байна. Тийм.

**С.Бямбацогт:** За гишүүд бас зөв ойлгоорой. Энэ Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал болбол Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу хэлэлцэгдэж байгаа. Энэ хуулиараа бол үнэхээр нарийн дэгтэй. Урьд нь бид нар дэмжсэн санал, дэмжээгүй санал гээд нэг нэг удаа хураагаад явчихдаг бол энэ чинь дэмжсэн биш тийм үү, гарсан саналуудыг хамтатгаж хэлэлцэнэ. Хамтатгаж хэлэлцэхдээ дэмжээгүй бол дахин 3 удаа санал хураана гээд маш одоо ойлгомжгүй заалтуудтай. 2011 онд батлагдсанаас хойш анх удаа хэрэглэж байгаа. Тийм болохоор бас нэг жоохон шинэ хэрэглэж байгаа болохоор жоохон үл ойлголцох асуудлууд гарч байж магадгүй шүү. Түүнийг бас зөв ойлгоод санал хураалтаа цааш нь үргэлжлүүлье ээ. За төслийн заалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

За санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 100хувийн саналаа энэ санал дэмжигдсэнгүй ээ.

2. Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт өөрчлөлт. 2 дугаар бүлэг. Багц санал хураалтууд орж ирж байна. Бид нар түрүүнд горимын санал Лүндээжанцан гишүүний горимын саналаар бүлэг, бүлгээр нь багцлаад саналаа хураая гэсэн байгаа. За төслийн 1.

Төслийн 3 дугаар зүйлийн 6 дах заалт буюу 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг 1.

“Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” Гэсэн төслийн заалт байна аа. Үүнтэй холбоотой бас нэлээнд олон санал гарсан. Тийм болохоор энийг бас давхар дээлтэй байх эсэх асуудал хөндөж байгаа. Энийг бас ойлголцол бий болгоё. Өшөө сайн ярилцъя гэдэг үүднээс энэ санал хураалтыг хойшлууллаа.

За. 2. Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 3 дах хэсэг:

“3.Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.

Төслийн заалт. За дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 39.3. Тийм дэмжих юм.

За. 13 гишүүн санал хураалтад оролцсоноос, 69.2 хувийн саналаар буюу 9 гишүүн энэ саналыг дэмжлээ. Энэ санал дэмжигдлээ.

За, 2.1. Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “өөрөө” гэснийг “шууд” гэж өөрчлөх.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар гаргасан санал. Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй. Мөнхбаатар гишүүн саналаа тайлбарлаад татна гэсэн тээ. За тайлбарлая.

**Л.Мөнхбаатар:** Тэр биз дээ. За. За уг зарчмын зөрүүтэй санал гаргасан гэхдээ ажлын хэсэг дээр Лүндээжанцан гишүүний бид хамтран сууж байгаад уг саналыг ажлын хэсгийн саналын томьёололтой нэгтгэхээр болсон тул уг саналаа татаж байна аа.

**С.Бямбацогт:** За баярлалаа. За 2.

“Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна.” Төслийн заалт. Ажлын хэсгийн санал байгаа тийм ээ араас нь. За санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор.

Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Лүндээжанцан гишүүний карт хурууны хээ санал хураах төхөөрөмж ажиллахгүй гацаж байна гэж байна шүү. Техникийнхэн.

2.1. Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

За, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

За төслийн 2.2. Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил.  
Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй.

Саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 буюу 90 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй ээ.

**За. 3. Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1. Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулж, шинэ Ерөнхий сайдыг томилох тухай саналыг хамтад нь албан ёсоор тавивал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонх уг саналыг дэмжсэн бол шинэ Ерөнхий сайдыг томилох, өмнөх Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцно.” Төслийн санал. Аан энэ чинь ажлын хэсгийн санал ш дээ тийм ээ. За. Мөнхбат гишүүн

**Ж.Мөнхбат:** За энэ Үндсэн хуулийн 43.1 дэх хэсэг дээр их ноцтой заалт орж ирсэн байгаа юм аа. Улсын их хурлын гишүүний ¼-ээс доошгүй нь гэж 19 гишүүн гарын үсэг зураад Ерөнхий сайдыг огцруулахдаа шинэ ерөнхий сайдыг хамтад нь албан ёсоор нэр дэвшүүлнэ гэж байгаа юм. ИНгээд Ерөнхий сайд огцрох юм бол тэр хамтад нь нэр дэвшүүлж оруулж ирсэн Ерөнхий сайд автоматаар томилогдоно. Ерөнхий сайд болох. Ийм агуулгатай заалт орж ирсэн. Энэ бол өөрөө Засгийн газрын бүр тогтворгүй болгож байгаа юм. өөрөөр хэлбэл Үндсэн хуульд байгаа бусад хуулиудад байгаа сонгуульд ялалт байгуулсан нам, эвсэл Ерөнхий сайдаа томилж Засгийн газраа томилно оо гэсэн энэ агуулга энэ заалтаар алдагдаж байгаа.

Яаж алдагдаж байгаа вэ гэхээр жишээлбэл Улсын их хурлын сонгуулийн дүнгээр 39, 40, 41, 42 орчим одоо суудалтай 1 нам эвсэл ялалт байгуулсан нөхцөлд өмнө Засгийн газрыг огцруулахад цөөнхийн одоо гишүүдтэй тухайн намаас нэг 2, 3-хан хүн 1 хүн Ерөнхий сайд болно. САЙД болно гэж одоо муугаар ярих юм бол урваад ингээд энийг өргөн барьчих юм бол нөгөө нам,

эвсэл сонгуульд ялсан нам, эвсэл Ерөнхий сайд аа томилж Засгийн газраа байгуулж чадахгүй, автоматаар нөгөө хуйвалдаанд орсон 1, 2 гишүүн цөөнхтэй хуйвалдсан гишүүн Ерөнхий сайд болоод цөөнхөөсөө Засгийн газар нь томилогдоод Засгийн газар нь томилогдоод явах ийм нөхцөл байдал үүсэж мэдэхээр ийм ноцтой заалт орж ирсэн. Тийм учраас энэ алдааг бид нар засах ёстой гэж бодож байгаа.

Парламентын засаглалаа бэхжүүлбэ, Засгийн газрын бодлого тогтвортой байдлыг цаашдаа хангая гэдэг энэ зарчмыг бид нар барья гэж байгаа бол энэ хуулийн сонгуулийн үр дүнгээр олонх болсон нам, эвсэл нь Засгийн газраа байгуулдаг, Ерөнхий сайд аа томилдог. Нам дээрээ эвсэл дээрээ дараагийн асуудлаа ярьдаг энэ асуудал байхгүй болох ийм ноцтой заалт орж ирж байгаа. Тийм учраас энэ дээр албан ёсоор санал гаргаж байгаа. Өөрөөр хэлбэл энэ заалтын шинэ Ерөнхий сайдыг томилох тухай хамтад нь гэдгийг хасах энэ заалтаас. Дараагийн өгүүлбэр дээрээс шинэ Ерөнхий сайдыг томилох, өмнөх гэдэг гэдэг энэ үгийг хасах гэсэн. өөрөөр хэлбэл Улсын их хурлын гишүүдийн ¼-ээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулж, огцруулах саналыг албан ёсоор тавивал Улсын их хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын их хурлын нийт гишүүний олонх уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын их хурлын тогтоол батлагдсанд тооцно гэсэн ийм саналыг одоо гаргаж байна аа. Энийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

За. Мөнхбат гишүү бас сая саналаа тайлбарлаж хэллээ. Тодорхой өөрчлөлт оруулах санал байгаа. Мөнхбаатар гишүүн бас үүнтэй холбоотой санал гаргасан байгаа. Оюунчимэг гишүүн бас санал гаргасан байгаа. Тийм болохоор энэ асуудлыг бас дахиад ажлын хэсэг сайн ярилцъя. Энэ саналыг хойшлуулъя аа.

**За. 4. Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу Дөчин зургаадугаар зүйлийн 4 дэх хэсгийн хэсэг:**

“4.Төрийн жинхэнэ алба нь мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай байх, шатлан дэвших зарчимд үндэслэнэ. Төрийн албан хаагчийг улс төрийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, сонгуулийн үр дүнгээр, эсхүл хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, халахыг хориглоно. Төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилтэд тавих хяналт хараат бус байна.” гэсэн төслийн заалт байна. Энэ төслийн заалтыг за, Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** За энэ заалтыг дэмжиж байгаа. Би зүгээр түрүүчийн Мөнхбат гишүүний хэлсэн дээр ажлын хэсэг тэр асуудлыг авч үзэхдээ би болбол өмнөх Ерөнхий сайд огцруулаад дараагийнх нь шинийг нэрийг хамт оруулж ирэх тэр ерөнхий зарчмыг дэмжиж байгаа. Гэхдээ саян нөгөө Мөнхбаатар гишүүний ярьсан сонгуульд ялалт байгуулсан нэм олонхоо хадгалж байх тэр заалтыг нь хамтад нь гэдгийнхээ өмнө нэмж оруулаад л шинэ Ерөнхий сайдыг томилох тухай саналаа Үндсэн хуулийн одоо тэд тэр тэр зарчмуудыг гээд. Эсвэл дугаараар нь эсвэл нөгөө одоо хамгийн олон суудал авсан нам олонх болсон нам гээд юу бий ш дээ тээ. Тэрний дагуу бий болгоод оруулж ирээд за хуучин ингээд огцруулж байгаа, шинийг нь энийг оруулж байгаа. Энийг ярихдаа яг тэр хуучин зарчмаараа ингээд сонгоод гаргаад ирсэн юм аа гэсэн юмтай нь хамт оруулчихвал хамтдаа байх асуудал нь хөндөгдөхгүй дэмжигдээд явах юм байгаа шүү. Ажлын хэсэг анхаараарай гэж хэлэх гээд байгаа юм. Тийм. Тэрийг хэлсэн шүү.

**С.Бямбацогт:** За төслийн заалт, дараа нь ажлын хэсгийн санал байгаа. Төслийн заалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар буюу 11 гишүүн энэ саналыг дэмжсэнгүй. За дараагийн санал хураалт.

**4.1.** “4.Төрийн жинхэнэ алба нь мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай байх, шатлан дэвших чадахуйн зарчимд үндэслэх бөгөөд түүний хэрэгжилтэд хяналт тавих байгууллага хараат бусаар ажиллана. Төрийн жинхэнэ албан хаагчийг хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, халахыг хориглоно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар.

За санал хураалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар буюу 81,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

За, Энх-Амгалан гишүүн саналаа татсан гэсэн тийм ээ. Энийг санал хураах шаардлагагүй.

За. **4.3.** “4. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн Дөчин зургаадугаар зүйлийн 4 дэх хэсгийн “шатлан дэвших” гэснийг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй.

За санал хураалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 100 хувийн саналаарэнэ санал дэмжигдсэнгүй ээ.

**5. Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“Ерөнхийлөгчөөр тавин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.”

Төслийн заалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 4 гишүүн буюу 36,4 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Төслийн ижил заалтууд хоёулаа дэмжигдэхгүй болбол Үндсэн хуулийн заалт нь хэвээрээ үлдэнэ. Хоёулаа дэмжигдэх юм болбол 3 дах хэлэлцүүлэг дээр найруулгын хувьд, утга агуулгын хувьд бас цэгцлэх асуудлыг бас байнгын хороон дээр хийгдэнэ тийм.

За. Дараагийн санал.

**5.1.** Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавин таван” гэснийг “тавин” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь, М.Оюунчимэг. /Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй, Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй, Өргөдлийн байнгын хороо дэмжсэн/.

Энэ саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 63,6 хувь. 2/3 арай хүрсэнгүй юу.

За санал дэмжигдсэн байна аа. Дэмжигдсэн байна.

За. Энэ яасан бэ. Сая 63 хувь гэсэн шүү тийм ээ. За санал хураалтыг дахин явуулъя. Шаардлагатай бол 3 удаа санал хураалт явуулах бололцоотой байгаа. За тэгвэл горимын санал гаргачих. Гараа өргөх юм бол нэгбүрчлэн тоолоод ингээд цаг их алдана шүү дээ. За дахиад санал хураалт. 3 хүртэл удаа хураах бололцоотой.

5.1.Төслийн 3 дугаарх зүйлийн 4 дэх заалт буюу 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 55 гэснийг 50 гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Оюундарь, Оюунчимэг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй, Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухаан байнгын хороо дэмжээгүй, Өргөдлийн байнгын хороо дэмжсэн. Санал хураалт, дэмжье гэснээр нь санал хураалт. Одоо дахиад хураана уу тийм үү? Үгүй дахиад нэг хураана, тийм. Адилхан 1 татгалзсан, 1 яасан тийм. Дахиад саяын томъёоллоор санал хураалт явуулъя. Цөөнх болно гэж. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 72,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 2 удаа олонхын дэмжлэг авсан. 3 удаа санал хураасан. Энэ санал дэмжлээ.

Одоо төслийн 1 дэх заалт бас дэмжигдээгүй. Тэнд энэ саналаар бас дахиж санал хураалт явуулна. Ерөнхийлөгчөөр 55 нас хүрсэн. Сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан Монгол Улсын уугуул иргэнийг 6 жилийн хугацаагаар зөвхөн 1 удаа сонгоно. Төслийн заалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 4 гишүүн буюу 36,4 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. 2 удаа дэмжигдээгүй учраас 3 дахь санал хураах шаардлагагүй.

6 дахь санал. Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно.” Төслийн заалт, дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Хуруугаа муу буруу ашигладаг л, за 11 гишүүн санал хураалтад оролцсоноос 9 гишүүний буюу 81,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Эхний санал хураалтаар дэмжигдсэн тохиолдолд шууд дараагийн санал хураалт явна. Дэмжигдээгүй тохиолд дахиж санал хураалтууд явагдана.

6.1 Мөнхбаатар гишүүн саналаа татъя гэсэн тийм ээ, тайлбарлах уу?  
6.1.Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “энэ зүйлд” гэснийг “Үндсэн хуульд” гэж өөрчлөх санал, Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар гаргасан. Мөнхбаатар гишүүнд микрофон өгье.

**Л.Мөнхбаатар:** Энэ яах вэ бид бас Байнгын хорооны хурал дээр бас тэмдэглүүлээд энэ ойлголтоо нэг мөр болгоод цаашаа явъя гэж одоо ажлын хэсэг бид нар бас ярьсан. Лувсанжав гуай, Бямбацогт гишүүн бас эрдэмтдийн төлөөлөлттэй өчигдөр суусан. Гэхдээ энийг бол ойлголтоо бас тэмдэглэж үлдээх нь бас цаашдаа уг энэтэй холбоотой асуудлыг Цэц одоо хэлэлцэх гэдэг юм уу олон дараагийн хуулиудыг одоо боловсруулах хэлэлцэх, шийдвэрлэхэд бол чухал юм гэж үзэж бас энэ дээр бас үг хэлье гэж бодож байгаа юм.

Ер нь бол энэ төслийн 33.4 дэх заалтад бол Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг энэ зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно гэж ийм заалт тусаж байгаа. Үүнийг бол энэ 33 дугаар зүйлийн одоо энэ заасан 12 тодорхой бүрэн эрх л Ерөнхийлөгчид олгож болно. Харин Үндсэн хуулиар олгогдсон бусад бүрэн эрхийн хүрээнд бол Ерөнхийлөгчид эрх олгох боломжгүй юм байна гэж би одоо ойлгож байгаа. Тухайлбал одоо 51 дүгээр зүйл дээр Ерөнхийлөгч шүүгч нарыг батламжлах 56 дугаар прокурор, Ерөнхий прокурор орлогч нарыг одоо томилох, мөн 33 дугаар зүйл дээр бол одоо Их Хурлын тараахтай холбоотой ч гэдэг юм уу за энэ ийм олон бүрэн эрхүүд бол Үндсэн хуулийн бусад зүйлүүдэд байгаа юм. Тэгээд эдгээрийг бол зөвхөн энэ 33.4 дэх хэсэг гэж одоо бас хязгаарлаж өгч байгааг нь бол би бас ажлын хэсгээс бас энэ дээр Лувсанжав гуай эд нар чинь бас тайлбараа хэлээд ингээд протоколдож үлдээх нь зүйтэй юм гэж. Тэгэхгүй бол ахиад бас Ерөнхийлөгчид хуулиар эрх нэмж олгодог энэ асуудал маань цаашаа үргэлжлээд яваад байх юм бас боломжтой байж магадгүй учраас энийгээ хэлээд байгаа юм. Тэгэхээр ямар ч байсан 33 дугаар зүйлд заасан энэ 12 бүрэн эрхийн хүрээнд бол Ерөнхийлөгчид бусад хуулиар бүрэн эрх олгож болно гэж ойлгож байгаа юм.

Үндсэн хуулийн 22, 51, 56 дугаар зүйлүүдэд заасан одоо Их Хурлыг тараах, шүүгчийг батламжлах, Ерөнхий прокурор, орлогч нарыг томилох энэ бүрэн эрхийг бол Ерөнхийлөгч Үндсэн хуульд заасан хүрээнд л хэрэгжүүлэх юм байна. Цаашаа ингээд бусад хуулиар задалж болохгүй гэсэн эрх олгож ийм заалтуудыг нэмж болохгүй гэсэн ийм санаа байна гэж ойлгож байгаа юм. Ийм учраас бас энэ дээр бас ажлын хэсгээс тайлбарыг нь аваад ойлголтоо нэгтгээд цаашаа явах нь зүйтэй гэж үзэж асууж байгаа юм.

**С.Бямбацогт:** Өчигдөр бас Мөнхбаатар гишүүн, Лувсанжав гуай эд нар бас ярилцсан энэ тал дээр. Лувсанжав гуай та тайлбар хийчих үү ажлын хэсгийн дэд ажлын хэсгийн ахлагч. Ер нь гэхдээ бас тайлбар бас заавал хийгдэх ёстой. Яагаад энэ гэвэл энэ тайлбартай холбоотойгоор цаашдаа бусад Үндсэн хуультай салбарлаад гарах тийм үү хуулиуддаа бид нар тодорхой зохицуулалтуудыг хийнэ. Тийм болохоор бас ямар ойлголтоор Үндсэн хуулийг хэлэлцэж байх үед энэ одоо санал гарсан юм бэ гэдгээ бас тайлбарлаад цаашдаа үүн дээр тулгуурлаж органик хууль болон бусад хуулиудаа хийх ёстой. Түүн холбоотой бол тайлбар хийчихье.

**Н.Лувсанжав:** Энэ сая Мөнхбаатар гишүүн сая өөрөө сая бол бид ойлголцсоныг тайлбарлачихлаа л даа. Үндсэн хуулийн 33 дугаар зүйл бол та бүхэн уншвал Ерөнхийлөгч дараах үндсэн бүрэн эрхтэй байна гээд 12 зүйл 10



хэдэн зүйл тоочсон байгаа юм. Тэгэхээр энэ үндсэн бүрэн эрхийн хүрээнд тодорхой бүрэн эрхийг олгох нь бол болох юм. Өөрөөр хэлбэл тэгж хязгаарлаж байгаа юм. Тэр бусад зүйлүүдэд Ерөнхийлөгчид олгож байгаа эрхүүд бол Ерөнхийлөгчид тухайлан олгосон тодорхой эрхүүд байхгүй юу. Тэрийг ахиж дэлгэрүүлэх юм уу нэмэгдүүлэх тийм маягийн ю бол хийж болохгүй. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулиар зөвхөн энэ шүүгчийн томилгоотой холбоотой зөвхөн л энэ эрхийг Ерөнхийлөгч эдэлнэ шүү гэдэг юм байгаа шүү дээ. Тийм учраас тэр зүйлүүдийг дэлгэрүүлж тодорхой бүрэн эрх нэмж олгох асуудал бол хориотой юм. Үндсэн бүрэн эрхээ задалж тодорхой бүрэн эрхийг олгох нь бол нээлттэй байх юм гэдэг утгаар энийг ойлгож байгаа юм.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Мөнхбаатар гишүүн.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэгтэй энэ ойлголтоо нэгтгэсэн учраас уг саналаа татаж авч байна.

**С.Бямбацогт:** Баярлалаа. 3. 3 дахь багц асуудал руугаа орж байгаа. Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж хараат бус байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалт:

“1/Шүүхийн ерөнхий зөвлөл арван гишүүнээс бүрдэнэ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллана;” төслийн заалт. Санал хураалт дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 72.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 1.1 хураалтаа зөв хийцгээгээрэй тэгээд.

1.1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын “арван гишүүнээс бүрдэнэ.” гэснийг “арван таван гишүүнээс бүрдэнэ.” гэж өөрчлөх, санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд, Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 90,9 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

1.2.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын “бүрдэнэ” гэснийг “бүрдэх бөгөөд ажлаа Улсын дээд шүүхэд танилцуулна.” гэж өөрчлөх, санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батнасан, Бямбацогт, Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй. Энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Батнасан гишүүн санаалаа тайлбарлаж үг хэлье.

**О.Батнасан:** Гишүүдийн амгаланг айлтгая. Ер нь энэ Монгол Улсын шүүхийн засаглалтай холбоотой асуудал дээр нэлээд одоо анхаарч Үндсэн хуулиараа шүүх засаглалын ажлыг сайжруулах ёстой гэсэн ийм бодлогыг барьж оруулж ирж байгаад бас хууль санаачлагч ажлын хэсгийнхэнд бол баярлаж байгаа. Ер нь шүүх бол ийм болчихоод байгаа юм. Энэ Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн хариуцлагын зөвлөл гэсэн ийм одоо олон салаа болчихоод байгаа. Одоогийн байдлаар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл ажил ерөөсөө хоорондоо уялдаа холбоо муутай байдаг. Ер нь

бол Шүүхийн ерөнхий зөвлөлийг бид бол Тамгын газар л гэж ойлго хэрэгтэй. Тийм учраас Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхэд ажлаа тайлагнадаг биш ядаж танилцуулдаг байя гэсэн ийм заалтыг л оруулсан. Тэгээд гишүүд та бүхэн одоо энэ заалтыг бас дэмжээд өгвөл сайн байна. Монгол Улсад шүүхийн засаглалыг сайжруулах юм бол бид эрхт зүйлт төрд амьдарч байгаагийн утга учир оршино гэдэг зүйлийг л хэлж байгаа юм.

Би бол их олон санал гаргасан. Миний анхны санал бол шүүхийн анхан шатны шүүхийн шүүгчийг ард түмнээс сонгоё гэдэг санал байсан. Тэгээд ажлын хэсэгтэй ярилцаад одоо энэ саналаа татсан. Харин одоо энэ шүүхийн ажлын уялдуу холбоог сайжруулах хоорондоо уялдаа холбоотой ажиллаж шүүх засаглалыг сайжруулахад Улсын дээд шүүхийн ерөнхий зөвлөл хамтраад ажиллах юм бол бас нэлээд ахиц дэвшил гарах ийм заалт байгаа юм. Тэгээд та бүхнийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Батнасан гишүүний саналыг дэмжье. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 4 гишүүн буюу 36,4 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Дахин санал хураалт явуулна. Дэмжигдээгүй санал дээр 3 хүртэл удаа санал хураана. Дахиад Мөнхбат гишүүн.

**Ж.Мөнхбат:** Энэ Шүүхийн ерөнхий зөвлөлтэй холбоотой асуудал тийм үү? Шүүхийн ерөнхий зөвлөл энэ шүүхийн хариуцлагын зөвлөл гээд нэмэгдэж байгаа, Дээд шүүх гээд ингээд 3 толгойтой юм болж хувирч байна шүү дээ ер нь шүүх орчин чинь тийм үү Цогт шүүгчээ. Тэгэхээр энэ бие биедээ тайлагнах танилцуулах хоёрын хоорондын ялгаа юу байна вэ гэдэг дээр нэг тайлбар авмаар байх юм. Одоо яг энэ заалт дээр юу байна вэ тэр дараагийнхаа 55.1 дээр байсан уу тэгээд энэ хоёр заалтаа нэг тайлбарлаад өгчхөөч. Бие биедээ танилцуулах тайлагнах гэсэн юмаа.

**С.Бямбацогт:** 1 дүгээр микрофон улсын Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүгч Цогт.

**Ц.Цогт:** Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр төслийг өргөн барихтай холбогдуулаад судлаачдын дэд ажлын хэсэг гэж ажилласан. Дэд ажлын хэсгийн санал болгосон хувилбар бол шүүх эрх мэдлийн байгууллагыг өөрийг нь бие даалгаж ажиллуулахад гол үүрэг гүйцэтгэдэг энэ Шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг байгууллагын бүрэлдэхүүнийг бол 50+1 шүүгчдийн өөрсдийнх оролцоотойгоор ийм байдлаар санал болгосон. За энэ маань томъёоллын ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг дээр бол 50, 50 болж өөрчлөгдсөн. Үүнтэй уялдуулаад Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэй болохынх нь хувьд Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн зөвлөгөөнд энэ чиг үүргээ Үндсэн хуулиар хүлээсэн чиг үүргээ танилцуулдаг байвал энэ эрх мэдлийн байгууллагууд ажил нь уялдаж явах юм гэсэн ийм санаачилгыг бол гишүүдийн гаргасан санал дээр үндэслээд дэд ажлын хэсэг бол санал болгосон.

Тэгэхээр зарчмын хувьд бол тайлагнах гэдгийг бол манай ажлын хэсэг дээр яриад энэ бол одоо Дээд шүүх хэтэрхий одоо оролцоотой болж болзошгүй учраас уялдааг хангахын тулд танилцуулах гэдэг үгээр томъёолбол зохистой гэж ингэж санал гаргасан.

**С.Бямбацогт:** Тайлбар хийлээ. Саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 81,8 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Дараагийнх нь.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалт:

“2/Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нэр дэвшүүлэн томилгооны сонсгол хийж, Улсын Их Хурал хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар томилно. Тэдгээр нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэн байна;” төслийн заалт. Энэ дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

2.1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтын эхний өгүүлбэрийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн гурвыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, нэгийг Засгийн газар, нэгийг мэргэжлийн холбооноос тус тус нээлттэйгээр нэр дэвшүүлж, Улсын Их Хурал томилгооны сонсгол хийн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар томилно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 10 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 80 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.2.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтын эхний өгүүлбэрийг “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо” гэснийг “Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүдийн гурвыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо” гэж өөрчлөх, санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батнасан Хууль зүйн байнгын хороо дэмжсэн. Батнасан гишүүн тайлбар хэлэх үү тийм ээ.

**О.Батнасан:** Тийм хууль зүйн Байнгын хороон дээр миний дэмжсэн саналыг ажлын хэсгийн саналд оруулсан учраас энэ саналаар санал хураах бол шаардлагагүй л гэж үзэж байна. Татаад авч байна.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Саналаа татаж авлаа гишүүн.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

“6.Шүүгчийн хариуцлагын зөвлөл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон бусад шийтгэл ногдуулах, чөлөөлөх шийдвэр гаргана.” Төслийн заалт. Саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 10 гишүүн санал хураалтад оролцсоноос 8 хувь буюу 80 хувийн саналаар 8 гишүүн буюу 80 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Шүүгчийн хариуцлагын зөвлөл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах шийдвэр гаргана. Уг шийдвэр нь Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэг, дөчин есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх маргааныг хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан өргөдлөөр Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, Улсын Их Хурлын Раднаасэд гэсэн байна. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 90,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 2 санал дэмжигдсэн учраас төслийн заалтаар дахиж санал хураалт явуулъя.

Төслийн заалт. “6.Шүүгчийн хариуцлагын зөвлөл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон бусад шийтгэл ногдуулах, чөлөөлөх шийдвэр гаргана.” Төслийн заалт. Санал хураалт дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Одоо дахиад ажлын хэсгийн саналаар дахиж санал хураалт явуулна.

“6.Шүүгчийн хариуцлагын зөвлөл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах шийдвэр гаргана. Уг шийдвэр нь Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэг, дөчин есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх маргааныг хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан өргөдлөөр Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Дахиад бас ярих л ёстой юм байна лээ биз дээ.

**Д.Лүндээжанцан:** Сая ажилласан санал юм байгаа биз дээ?

**С.Бямбацогт:** Тийм. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 90,9 хувийн саналаар буюу 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. 2 дахь санал дэмжигдсэн учраас 2 дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын Дөчин есдүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

“7.Шүүгчийн хариуцлагын зөвлөл есөн гишүүнтэй байна. Тэдгээрийн гурав нь шүүн таслах ажлын туршлагатай хуульч, гурав нь хууль зүйн эрдэмтэн; гурав нь иргэдийн төлөөлөл байна. Зөвлөлийн гишүүд нь зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно.” Төслийн заалт.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Энэ санал хураалтыг хойшлуулъя тэгвэл. Хойшлууллаа.

Өчигдөр бид нар энийг ярьсан шүү дээ. Раднаасэд гишүүний гаргасан саналаас Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн гишүүдийн гурвыг мэргэжлийн холбоо, гурвыг шүүх таслах ажлын туршлагатай хууль дотроосоо, гурвыг Улсын Их Хурлаас бүрдүүлнэ гэдгээ эргэж сайн ярилцаад томьёоллоо оруулж ирье гэсэн. Томьёоллоо бэлдэж оруулж ирээгүй байна. Урд талын санал дээр чинь

Хууль зүйн эрдэмтэн гэдэг чинь хэнийг хэлэх гээд байгаа юм иргэдийг яаж сонгох гээд байгаа юм бэ бөөн маргаан гарсан шүү дээ. Ингээд яриад эргэж ярья гэсэн асуудлаа тэгээд орж ирчхээд яриад байх юм. Хойшлуулсан.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын Дөчин есдүгээр зүйлийн 8 дахь хэсэг:

“8.Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах бусад шаардлагыг хуулиар тогтооно.” Төслийн заалт. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад 10 гишүүн оролцсоноос 11 гишүүн оролцсоноос 90,9 хувийн саналаар буюу 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

5.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүгчдийн хариуцлагын зөвлөл ажлаа Улсын Дээд Шүүхэд тайлагнана.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй. Дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Тийм.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар буюу 11 гишүүн дэмжсэнгүй.

5.2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүгчийн хариуцлагын зөвлөл ажлаа Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд тайлагнах бөгөөд тэдгээрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” Санал гаргасан Улсын Их Хурлын Мөнх-Оргил Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалтын Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, хорин нэгэн шүүгчээс бүрдэнэ.” Төслийн заалт. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 90.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.1.төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь буюу 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 21-н гэснийг хасах. Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар санал гаргасан. Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй.

Мөнхбаатар гишүүн саналаа тайлбарлаж үг хэлье.

**Л.Мөнхбаатар:** Улсын дээд шүүхийн шүүгчдийн тоог одоогийн бидний хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуулиар тогтоодоггүй ээ. Шүүхийн тухай хуулиараа тогтоогоод явж байгаа. Одоогийн Шүүхийн тухай хуулиар бол 24 шүүгч, даргатайгаа нийлээд 25 шүүгчтэй ажиллаж байгаа юм. Гэтэл үүнийг 4-өөр бууруулахаар оруулж ирээд байна л даа, нэгдүгээрт. Тэгэхээр тэр 4 шүүгч одоо огт ажилгүй байгаад байсан болоод, ачаалалгүй болохоор нь 4-өөр бууруулж байгаа юм уу, үүний үндэслэл нь огт харагдахгүй байна. Итгэл үнэмшилтэй хариулт авч чадахгүй байгаад байна, нэгд.

Хоёрдугаарт, хяналтын шатны шүүхийн шүүгч нарын ачаалал маш их өндөр байгаа. Захиргаа, эрүүгийн танхим бол жилдээ 500 гаруй хэрэг шийдэж байна, иргэн бол бүр мянга гаруй хэрэг шийддэг. Нэг Дээд шүүхийн шүүгчид хянаж байгаа хэргийн хувьд 250 орчим байна гэсэн статистик байгаа юм билээ. Ингээд үзэхээр маш их өндөр ачаалалтай ажиллаж байгаа юм, одоо. Гэтэл цаашид одоо энэ 20 жилийн хугацаанд тогтвортой үйлчлэх ёстой Үндсэн хууль. Энэ 20 жилийн хугацаанд хэрэг маргаанууд мэдээж нэмэгдэнэ, хүн амын тоо өсөж байна, иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилж байна. Хэрэг маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх ийм чиг хандлагатай болж байгаа, ихэнх нь. Ийм тохиолдолд цаашаа нэмэгдэх тохиолдолд Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах ийм шаардлага гарна, Дээд шүүхийн шүүгчдийн тоог нэмэхийн тулд. Гэтэл одоо үүнийг зөвхөн энэ тоо өөрчлөхийн төлөө Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад байж болохгүй ээ, нэг.

Хоёрдугаарт, шүүгчдийн хувьд энэ тоог нь заахгүйгээр шүүхийнхээ хуулиар явж байгаа энэ өнөөдрийнхөө системээр явахад огт болохгүй юм байхгүй гэдгийг хэлье. Ийм учраас үүнийг бас манай Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд бас дэмжиж өгөөч ээ гэдгийг хэлье гэж бодож байна. Ер нь бол энэ дээр нэг ийм зүйл байгаа юм.

Одоо 24 байгаа үүнийг чинь 8, 8-аараа танхим болоод явдаг, 3 танхимтай. Гэтэл тэнд өвчтэй, чөлөөтэй, шүүгчээс татгалзсан ийм тохиолдол гарвал одоо энэ 8-ыг чинь 7 болгоод буулгачихвал харин ч бүр тэр танхим маань хуралдаж чадахаа байчихна шүү дээ. Энэ зүйлийг би бас хэлэх гэсэн юмаа. Ийм учраас ямар ч үндэслэлгүйгээр 4-өөр бууруулж байгаа, дээр нь энэ тоог тавих ямар шаардлага байгаа юм бэ? Ийм учраас үүнийг гишүүд анхаарч үзээч. 21 болгоод байгаа нь өөрөө үндэслэлгүй байна, дээр нь 7 шүүгчтэй болохоор улам төвөгтэй байдалд орно. Одоо хүртэл зарим танхимуудын хувьд хурлаа хийхэд хүндрэлтэй байна шүү дээ. Амьдрал дээр олон зүйл гарна, өвчтэй хүн байна, шүүгч нараас чөлөө авчихвал яах вэ? Татгалзчихвал яах юм бэ? Ингээд танхим бүрдэхгүй, иргэдийн эрх ашгийг хангаж чадахгүй ийм байдал уруу орвол яах вэ гэдэг асуудлыг би яриад байгаа юм л даа. Гэтэл одоо үүнийг ойлгохгүй ингээд, үүний ямар ч ач холбогдол, шүүхийнхээ тухай хуулиар явж болохоор юмыг аваачиж ийм байдалд оруулаад байгаа гэдгийг хэлье. Тэгээд Байнгын хорооны гишүүд бас үүнийг ойлгож дэмжээрэй гэдгийг хэлье.

**С.Бямбацогт:** Санал хураалт явуулъя, Мөнхбаатар гишүүний саналаар. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 90.9 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалт.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалтын Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр таваас доошгүй жил ажилласан, гучин нас хүрсэн Монгол Улсын иргэнийг анхан шатны шүүхийн шүүгчээр томилно. Давж заалдах шатны шүүхийн шүүгч нь тухайн шүүн таслах ажлын төрлөөр дагнан анхан шатны шүүхэд зургаагаас доошгүй жил шүүгчээр ажилласан байна. Улсын дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан, дөчин нас хүрсэн Монгол Улсын иргэнийг арван хоёр жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа томилно.”

“Төслийн заалт”. Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Энэ ийм шүү, гишүүд ээ, анхаараарай. Түрүүн яг бид нар ийм юмаар санал хураасан, хоёуланг нь дэмжиж байгаад, арынх нь урдахтайгаа нийлээд нэг бүтэн заалт болоод явсан. Түүн шиг одоо энэ хоёрыг хоёуланг нь дэмжихгүй бол болохгүй. Дээд шүүхийн шүүгчийнхээ шалгуурыг нь тодосгож өгч байгаа юм. Тэгээд доодох саналаа дээдэхтэйгээ нийлүүлээд, дараагийн шатанд хамтраад явчих юм шүү. Тийм учраас хоёуланг нь дэмжээрэй.

**С.Бямбацогт:** Санал хураалт явуулъя, дэмжье гэсэн томьёоллоор.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 90.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

**7.1.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн** “Монгол Улсын иргэнийг 12 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа томилно.” гэсний дараа “Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн гуравны хоёр нь шүүн таслах ажлын туршлагатай байна.” гэж нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан. /Хууль зүйн байнгын хороо дэмжсэн/

Эхлээд Батнасан гишүүн саналаа тайлбарлалч.

**О.Батнасан:** Надыг үг хэлэхээр унах юм бол Их Хуралд олон жил суусан гишүүд Улсын дээд шүүхийн шүүгч болно гэж ойлгох хэрэгтэй ард түмэн. Энэ бол ингэж байгаа юм, давж заалдах шатны шүүхийн шүүгч дээр анхан шатны шүүхэд 6-аас доошгүй жил гээд шалгуур тавьчихсан, тэгсэн мөртлөө Улсын Дээд шүүхийн шүүгчийн шалгуур хуульчийн мэргэжилтэй, 15-аас доошгүй жил хуульчийн мэргэжлээр ажилласан, 40 нас хүрсэн иргэн гээд. Энэ шүүн таслах ажлын туршлага гэдэг юм бол байхгүй байгаа юмаа. Харин миний хувьд бол Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар гаргасан, 10-аас доошгүй жил шүүгчээр ажилласан гэж. Улсын дээд шүүхийн шүүгч чинь тэгж болохгүй шүү дээ, зүгээр 15 жил ажилласан компанийн хуульч, 15 жил Их Хуралд суучихсан Улсын Их Хурлын гишүүн, 15 жил багш хийчихсэн онолын багш очоод Улсын дээд шүүх дээр очоод ард түмний хувь заяаг шийддэг байж болохгүй шүү дээ.

Дээр нь Монгол Улс нэгдмэл шүүхтэй. Ямар ч шатны шүүхийн шийдвэр Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж болдоггүй юмаа. Ийм зүйл байгаа учраас Улсын дээд шүүхийн шүүгчийн шалгуурыг өндөрсгөж өгье гэсэн ийм санал оруулсан. Харин Мөнхбаатар гишүүнтэй санал нэгдээд, тэр 10-аас доошгүй жил шүүгчээс ажилласан гээд нэмээд оруулчих, энэ хоёр саналыг нэгтгээд оруулж болж байгаа юм. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Дэгд тийм дэг байхгүй. Санал хураалт явуулъя. Лүндээжанцан гишүүн.

**Д.Лүндээжанцан:** Би энэ Батнасан гишүүний саналыг дэмжиж байгаа юмаа, Батнасан гишүүн ээ. Таны энэ гуравны хоёр гэдгийг. Гэхдээ байна шүү дээ, үүнийгээ ингэж жаахан, би өчигдөр ажлын хэсэг дээр хэлсэн юм, миний тэр засварыг аваад ороод ирэхгүй дээ гэж. Гуравны хоёроос доошгүй нь гэж. Тэгэхгүй бол гуравны хоёр нь шүүн таслах ажлын туршлагатай байна гэхээр яг махан тоо болчихоод байна шүү дээ. Нэг эрдэмтэн орж болно шүү дээ, тийм ээ Батнасан гишүүн ээ. Тэгэхээр доошгүй нь гэдэг тодотголтойгоор миний нэрийг нэмж бичээд ч болсон, гуравны хоёроос доошгүй нь, хэрвээ энэ гуравны хоёр гээд орчих юм бол гуравны хоёр нь шүүгчид дотроосоо шатлан дэвшиж гарч ирнэ, гуравны нэг нь гаднаас байх ёстой гэдэг ийм буруу ойлголт гарч ирэх гээд байгаа учраас гуравны хоёроос доошгүй нь байх ёстой гэдэг ийм юм байгаа шүү дээ.

Тэгэхээр зорилгын онол, бичвэрийн онол, прагматизмын онол гээд 3 онолыг үндэслэж байж энд юм хийдэг юм, энэ хуулийн төсөл хийхэд. Гуравны хоёроос доошгүй нь тэр хорин тавуулаа ч байж болно, хорин хоёулаа ч байж болно.

**С.Бямбацогт:** Тэгвэл тэр ойлголтоор саналаа хураая. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 90.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гуравны хоёроос доошгүй нь гэсэн ойлголтоор явлаа шүү дээ, тийм ээ.

**7.2.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хуульчийн мэргэжлээр арван таван жил ажилласан” гэснийг “давж заалдах шатны шүүхэд арваас доошгүй жил ажилласан” гэж өөрчлөх.**

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, /Хууль, зүйн байнгын хороо дэмжээгүй/

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100.0 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

**7.3.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан” гэснийг “арваас доошгүй жил шүүгчээр ажилласан” гэж өөрчилж, “арван хоёр жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа” гэснийг хасах.**



Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, /Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй/

Мөнхбаатар гишүүн саналаа тайлбарлая.

**Л.Мөнхбаатар:** Энэ Төрийн байгуулалтын байнгын хорооныхон маань бас энэ шүүх эрх мэдлийн энэ хэсэг дээр бас нэлээн анхаарч, бас олон талаас нь бодож бас би шийдвэр гаргаасай гэж бодоод байгаа юм.

Энэ дээр анхаарах хэд хэдэн зүйлүүд байна, хоёр, гурван асуудал байгаа юм. Энд 51 дүгээр зүйл дээр, анхан шатны шүүхийн шүүгчээр хуульчийн мэргэжлээр 5-аас доошгүй жил ажилласан хүнийг, давж заалдах шатны шүүхийн шүүгчээр анхан шатны шүүхэд 6-аас доошгүй жил ажилласан хүнийг томилохоор ингээд өсгөж томьёолсон байгаа юм. Шаардлагыг нь дандаа өсгөөд томьёолоод байгаа юм. Гэтэл Дээд шүүхийн шүүгчийн энэ шаардлагыг нь бууруулчхаад байгаа юм, шалгуурыг нь бууруулчхаад байгаа юм. Ингэхээр ямар ч байсан давж заалдах шатанд ажиллах хүн бол өмнө нь мэргэжлээрээ 5 жил ажилласан, шүүгчээр 6 жил ажилласан анхан шатанд 6 жил гэхээр 11 жил ажилласан ийм хүн байх нь байна шүү дээ, энэ өндөр шалгуур тавьж байгаа юм. Энэ зүйтэй, ингээд явъя.

Гэтэл Дээд шүүхэд зөвхөн мэргэжлээрээ 15 жил ажилласан хүнийг л шүүн таслах ажлын туршлагагүй байсан ч гэсэн оруулах нь байна шүү дээ. Гэтэл энэ дээр сая Батнасан гишүүн ярьж байна, компанийн хууль ч ороод ирж болно, 15 жил нотариатч хийсэн, хуульчийн гэрчилгээтэй хүн ч ороод ирэх боломжтой. Ингээд тэр шүүн таслах ажлын туршлагатай, анхан шат, давж заалдах шатны шүүгч нарын тэр нотлох баримт, яг мэргэжлийнхээ дагуу хийсэн тэр хэргүүдийг хянадаг энэ ажлыг ямар ч шүүн таслах ажлын туршлагагүй хүмүүс хянах нь ээ. Шийдвэр гаргах нь. Эндээс ингээд би тодорхой асуулт тавихаар яг итгэл үнэмшилтэй би тайлбар авч чадахгүй байгаад байгаа юм, яг тодорхой тайлбар байдаггүй. Эрдэмтэд ороод хууль тайлбарлавал сайн гэсэн нэг иймэрхүү юм яриад байгаа юм.

Энэ Дээд шүүхийн шүүгч чинь өөрөө шүүгч мөн юм уу? Хэрвээ шүүгч юм бол шүүгч болгон шүүн таслах ажиллагаа явуулдаг. Ийм учраас яг л адилхан шүүгч нар байна шүү дээ. Гэтэл ер нь ялгавартай хандаад, зөвхөн Дээд шүүхэд нь хэн ч орж болдгоор, бусад шатны шүүгчид маш өндөр шалгуур тавьчихсан, анхан шатны шүүхэд 6 жил ажиллаж байж давж заалдах шатандаа ажиллах боломжийг ингээд бүрдүүлчихсэн байгаад байгаа юм.

Ийм учраас энэ онолын тийм тайлбар гаргах хэрэгтэй байгаа бол түүнийг өөр байдлаар шийдэж болох байх л даа. Хуучин бол энэ байдал уруугаа онолын тайлбар гаргадаг, ингээд энэ тал уруугаа явъя гэж байгаа бол хуучин 1992 оныхоо Үндсэн хуулийнхаа суурь баримтлалтай зөрчилдөнө. 1992 оноос өмнө Улсын Дээд шүүхийн гишүүн гэж явдаг байсан шүү дээ, гишүүн гэж явдаг. Тэр нь Ардын Их Хурлаас сонгогддог. Тэгээд тэр уруугаа явах гээд байна шүү дээ, одоо энэ чинь, тийм тайлбар, үндэслэл яриад, логик яриад байгаа юм бол. Энэ 1992 оныхоор бол зөвхөн энэ шүүгч шүүн таслах үйл ажиллагаа явуулахаар ингээд хуульчилсан шүү дээ. Ийм том концепцын юман дээрээ та нар чинь ингээд их өөр болгох гээд байгаа нь харамсалтай байна, манай Байнгын хорооны гишүүд ээ.

Ийм учраас энэ хэрэг маргааныг Дээд шүүхийн шүүгч өөрөө тасалдаг, шүүн таслах ажиллагаа явуулдаг учраас 10-аас доошгүй жил гэсэн энэ шалгуурыг тавьж өгье, шүүгчээр ажилласан байна аа гэж байгаа юм. 10-аас доошгүй жил гэдэг нь анхан шатанд ч ажилладаг, давж, заалдаг аль аль шатанд нь ажилласан байж болно. Тэгэхгүй бол анхан шатны шүүхэд нэгхэн жил ажиллачхаад, давах дээрээ ажиллахгүйгээр шууд Дээд шүүхэд очих ийм байдал үүсээд байна шүү дээ. Одоо хуучин ч гэсэн тийм байдлууд зөндөө л гарсан шүү дээ. 1 жил ажилладаг, тэгээд Дээд шүүхэд шууд орчихдог. Мөн гаднаас компанийн хуульч орчих жишээтэй. Иймэрхүү байдал үүсээд байгаа учраас үүнийгээ хаагаад 10 жил гээ. Давж заалдахад 6 жил ажилласан гэдэг шалгуур тавьж байгаа юм бол шүүхэд 10 жил гэсэн шалгуурыг тавихад яагаад болохгүй гэж, нэг. Энэ чинь шатлан дэвшиж байгаа тогтолцоо шүү дээ, бас нэг талаасаа.

Хоёрдугаарт, энэ төсөлд анх дурдагдсан, мэргэжлээрээ 15 жил гэдгийг бас агуулна. Яагаад гэвэл шүүгч болохын тулд 5 жил мэргэжлээрээ ажилласан байх ёстой гээд 5 жил, 10 жил шүүгчээр ажилласан байлаа, ингээд 15 жилийн аль аль агуулгаа агуулж байна. Ийм учраас манай Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд энэ заалтыг та бүгд маань дэмжиж өгөөч ээ гэж хэлэх байна. Ер нь гуравны хоёр нь ч гэдэг юм уу, ийм шалгуур тавьдаг нь маш буруу. Яагаад заримд нь шүүн таслах ажлын туршлага шаардчихаад, заримд нь огт шаардахгүйгээр хийж байгаа юм.

Яагаад тэгж байгаан? Энэ чинь өөрөө тэр Дээд шүүхийн шүүгчдэд тэгш бус байдлаар хандаж байна шүү дээ. Зарим нь шүүн таслах ажлын туршлагатай байж болно, зарим байхгүй ч байж болно гэж байна шүү дээ. Тэгээд энэ шалгуур чинь өөрөө ямар логик, авцалдаа байгаа юм бэ? Энэ асуудлуудаа та нар маань бодож байж энэ асуудлыг нухацтай хандахыг би та бүгдээсээ хүсэж байна.

**С.Бямбацогт:** Мөнхбаатар гишүүний саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 3 гишүүн буюу 27.3 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

**7.4.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан,” гэснийг “Улсын дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан, анхан буюу давж заалдах шатны шүүхэд зургаагаас доошгүй жил ажилласан,” гэж өөрчлөх.**

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа, /Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй/

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Ундраа гишүүний санал дэмжигдсэнгүй. 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

**7.5.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан”**

гэснийг “давж заалдах шатны шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100.0 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

8.Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор томилгооны сонголт хийж Улсын Их Хурал нийт гишүүний олонхын саналаар есөн жилийн хугацаатай томилно. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр дахин томилохыг хориглоно.”

“Төслийн заалт”. Мөнхбат гишүүн.

**Ж.Мөнхбат:** Энэ хоёр заалт Мөнхбаатар гишүүний гаргасан заалт уг нь авчихмаар заалт байгаа юм. Тэгээд үүнийг аваад найруулаад нэг болгоод хурааа гэсэн чинь яалаа? Одоо хоёуланг нь дэмжих юм уу? За, за.

**С.Бямбацогт:** Занданшатар гишүүн.

**Г.Занданшатар:** Би Мөнхбаатар гишүүнээс асууя. Энэ 2008 онд баталсан шүүхийн бие даасан байдлын олон улсын стандарт буюу Монтескье стандартын 4.3-т, шүүгчийн томилгоо хугацаагүй байх бөгөөд гагцхүү томилогдох үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах хугацаа болсон тохиолдолд шүүгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх нь зохистой гэж зөвлөмж байдаг юм байна. Нөгөө шүүхийн хараат бус байдал, шүүгчийн хариуцлагыг нэг талдаа сайжруулаад, хариуцлагын зөвлөл байсан учраас яг энэ одоогийн уур амьсгалаараа тэртэй тэргүй чөлөөлдөг заалтыг нь Шүүгчийн хариуцлагын зүйлдээ хийчихсэн юм чинь энэ насны асуудал дээр хуучнаараа явахгүй байсан юм бол, болохгүй байсан юм уу, түүнийг салгаад ярьж болохгүй байсан юм уу?

Хоёрдугаарт нь, Үндсэн хуулийн цэцийн гишүүний хууль зүйн өндөр мэргэшилтэй гэж, улс төрийн мэргэшил гэдгийг нь хасчихаар улс төрийн салбар дахь хууль зүйн өндөр мэргэшилтэй, улс төрийн шинжлэх ухаан гэдэг чинь бас тусдаа шинжлэх ухаан шүү дээ, энэ хоёрыг нэг холбоос болгож ашиглахгүй, тусдаа болгож ашиглаж, хууль хэрэглэсэн хэрэглээндээ байна уу? Энэ Үндсэн хуулийн заалтандаа байна уу? Энэ хоёрыг ажлын хэсэг юу гэж үзэж байна вэ? Ажлын хэсгээс асууж байна. Түрүүчийнх болон одоогийнхыг нийлүүлээд л асуучихлаа.

**С.Бямбацогт:** Мөнхсайхан.

**О.Мөнхсайхан:** Баярлалаа. Тэгэхээр энэ хууль зүйн, улс төрийн өндөр мэргэшилтэй гэж одоогийн Үндсэн хуульд байгаа. Ер нь бол Үндсэн хуулийн цэц

бол Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэдэг ийм шүүх байгаа, шүүх эрх мэдлийн байгууллага. Хууль зүйн, улс төрийн гэдгийг уг нь хамтад нь ойлгоод, улс төрийн гэдэг нь өөрөө улс төрийн харилцааг ойлгодог, улс төрийн шинжлэх ухааны мэдлэгтэй, Үндсэн хуулийн эрх зүйн мэдлэгтэй. Тэгээд ийм өндөр мэргэшилтэй хүн байна гэдэг агуулгаар 1992 оны Үндсэн хуульд орсон боловч 27 жил тэр улс төрийн гэдгийг нь ерөөсөө л намын гишүүн байсан, улс төрийн албан тушаал хашиж байсан гэдгээр ойлгож ирсэн учраас өнгөрсөн хугацаанд

Цэцэд ажилласан 36 хүний дийлэнх нь энэ хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдэг тэр шалгуурыг нь хангаж байгаагүйгээс болоод Цэцийн шийдвэрийн чанар нэлээн тааруу гэж шүүмжлэгддэг, үндэслэлээ бичдэггүй олон асуудлууд гарч байгаа.

Үүнтэй холбоотой бас Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг нэлээн асуудалтайгаар тайлбарласнаас болж зарим Үндсэн хуулийн өөрчлөлт ороход ч хүрч байгаа ийм зүйл байгаа юм. Тэгээд олон улсын жишиг, манай Үндсэн хуулийн анхны энэ үзэл баримтлалын дагуу хууль зүйн өндөр мэргэшилтэй гэж тодотгож оруулж өгч байгаа, энэ дотор нь тэр улс төрийн харилцаа, эрх мэдлийн хуваарилалт юмыг ойлгодог гэсэн агуулга нь багтаж байгаа гэж ойлгоод, Цэцийн хууль тогтоомжоо дэлгэрүүлж тайлбарлах, энэ талын мэдлэг ур чадвар, ёс зүй, туршлага байна гэдэг нь задраад явна гэж харж байгаа. Тэгэхээр энэ үзэл баримтлалаар орж байгааг дэд ажлын хэсэг, ер нь Үндсэн хууль судлаачид 100 хувь дэмжиж байгаа гэж ойлгож байгаа. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Цогт, 1 дүгээр микрофон.

**Ц.Цогт:** Занданшатар даргын асуултад тэр хугацаагүй байх ёстой гэдэг стандарт бол үнэхээр олон улсын бүх зөвлөмжүүд, стандартуудаар ердийн шүүхийн шүүгчийн хувьд томилогдсоноос хойш хугацаагүй байх ёстой гэдэг энэ тэтгэвэрт гарах хүртэл хугацаагаараа томилогдох ёстой гэсэн энэ зөвлөмж бол яг нэг түвшинд ойлгогддог. Үүнийг дэд ажлын хэсэг яг ийм саналыг удаа дараа гаргаж байсан. Үүнийг төслийн 51.3-тай холбогдуулж хэлж байна гэж ойлгосон. Энэ нь Үндсэн хуулийн цэцийн гэхээсээ илүү ердийн шүүхийн шүүгчийн хугацаатай холбогдуулж хэлсэн гэж ойлгосон. Тэгэхээр энэ бол Занданшатар даргын хэлдэг тэр үндэслэл бол зөв үндэслэл байгаа юмаа. Хугацаагүй томилогдох ёстой гэсэн үндэслэл нь.

**С.Бямбацогт:** Санал хураалт явуулъя. Төслийн заалтаар. Төслийн заалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 81.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.1.Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “есөн жилийн хугацаатай” гэснийг “есөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцож 100.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу Жаран тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арван таваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно.” Төслийн заалт. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцож 100.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.1.Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу Жаран тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “ажилласан” гэсний дараа “сүүлийн арван жил улс төрийн намын харьяалалтай байгаагүй” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Л.Болд, Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй. Санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 2 гишүүн буюу 18.2 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Шүүх засаглалтай холбоотой багц саналууд үндсэндээ хураагдаж дууслаа. Ямар санал байгаа билээ. Хугацааны. Хураагдсан байна. Татаж авсан саналуудыг та бүхэнд уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 51 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах.

5.Ерөнхий шүүгчийг Улсын Их Хурлын гишүүдийн 3-ны 2-ын саналаар томилох. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн дотроос нийт шүүгчдийн олонхын саналаар 3 жилийн хугацаагаар сунгана. Ерөнхий шүүгчийг тухайн шүүхэд нэг удаа улируулан сонгож болно гэсэн саналыг Батзандан, Болд нарын гишүүд гаргасан. Саналаа татаж авсан. Санал хураах шаардлагагүй.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтын мэргэшилтэй гэснийг мэргэжилтэй гэж өөрчлөх. Улсын Их Хурлын гишүүн Батзандан, Болд нар гаргасан. Саналаа татаж авсан. Санал хураах шаардлагагүй.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн томилох гэснийг томилуулах гэж өөрчлөх. Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар санал гаргасан. Саналаа татаж авсан. Санал хураах шаардлагагүй.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ганбаатарын гаргасан зарчмын зөрүүтэй татаж авсан саналыг та бүхэнд уншиж танилцуулъя.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 50-иас доошгүй гэснийг 75-аас доошгүй гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар энэ саналаа татаж авсан.

Мөн төслийн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 4 дүгээр зүйлээс 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 50-иас доошгүй

гэснийг 75 оноос доошгүй гэснийг хасах гэсэн саналаа татаж авсан байна. Тийм учраас энэ саналуудаар санал хураалт явуулах шаардлагагүй болсон.

Гишүүд байгаа биз дээ.

ДӨРӨВ. Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн талаар санал хураалтыг явуулна. Гишүүд бие засах гээд гарсан уу тиймээ.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрт хамаарах асуудлаар хуульд заасан, эсхүл сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргана.” Төслийн заалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100.0 хувийн саналаар энэ заалт дэмжигдсэнгүй. Төслийн заалт дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. 1.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дахиад уншихъя.

1.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 90.9 хувийн санал буюу 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу Жардугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргыг хуульд заасан үндэслэл, журмаар чөлөөлж, огцруулна. Сум, дүүргийн Засаг даргыг огцруулсан бол бүрэн эрхийн үлдсэн хугацаанд ажиллах Засаг даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга томилно.” Төслийн заалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100.0 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

2.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу Жардугаар зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. Тэдгээрийг хуульд заасан үндэслэл, журмаар чөлөөлж, огцруулна. Бүх шатны Засаг даргын бүрэн эрхийн хугацаа дараагийн Засаг даргын бүрэн эрх эхэлснээр дуусгавар болно.” Санал гаргасан: Ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор. Дуусгавар болно тийм.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долоодугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Улсын болон орон нутгийн харьяалалтай хот, тосгоны эрх зүйн үндэс, тэдгээрийн өөрийн удирдлагын болон засаг захиргааны зохион байгуулалтын зарчмыг хуулиар тогтооно.” Төслийн заалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100.0 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

3.1.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долоодугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Содбилэг гишүүн үг хэлье.

**О.Содбилэг:** Энэ ингээд 57.2-ын дахиж найруулсан энэ ингээд үнэхээр манай Эрдэнэтийн иргэдийн хүсэл бодолд нийцэхгүй ийм заалт болоод байна л даа. Одоогийн аймгийн статусаас нь бүр дордуулсан болчхож байгаа юм ингэхээр. Аймаг ч биш, тэгээд хот ч биш. Тэгээд дараа нь энийг Засгийн газар өргөн мэдүүлэх юм гэнээ. Хэзээ, яаж өргөн мэдүүлэх юм чухам тиймээ. Ингээд 100 мянган хүнтэй хотынхоо эрх ашгийг Үндсэн хуулиндаа угаасаа байгаа хот 2 л байна шүү дээ Дархан, Эрдэнэт. Улаанбаатараас гадна. Эд нарыгаа шууд хүлээн зөвшөөрөөд ингээд оруулчихгүй ийм найруулга хийгээд байхаар ерөөсөө манай Дархан, Эрдэнэтийнхэн энийг дэмжихгүй байх гэж бодож байгаа шүү.

Сая хэлэлцүүлгээр бол хамгийн их захиж байгаа юм бол энэ л байсан. Бид нар хот шиг ийм статустай болоод мэдээж нэрээ сэргээж авъя гэж байгаа юм. Хот шиг статустай болж тэгснээр тэр төрийн үйлчилгээ иргэддээ хүрэх нь дүүрэг хороогоороо хуваагдаад хүрэхгүй бол одоо жишээлбэл Баян-Өндөр суманд 100 мянган хүн амьдраад сумын статустай ингэж яваад төрийн үйлчилгээ хүмүүст хүрэхгүй байна гэдэг хамгийн том шүүжлэл байгаа. Тэрийг бол энүүгээр бол дээрдүүлж зассан юм харагдахгүй байгаад байна. 100 мянган хүнтэй одоо байгаа хотын асуудлыг Засгийн газарт ингэж үлдээж болохгүй ээ. Улсын Их Хурал өөрөө шийдэх ёстой. Шууд энэ дээр ингээд бид нар шийдээд явчих ёстой төсөлдөө. Тэгэхээр энийг бол дэмжихгүй байна.

**С.Бямбацогт:** Лүндээжанцан гишүүн тайлбар хийе.

**Д.Лүндээжанцан:** Содбилэг гишүүн бол одоо энэ Эрдэнэтийн асуудлаар маш олон удаа ярьж, цаана нь Дамба-Очир гишүүн, Хаянхярваа гишүүн, Жавхлан гишүүн, Баттөмөр гишүүн гээд ярьж байгаа юм. Тэгээд энийг одоо бүгдээрээ яаж шийдэх вэ. Дээр нь Улаанбаатарын гишүүд ярьж байгаа юмаа бас. Хотын асуудлын статус. Тэгээд энэ дээр бол бид хэрвээ одоо энэ хотыг

засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж гээд шууд бичдэг бол илүү амар байгаа юм. Орон нутгийн хот ч тэр, хот ч тэр. Гэтэл 9 зүйл дээр нэмэгдээд 24-өөс илүү гаргахгүй. Үгүй ээ ингэж байгаа. 70 зүйлийн 24-т нь бид хөдөлгөж болно гэж байгаа юм. Нэг үсэг үг сольдог ч юм уу яадаг ч юм. Тэгсэн чинь манайх одоо 20 зүйлд нь гар хүрчихээд байгаа байхгүй юу. Тэгээд 4 юунд нь багтахаа байчихаад ингээд энэ зохицуулалтыг хийж өгсөн. Хийж өгөхөд бол нэгдүгээрт, Эрдэнэт хот Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж оруулахгүй бол энд 2 газар Улсын Их Хурал бол шийдэх эрх нь Улсын Их Хуралд байна гээд Үндсэн хуулинд байж байгаа. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх, байгуулах асуудлыг батлах гээд Үндсэн хуулинд.

Мөн энэ Үндсэн хуулиндаа болохоор ийм ийм саналыг үндэслээд Засгийн газрын өргөн мэдүүлнээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гээд байж байгаа байхгүй юу. Тэгэхээр Засгийн газарт итгэхгүй байна гэж яриад байгаа байхгүй юу үгүй шүү дээ. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ эрх нь нээгдээд ирэхээр тэр чиг үүргийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг шилжүүлэх асуудал эхний ээлжинд Дархан, Эрдэнэт хотод бол шууд хамаарна. Харин аймгийн зэрэглэлтэй хотуудыг нь бол судалгаа гээд шаардаад бас нэг жаахан цаг хугацаа орж магадгүй.

Хоёрдугаарт, Содбилэг гишүүн ээ, энэ протоколд бол энэ бүхэн тэмдэглэгдэж байна. Тэгэхээр Засгийн газар оруулж ирэхгүй дээ. Өмнө нь хуурагдсан юм даа гээд ингээд яриад байна шүү дээ. Тийм юм бол байхгүй гэдгийг би бол хэлмээр байна. Өөрөөр хэлбэл энийг би үүрэг өгдөг хүн нь биш ч гэсэн энэ протоколд бол ороод явж байгаа учраас Эрдэнэт, Дархан хоёр бол улсын хэмжээний хот болно. Улаанбаатар хот бас улсын хэмжээний хот болно. Дээр нь Улаанбаатар хот нь одоо би бол ингэж төсөөлдөг шүү дээ, манайхан чинь яриад байгаа шүү дээ. Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Баянгол 4 нийлээд Улаанбаатар хот.

Яагаад гэхээр Улаанбаатар хотын нэрийг өөрчилж болохгүй. Үндсэн хуулинд нийслэл нь Улаанбаатар хот. Сонгинохайрхан, Баянзүрх хоёр нь бол хот байж болно шүү дээ бас. Ер нь зүгээр энэ би зүгээр төсөөлж байна шүү дээ. Энэ заавал биш. Энэ бол нийслэлийн иргэд өөрснөө ярих асуудал. Ямар ч байсан Улаанбаатар хот томоороо ч бай, хоёр, гурав хуваагддаг ч бай энэ өөрийн удирдлагынх нь асуудал шийдэгдэнэ жинхнээсээ. Нөгөө хуурамч Дамбийжаа гэдэг шиг биш. Хуучин бол ганцхан л ийм мухар заалт байсан. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооноо гэсэн ганцхан заалт байсан.

Тэгвэл өнөөдөр энэ дээр улсын хэмжээний болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тэгээд цэг таслал байгаа тосгоны тийм үү. Эрх зүйн үндсийг эрх зүйн байдлыг хуулиар тогтооно. Түүний одоо өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг гэж байгаа. Тэгэхээр өөрийн удирдлага, хот шиг хот болгох энэ асуудал нь өөрийн удирдлага гэдэг үгээрээ одоо засаглалынх нь асуудал шийдэгдэж байгаа юм. Зохион байгуулалтынх нь асуудал шийдэгдэж байгаа юм. Энэ чинь байна шүү дээ манай Үндсэн хууль бол дэлгэрэнгүй Үндсэн хууль биш. Манай Үндсэн хууль бас тунхаг Үндсэн хууль биш. Аль алиных нь дундуур явсан Үндсэн хууль байхгүй юу. Тийм учраас бүх зүйлийг Үндсэн хуулинд шаваас хийж оруулж болдоггүй. Бас нэг Үндсэн хуулийн онол ном байна.



Ийм учраас бид бүхэн энүүгээр нь нээж өгөөд тэгээд ард нь засаг захиргааны чиг үүрэг оноох асуудал нь бол нэгжийн чиг үүргийг өгөх асуудлыг нь Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнээ гээд ингээд компактный шийдээд өгч байгаа учраас болж байгаа юм.

Дархан, Эрдэнэт, Улаанбаатар гэдэг 3 нэрээр оруулна гэж нэг хэсэг нь дайраад байгаа юм. Гэтэл дахиад шинэ хот орох тоолонд байгуулах тоолонд Үндсэн хуульдаа бид өөрчлөлт оруулах уу гэж. Ер нь юмыг яаж мэдэх вэ, ойрын хугацаанд 2 шинэ хот гарч ирэхийг бас үгүйсгэх арга байхгүй шүү дээ. Ийм учраас бид бүхэн бол нэрлэн зааж бичихгүй байх зарчмыг баримтална гэдэг ерөнхий онол зарчим номынхаа дагуу /минут дуусав/

**С.Бямбацогт:** -Үндсэн хууль хэлэлцэж байгаатай холбоотой бүх ажлын хэсэг, Байнгын хороо, чуулганы хуралдааны протоколууд үлдэж байгаа. Тэгээд түүнтэй холбоотой бас дагаж гарах хуулиуд дээр энэ заалтууд бас тодорхой тусгагдах ёстой. Тусгагдахдаа бас тодорхой яг энд яригдсан агуулгын хүрээнд бас яригдана гэдгийг бас бид нар цааш цаашдаа бас ойлгоод бас нэгдсэн ойлголтонд хүрээд явчихъя гэж бодож байна.

Ингээд санал хураалтаа явуулъя. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

12 гишүүн санал хураалтад оролцсоноос 66.7 хувь буюу 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

3.2.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долоодугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй, Хууль, зүйн байнгын хороо дэмжээгүй. Мөнх-Оргил гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 91.7 хувь буюу 11 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Монгол Улсын нутгийн өөрийн удирдлагын үндсэн байгууллага нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал мөн. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн болон татвар тогтоох эрхтэй байна. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг иргэд сонгох журмыг хуулиар тогтооно.” “Төслийн заалт”. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100.0 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

4.1.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал

байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 81.8 хувийн санал буюу 9 гишүүний саналаар санал дэмжигдлээ.

4.2.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эхний өгүүлбэрийг “Монгол Улсын нутгийн өөрийн удирдлагын үндсэн нэгж нь сум, дүүрэг мөн.” гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн, Хууль, зүйн байнгын хороо дэмжээгүй. Мөнх-Оргил гишүүний саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 90.9 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалтын Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурал нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дөрвөн жилийн хугацаагаар сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.” “Төслийн заалт”. Төслийн заалтыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүний санал буюу 90.9 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

5.1.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалтын Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн. За Мөнхбат гишүүн тайлбар хэлье. Санал хураалтыг хүчингүй болгоё. Санал хураалтыг цуцалъя.

**Ж.Мөнхбат:** -Энэ заалтыг бол д эмжих заалт байгаа юм. Би бас энэ заалттай холбогдуулаад энэний өмнө санал хураасан заалтан дээр үг хэлэх гэж байгаа юм. Энэ хөдөө орон нутгийн иргэд сонгогчид энэ ард түмэн бол нэг юманд их дургүй байна. Аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгчөөс сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал сонгодог энэ юмыг бол нийтээрээ эсэргүүцэж байгаа. Тийм учраас бол Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл дээр байсан энэ орон нутаг, иргэд сонгогчдын дэмжихгүй байгаа энэ саналыг ажлын хэсэг харин ингээд засаад оруулж ирээд сайжруулаад, өөрөөр хэлэх юм бол аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч нар хуучнаараа үлдэж байна гэсэн ийм санал гаргаж ингээд дэмжигдсэн байгаа. Энэ дээр одоо нэг зүйлийг бид их анхаарах ёстой юм билээ.

Ялангуяа энэ одоо ингээд дагаж мөрдөх органик хуулиудаараа ингээд дэлгэрэнгүй зохицуулагдаад явна. Жишээлбэл Засаг даргыг багийн Засаг даргыг одоо энэ хуулиар сумын иргэдээс сонгогдсон Засаг даргаа сонгож байгаа юм, томилж байгаа юм. Гэтэл сумын Засаг даргаар томилогдсон нөхөр багийн

Засаг даргаараа дандаа найз нөхдөө томилчихвол яах вэ, ах дүү нараа томилчихвол яах вэ. Намынхныгаа томилчихвол яах вэ гэсэн ийм эрсдэл байгаа юм. Тийм учраас сумын Засаг даргыг ард түмнээрээ сумын иргэн сонгож байгаа. Огцруулдаг, хариуцлага алдсан одоо намчирхдаг ч юм уу, ах дүү төрөл төрөгсдөөрөө бөөрөлхдөг ийм одоо нэг сумыг, багийн Засаг даргыг нэг хувийн компани шиг байдалтай байлгах ийм хандлага гарах юм бол сумын Засаг даргыг огцруулдаг энэ заалтыг нь маш тодорхой, маш нээлттэйгээр одоо органик хуульд тусгах өгөх ёстой юм байна шүү гэдгийг л энэ заалтан дээр тодотгож хэлж байгаа юм тийм.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 90,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зургаа, төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалтын 60 .2 дахь хэсэг хоёр аймаг, нийслэлийн засаг даргыг аймаг нийслэлийн төлөөлөгчдийн хурлаас нэр дэвшүүлж, ерөнхий сайд, баг хорооны засаг даргыг харьяалах сум дүүргийн засаг дарга тус тус 4 жил хугацаагаар томилно, Ерөнхий сайд аймаг нийслэлийн засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлд заасан журмаар дахин нэг удаа нэр дэвшүүлж ерөнхий сайд томилно. Төслийн заалт. Төслийн заалтыг, зөвшилцөх гэдэг уг нь байх ёстой гээд байгаа ш дээ, Бямбажаргал, дэд ажлын хэсгийн Бямбажаргалд 2 дугаар микрофон өгье.

**А.Бямбажаргал:** Баярлалаа, нийт гишүүд, хуралдаан даргалагчид. Эдгээр заалтуудын хооронд бол шууд ямар нэг ялгаа байхгүй байгаа, гэхдээ энэ зайлшгүй нэг зүйлийг тооцох ёстой юм билээ. Нэгэнт бид нар сум, магадгүй яваандаа дүүргийн ч гэх юм уу одоо томьёоллоороо шууд сумын даргыг сонгож байгаа тохиолдолд сумын дарга маань нийт багийн дарга нарыг өөрөө томилж байгаа, Монгол улс бол нэгдмэл улс, хоёрдугаарт, ерөнхий сайдын гар хөл болж ажиллах Засаг дарга нар өөрөө нэгдмэл нэг цул байх ёстой. Хуулийг хэрэгжүүлэх биелүүлэх ажлыг хариуцдаг, тийм учраас одоогийн энэ томьёоллоор харах юм бол ерөнхий сайд нэг удаа нэр дэвшсэн хүнийг томилохоос татгалзвал шууд хурлаас нэр дэвшүүлж байгаа хүнийг томилох буюу ... хэм хэмжээ болж хувираад байгаа юм.

Өөрөөр хэлбэл ерөнхий сайд өөрөө нэгдсэн удирдлагаар хангаж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх гэдэг энэ агуулгадаа орон нутагт үүнийг хүргэх засаг даргыг томилж чадахгүй байх ийм хэмжээнд хүрчээд байгаа юм. Тэгэхээр агуулгын хувьд бол зарчмын зөрөөтэй санал гараад гишүүдээс энэ орж ирээгүй болов чиг хамгийн гол өөрчлөлт бол эхний удаа нэр дэвшүүлээд ороод ирэх нь хэвээрээ байж болно. Харин ерөнхий сайд хоёр дахь удаагаа нэр дэвших тохиолдолд заавал ерөнхий сайдтай зөвшилцөж дараа нь ерөнхий сайд томилох агуулгаар өөрчлөлт оруулахгүй бол хуулийг хэрэгжүүлэх энэ үйл ажиллагаа маань тасалдал үүсэх ийм нөхцөл байдал руу орох юм билээ. Энэ өнгөрсөн 27 жилийн хугацаанд нэгэнт тогтсон практик, үүнийг нь хууль зүйн болгож хувиргах шаардлага байгаа гэдгийг тодруулж хэлье. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Асуулт арай өөр тавигдсан, Мөнхбат гишүүн, асуулт ингэж тавигдсан байхаа. Хоёрт төслийн заалт ажлын хэсгийн заалт хоёрын яг зарчмын ялгаануудыг хэлээд өгөөч гэсэн, Мөнхбат гишүүний асуулт дээр нэмээд хариулахдаа хэлээрэй манай дэд ажлын хэсэг.

**Ж.Мөнхбат:** Яг энэ заалт дээр иргэд ийм юмыг сонирхоод байгаа, манай дэд ажлын хэсгийн ахлагч нар хариулах уу. Одоо аймгийн засаг даргыг томилохыг ерөнхий сайд татгалзах эрхтэй байна шүү дээ. Өөрийн чинь саяны тайлбарлаж байгаагаар бол нэгдмэл улсын шинж чанарыг хадгалах гэсэн шалтгаанууд ярьж байна. Сумын иргэдээсээ сумын засаг дарга сонгогдоод байгаа, тэгэнгүүт сумын засаг дарга нар 330 жижиг ноёдууд төрөх үү, нөгөө ерөнхий сайд, нөгөө төрийн нэгдмэл бодлого, улсын нэгдмэл байдал гэсэн юмнаас чинь салангид явчих ийм эрсдэл үүсэх юм биш биз.

Би ард түмнээсээ сонгогдсон, чи муу юу донгосоод байгаа юм ийм ийм юм ярьсан баахан хурган ноёдууд сум болгон дээр тодорчих юм биш биз дээ ийм эрсдэл болгоомжлол байгаад байна. Энэ бол ард түмний ярьж байгаа болгоомжлол зөв байхгүй юу. Тийм учраас та нарын энэ нэгдмэл байдал, монгол улс нэгдмэл улс мөн, төрийн бодлогын нэгдмэл чанар гэж яриад байна. Сумын иргэдээсээ сонгогдсон сумын засаг дарга нар аймгийнхаа даргад иргэдийн хурлаасаа сонгогдсон аймгийн даргадаа захирагдах уу, төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд, үүрэг даалгавар биелүүлэх үү, чи юу яриад байгаа юм, би ард түмнээсээ сонгогдсон, чи чаддаг юм бол намайг огцруулаарай гээд томроод байх юм байх уу.

**С.Бямбацогт:** За хэн хариулах вэ, За Товуусүрэн гуай 7-р микрофон

**Ц.Товуусүрэн:** Саяын асуултад, ер нь бол ийм юм, энэ хоёр томъёолол ямар ялгаатай вэ гэж, энэ хоёр томъёолол үндсэндээ ялгаагүй, нэгд нь төлөөлөгчдийн хурал гэж байгаа, нөгөөдхөд нь хуучнаараа иргэдийн төлөөлөгчдийн хурал гэж байгаа, тэгэхээр энэ бол үндсэн хуулийн одоогийн байгаа зохицуулалт руу шилжиж байна гэсэн үг, аймаг нийслэлийн засаг даргыг ерөнхий сайд томилох асуудал нь бол, тэгж ойлгох ёстой. Зүгээр сумын засаг дарга жижиг ноён болох уу гэдэг асуудал, анх үзэл баримтлал нь ямар байсан вэ гэхээр төвлөрлийг сааруулья гэсэн үзэл баримтлал байсан, түүн дээр яах вэ одоо сумын иргэдийн хурал бол үндсэн байгууллага гэсэн тэр томъёолол хасагдаж байгаа.

Тэгэхээр сумын засаг дарга бол одоогийн үндсэн хуулийн зохицуулалтаар төрийн удирдлагыг нутгийн удирдлагатай хослуулах тэр юм зарчим нь үндсэн хуулиараа хэвээрээ байгаа, дээрээс нь сонгогдсоных нь хувьд органик хуулиар болзошгүй тэр эрсдэлийг хаах арга арга хэмжээнүүдийг авч болно гэж харж байна.

Ер нь бол хуучнаасаа илүү бие даасан байдалтай болох гэх тийм эрмэлзэл гарахыг үгүйсгэхгүй, гэхдээ органик хууль дээр үүнийг сайн бодож тийм юмыг нь хааж өгөх ёстой гэж бодож байна. Улсын Их Хурлын гишүүд түрүү ажлын хэсэг дээр хуралдаад олонхоороо шийдсэн асуудал би тийм ийм гэж зөв буруу гэж хэлэх эрх байхгүй, нэгэнт өмнө нь олонхоороо шийдээд энэ томъёоллыг хийгээд ажлын хэсэгт хүргүүл гэсэн үүрэг авсан учраас тэр дагуу нь би энэ асуудалд хариулт өгч байна.

**С.Бямбацогт:** За, Тогтохсүрэн гишүүнд микрофон өгье.

**Д.Тогтохсүрэн:** Бямбацогт дарга аа, энэ хоёр байна шүү дээ ямар ч ялгаагүй байгаа юм, энэ хоёр заалт ялгаагүй, тийм учраас ялгаагүй хоёр заалтыг хурааж хэрэггүй, би ажлын хэсгийн саналыг татаж аваад үндсэн

заалтаараа явуулъя. Хойшлуулж хэрэггүй, одоо татаад авъя, ажлын хэсгийн заалтаар татаж аваад үндсэн саналаа авъя, энд ямар ч үг үсгийн зөрөө ялгаа байхгүй учраас ялгаа байхгүй, Бямбажаргалын яриад байгаа санааг би түүнийг дараагийн юм дээр ярих ёстой, Бямбажаргал бас л, энэ хоёр заалт байна шүү дээ, ижилхэн заалт байхгүй юу. Тэгэхээр ижилхэн заалтаа хоёуланг нь нэг нь унагаж байсанд орвол нэгийг нь татаад авъя, ажлын хэсгийн саналаар, тэгэхээр үндсэн заалт босоогоороо яваад өгнө. Ерөөс хөндөгдөхгүй байхгүй юу, хөндөгдөөгүй юм байхгүй юу.

**С.Бямбацогт:** Яг адилхан биш байгаад байгаа юм л даа. Сум дүүргийн засаг даргыг тус тус 4 жилийн хугацаагаар томилно гэсэн байгаа юм, 4 жилийн хугацаагаар, хоёр дахь дээр байхгүй болчхоод байгаа юм. Хоёр дахь дээр нь, тийм.

**Д.Тогтохсүрэн:** Тэр өөр заалт дээр орсон юм.

**С.Бямбацогт:** Тэгвэл татаад авах нь зөв юм уу. Болох уу. За тэгвэл ажлын хэсгийн саналыг татаж авсан.

Төслийн заалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

За санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 6,1 дэх саналыг ажлын хэсэг татаж авсан. 6,2 төслийн 3-р зүйлийн 13 дахь заалт буюу 60,2 дэх хэсгийн баг хорооны засаг даргыг харьяалах сум дүүргийн засаг дарга тус тус гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн төсвийн байнгын хороо дэмжээгүй, Тэмүүлэн гишүүний саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Тэмүүлэн гишүүний. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 92,3 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Долоо, төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалтын 60,3 дахь хэсэг. Гурав, сум дүүргийн засаг даргыг тухайн нутаг дэвсгэрийн иргэд 4 жилийн хугацаагаар сонгож, аймаг нийслэлийн засаг дарга 15 хоногийн дотор батламжилна, сум дүүргийн засаг даргын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Төслийн заалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтыг хүчингүй болгоё. Дараагийн санал Батзандан гишүүний тайлбар Болд гишүүнд микрофон өгье.

**Л.Болд:** Одоо байнгын хорооны өөрийнх нь хуралдаан дээр гаргаж байгаа гишүүдийн саналыг үүний дараа хураана ш дээ тийм ээ, энэ ямар нэг байдлаар дэмжигдэхэд түүнийг хураахад зөрчилдөхгүй биз. Яагаад гэвэл дараа нь энд хураагдсан байнгын хорооны хураагдсан саналууд чинь дараа нь ажлын хэсэг рүү шилжинэ шүү дээ. Тэнд цөмөөрөө дахин ярина тийм ээ, ярих эрхээ авах гээд байгаа ш дээ. Үүнтэй холбогдуулаад үүнийг арай өргөжүүлсэн томъёоллыг дараа нь хураалгах юм. Түүнийг анхаарч өгөөч ээ гэдгийг хэлмээр байгаа юм.

**С.Бямбацогт:** За яг ижил зүйл заалт дээр ижил агуулгатай буюу эсрэг агуулгатай саналууд гарах юм бол хураалгаж аль болох зөв ойртуулахыг бодно. тэгээд гурав хүртэл санал хураах боломж нь байгаа.

За, санал хураалтыг, төслийн заалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 92,3 буюу 12 гишүүн саналаар энэ санал дэмжигдсэнгүй,

7.1, төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалтын 60.3 дахь хэсгийн доор дурдсанаар өөрчлөн найруулах, гурав, сумын засаг даргыг тухайн нутаг дэвсгэрийн иргэд хуулиар тогтоосон журмын дагуу сонгож, аймгийн засаг дарга 15 хоногийн дотор батламжилна, дүүргийн засаг даргыг сонгох эсвэл томилох журмыг хуулиар тогтооно. Санал гаргасан ажлын хэсэг Их Хурлын гишүүн Мөнхбаатар, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ажлын хэсгээс гарсан ажлын хэсгийн төслийн заалтын саналуудаар байнгын хороодын саналуудаар санал хурааж дууслаа. Одоо гишүүдээс гарсан саналуудаар санал хураалт явуулна. Сая яригдсан, ижил төстэй саналаас нь хураая, хамгийн сүүлд яригдсан болохоор халуун дээр нь ярья, миний санал байна. Яах вэ адилхан гишүүний эрхээ эдэлье ээ. 60.2 одоо би уншиж өгнө, гишүүдийн гаргасан саналуудаар санал хураалт явуулна. Тараагдахгүй, одоо гишүүд сая бичиж өгсөн болохоор, сая бичиж өгсөн саналууд, хураагаад ажлаа цэгцэлнэ. За нэгд нь Их Хурлын гишүүн Бямбацогт зарчмын зөрөөтэй санал гаргасан байна.

60.2. Аймаг нийслэлийн засаг даргыг аймаг нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас нэр дэвшүүлж, ерөнхий сайд, баг хорооны засаг даргыг харьяалах сум дүүргийн засаг дарга томилно. Ерөнхий сайд аймаг нийслэлийн засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлд заасан журмаар дахин нэр дэвшүүлэхдээ ерөнхий сайдтай зөвшилцөн нэр дэвшүүлж томилно гэсэн, өөрөөр хэлбэл Бямбажаргал түрүү хэлсэн, үндсэндээ нэгдмэл байх засаг захиргаа нутаг дэвсгэр бодлогын хувьд гэдэг үүнийг дэмжээд өгөөч ээ саналыг гаргаж байгаа юм. Хамтатгаад авч болно тийм ээ, энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

За Содбилэг гишүүний саналыг та бүхэн уншиж танилцуулъя, Төслийн 3 дугаар зүйлийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт 22.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах. Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гуравны хоёроос доошгүй саналаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж шийдвэрлэсэн бол тухайн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх дуусгавар болсонд тооцно гэж өөрчлөн найруулах. Содбилэг гишүүн саналаа тайлбарлая.

**О.Содбилэг:** Энэ саналын цаад утга нь юу вэ гэхээр цэцийн дүгнэлтээр эсвэл шүүхийн шийдвэрээр Улсын Их Хурлын гишүүн хууль зөрчсөн байна гэдэг шийдвэр гарах юм бол яг тэр гишүүнээ эгүүлэн татах процесс нь тодорхойгүй юм билээ, үүнийг тодорхой болгож өгч байгаа юм, яг Их Хурал нь өөрөө шийдэж тэр гишүүнээ, тэхээр гуравны хоёроос доошгүй саналаар бүрэн эрх нь дуусгавар болох энэ Их Хурлын гишүүнийг, Их Хурал нь өөрөө яагаад гэвэл адилхан статустай гишүүд нь үүнийгээ авч хэлэлцэхээс өөр аргагүй гэдэг ийм логигоор

**С.Бямбацогт:** За Мөнхбат гишүүн яг ижил санал гаргасан. Тайлбарлая.

**Ж.Мөнхбат:** За энэ Улсын Их Хурлын гишүүнийг эргүүлэх татах энэ асуудлыг иргэд сонгогчид нэхэж байгаа юм. Их Хурлын гишүүд сонгогдоод 4 жил ерөөсөө уяагүй юм шиг ингээд яваад байна, ёс суртахууны, хуулийн хариуцлага алдсан, үндсэн хууль зөрчсөн байх юм бол эргүүлэн татдаг байх ёстой гэсэн иргэд сонгогчдын энэ саналыг би зөв гэж дэмжиж байгаа юм. Тийм учраас ажлын хэсэг дээр санал гаргасан. Содбилэг гишүүн бид хоёрын санал ерөнхийдөө ижил дүү маягтай ийм санал гарч байх шиг байна. Тэгээд одоо ажлын хэсэг дээр гарсан саналаар үндсэн хууль зөрчсөн эсэхийг нь үндсэн хуулийн цэц үндсэн хууль зөрчсөн байна гэж үзэх юм бол Улсын Их Хурал дээр тухайн гишүүнийг эргүүлэн татах асуудал яригдана гээд, энэ дээр бас нэг улс төржөөд цэцийн гаргасан шийдвэр болгоноор гишүүн татаад байдаг асуудал байх нь учир дутагдалтай юм гээд, давхар Их Хурлын шийдвэрийг гуравны хоёр гэсэн ийм босго тавиад орж ирж байгаа зүйл байгаа. Өөрөөр хэлбэл ард түмний сонгогчдын хүсэн хүлээгээд байгаа нөхөж шаардаад байгаа тэр Улсын Их Хурлын гишүүдийг эргүүлэн татна гэсэн энэ хуулийн заалт бол энэ зохицуулалтаар бүрэн хангагдаж байгаа гэж ойлгож болно. Санал нэг байна.

**С.Бямбацогт:** Энэ Их Хурлын гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох гээд Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахаас өөр Улсын Их Хурлын өөрийнх нь бүрэн эрх буюу нийт гишүүдийн гэж яригдаад байна тийм үү, энэ заалт хөндөгдсөн үү, энэ заалт хөндөгдсөн билүү, Хөндөгдсөн байна. Улсын Их Хурлын өөрийн бүрэн эрх дуусгавар болж байгаа чинь өөрөө гишүүний бүрэн эрх давхар дуусгавар болж байгаа биз дээ. Н.Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Яг дэгтэй Бямбацогт дарга аа, дэгтэй яаж уялдах эсэх нь би сайн мэдэхгүй байна. Гэхдээ яг хуралдаан дээр шууд гишүүдээс гарч байгаа саналыг ажлын хэсэг дээрээ яриад эргээд чуулганаар яривал арай дээр санагдах юм, та тийм санал хурааж өгвөл яаж байна, Хуралдана, харин дэгтэй зөрчилдөхгүй болбол гэж байна шүү дээ би, тайлбарыг нь сонсьё. Дэгтэй зөрчилдөхгүй бол би тийм санал гаргаж байна.

**С.Бямбацогт:** Дэгтэй бол би зөрчилдөхгүй гэж бодож байна. Яагаад гэвэл бид нар сая байнгын хороод гаргасан төслийн саналууд, ажлын хэсгийн саналууд хураахдаа үл ойлголцолтой тийм үү, зарим Болд гишүүний санал гарсан шүү дээ. Горимын санал Болд гишүүн гаргаад ойлголцолд хүрч байж асуудлыг шийдье. Тийм болохоор зарим саналуудаар санал хураахаа хойшлуулаач гэсэн горимын саналыг Болд гишүүн гаргасан. Нэлээд олон санал хойшлуулсан байгаа, тийм болохоор гэнэт орж байгаа саналуудыг бид нар ажлын хэсэг дээрээ дахиж ярьж байгаад дараагийн байнгын хороогоор оруулахаар хойшлуулж болно, тэгэх үү.

Тэгвэл одоо 6 санал байх шиг байна, Содбилэг гишүүний саналууд байна, Болд гишүүн, Батзандан гишүүний санал байна, Бямбацогт гишүүний санал байгаа, ийм саналууд байна. Мөнхбат гишүүний нэг санал байгаа, хойшлогдсон саналд орсон саналууд хойшилсон байгаа. Ингээд 6-7 саналуудыг хойшлуулчих уу. Ажлын хэсэг дээрээ дахиж ярьж байгаад, томъёоллоо харж байгаад, тийм ээ.

Содбилэг гишүүн та юу гэж бодож байна. Төслийн заалт хөндөгдсөн бил үү, хөндөгдөөгүй тийм ээ, Ямар ч байсан гишүүдийн гаргасан саналуудыг уншаад танилцуулчих уу, энэ цөөхөн санал байна. Содбилэг гишүүн, гишүүдийн саналуудыг хураахын тулд хөндөгдсөн төслийн заалтуудыг дахиж уншина,

тийм үү, За одоо төслийн заалт нь ийм байсан, үүнийг хураая гэж хураалгаад гишүүдийн гаргасан саналыг одоо ийм санал боллоо, ийм заалт ийм болгож байна гээд дахиж хоёр хураагдана. Ингэж хоёр хураагдана. Их Хурлын дарга.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Энэ үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хуулиар журамласан. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хууль дээр үндсэн хуульд нэмэлт оруулах санаачилга дур зоригийн шинж чанартай байж болохгүй. Хоёрын нэгдүгээр зүйл дээр бас дур зоригийн шинж чанартай үйлдэл нь Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэг гэсэн хатуу заалттай.

Дээр нь Улсын Их Хурал нь өөрөө өөрийнхөө эрх мэдлийг нэмэгдүүлэх, бүрэн эрхийн хугацаатай холбоотой санал гаргаж болохгүй гэсэн хоригуудтай байгаа. Тэгэхээр манай гишүүд санал гаргахдаа бас хуулиа сайн, хуультайгаа сайн нийцүүлж гаргахгүй бол үүн дээр саяны санал дээр гэхэд прокурорын саналаар одоогийн үндсэн хуулийн заалтаар прокурорын саналыг үндэслээд түдгэлзүүлэх асуудлыг олонхын асуудлаар шийдэж байгаа, прокурорын саналаар, шүүхийн шийдвэр гарсан үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарсан ийм асуудлаар гуравны хоёроор шийдвэрлэнэ гэхээр энэ агуулга концепцын зөрчил гарах вэ, үүнийгээ нэлээн сайн ажлын хэсэг дээр ярилцахгүй бол болохгүй байхаа гэж бодож байна.

**С.Бямбацогт:** За ажлын хэсгийн гишүүн Лүндээжанцан гишүүн санал, тайлбар хэлье.

**Д.Лүндээжанцан:** Баярлалаа. Тэгэхээр бас манай Төрийн байгуулалтын байнгын хороо хоёрдугаар хэлэлцүүлгээ ямар ч байсан эхлээд нэлээн олон асуудлаар одоо санал хураагаад шийдэж байна. Бас нэлээн олон асуудал болбол шийдэгдэж оруулж байна. Мөн нээлттэй үлдэж байгаа. Энэ асуудлуудаар манай гишүүд гаргахдаа тэр яг Үндсэн хуулийн журмын хууль, дэгийн хууль одоогийн үйлчилж байгаа бас бусад хууль бас Үндсэн хуулийн эрхзүй ерөнхий зарчим онол ном гэж байна. Тэрнийхээ дэг жаягийн дагуу явахгүй бол бас болохгүй. Бид нэг үг байдаг шүү дээ. Хуулийг бол яруу найраг шиг чөлөөтэй бичиж болдоггүй, илтгэх урлаг шиг уран гоё тансаг байдаггүй, тэгсэн мөртөө энэ бол ухаалаг, их логиктой, ийм аналитик ажил юм, хууль, төсөл бичих гэдэг бол.

Тэгэхээр энэтэй холбогдуулаад 3-н одоо онол ном байдаг. Нэг нь бол бичвэрийн онол, прагматизмын онол, зорилгын онол гээд . зорилго тавьчихдаг, гэтэл бичвэрийн онол дээрээ болохоор хууль тогтоогч яаж бичих вэ, гэтэл хууль тогтоогч яах, яаж бичих ёстой вэ гэдэг прагматизмын онол. Тэгээд ингээд бүх юм онол номоор явагддаг учраас бид одоо энэ ажлын дэд хэсгүүд мэргэжлийн хүмүүсийнхээ юмыг бол бас бодохгүй бол одоо ерөнхий зарчмыг барихгүй бол болохгүй байгаа юм. Одоо ингээд бид бүхэн бол сумын Засаг даргыг сонгодог боллоо гэхэд тавигдах шаардлагыг Үндсэн хууль дотроо ямар хэмжээнд оруулж өгөх вэ, тийм үү? Болд. Тэгэхээр ядахдаа одоо энэ сумын Засаг дарга болох хүн бол бид иргэдээсээ сонгогдож байгаа гэж ямар шалгуургүй байж болохгүй байгаа юм. Тэрийг нь юуг нь Органик хуульд өгөх вэ? Дээд боловсролтой байна ч гэдэг юм уу, ядахдаа нэг одоо энэ чинь хүн удирдана.

Улс төрийн цэвэр албан тушаалтан бол өөр хэрэг. Тэрний тэр боловсрол энэ тэрийн бол Сонгуулийн хуульд бол заадаггүй. Насны заагаад, тэгээд



татварын өргүй, ял шийдгүүлж яваагүй билүү тийм заалтууд байдаг. Гэтэл онцлог сумын Засаг дарга дээр тавигдах шаардлага гэдэг бол онцлог шаардлагууд байх ёстой. Энэ мэтчилний Юмнууд бол яригдах юм шиг байна лээ. Тэгээд энийг болбол ажлын дэд хэсэг дээрээ манай гишүүд гаргаж байгаа саналынхаа дагуу маш сайн ярилцаж байгаад бид бэлтгээд оруулж ирье. Одоо ингээд өнөө оройноос эхлээд бид нар нээлттэй саналууд болоод гишүүдийн гаргасан санал дээрээ ажиллаж эхэлнэ гэдгээ хэлье.

**С.Бямбацогт:** Гишүүдийн саналаар санал хураах уу, хойшлуулах уу?

**О.Содбилэг:** Энэ өнөөдөржингөө бусад Байнгын хорооны гишүүд өөрийнхөө Байнгын хороон дээр гаргасан саналын бид нар санал хураалтаар дэмжих, үгүйг хэлэлцчихээд яг энэ Байнгын хорооны гишүүний хувьд би саналуудаа гаргахаар санал хураахгүй гээд шал өөр юм яриад завхруулаад байх ийм шаардлага юу байгаа юм бэ. Яг бүрэн эрхийнхээ хувьд би энэ Байнгын хорооны гишүүний хувьд Төрийн байгуулалтын байнгын хороондоо зарчмын зөрүүтэй санал гаргаж байна шүү дээ. Тэгээд Дэгээрээ санал хураах ёстой шүү дээ. Яагаад өөр юм руу ингээд.

**С.Бямбацогт:** Юу яаж байгаа юм аа, Содбилэг гишүүн ээ. Нөгөө ердийн хууль хэлэлцдэгээс өөр дэгтэй, өөр горимоор Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуулиараа, тэрний дэгээр явж байгаа юм. Тэр нь дээр болохоор нөгөө их онцлогтой. Төслийг заалтаар эхэлж санал хураана, дараа нь ажлын хэсгийн заалтаар, дараа нь гишүүдийн гаргасан саналаар гэсэн ийм дэгтэй юм.

Тэгээд бусад Байнгын хороодын санал дээр ажлын хэсэг ажиллаад, бусад Байнгын хороодоос гаргасан саналууд, гишүүдийн гаргасан саналууд, ийм ийм саналууд байгаа юм байна. Төслийн заалттай харьцуулахаар ийм хоорондоо зөрчилтэй, ийм одоо давхцалтай, ийм байдлаар зохицуулж болох юм байна гэдгийн ажлын хэсэг маань ажиллаад ингээд хугацаанд ажиллаад тийм үү, Байнгын хороо хуралдах бэлтгэл ажил хийгээд ингэж орж ирж байгаа болохоор бусад Байнгын хороодын саналууд дээр гишүүдийн саналууд ажиллачихсан юм. Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо тийм ажлын хэсгийн ажиллачихсан санал дээр ажиллаж байгаа болохоор сая хурааж болсон.

Одоо нөгөө гишүүдийн шууд гаргасан санал дээр нөгөө төслийн заалттайгаа яаж дүйцүүлж харьцуулж үзэх үү, ажлын хэсгийн саналтай яаж хоорондоо уялдаж тийм үү, эсрэгцэж байна гэдгийг харьцуулах боломж байхгүй болохоор дэмжих, дэмжихгүй байх нь гишүүд нэлээд их хугацаа авах хооронд нь харьцуулагдаад сүүлд нь асуудал үүсэх иймэрхүү л болчихоод байгаа юм л даа. Тий болохоор ажлын хэсэг ажиллаж байж, төслийн заалттай хэр уялдаж байна, ажлын хэсгийн саналтай хир зэрэг нийцэж байна. Бусад байдлаар яаж томъёолж болохоор байна гэдгийн шийдэж байгаад энэ саналыг бол ингэж хураах нь зөв байна гэдэгт ажлын хэсэг бэлтгэл ажил шаардлагатай.

Энэ болохоор бусад ердийн хууль хэлэлцдэгээс өөр дэгтэй учраас ажлын хэсэг ажиллахгүй гэсэн юм. Тэгээд одоо хураагаад явчихъя гэвэл шууд хураагаад явчихъя. Хураачих уу тэгвэл. Одоо үндсэн заалт, хураана шүү дээ. Дэгийн хуулиараа бид нар төслийн заалтаараа эхэлж хураана. Үгүй. Одоо гишүүн болгоны гаргасан саналуудыг бид нар үндсэн төслийн заалттай яаж

уялдаж байна гэдгийн харж байгаад төслийн заалттай нь уялдуулж хураана. Дэгийнхээ хуулийг барина. Бид нар өөр өөрсдийн хүсэл сонирхлоороо биш, дэгийн хуультай, хуулиа л барьж явна. Бүгдээрээ биш хөндөгдсөн заалтууд нь өөр, хөндөгдөөгүй юм байгаа бол хөндөгдөж байна шүү дээ. Одоо жишээ нь, Содбилэг гишүүний гаргаж байгаа энэ нэг санал болбол 3 дугаар зүйлийн 22 дугаар 2 дахь хэсэг болбол хөндөгдөөгүй. Бид нар энэ дээр санал хураагаагүй, ерөөсөө. Тийм болохоор эхлээд төслийн заалтын яриад, энэ процесс дунд алдаа гарчих гээд байгаа байхгүй юу. Бид нар одоо тэгэхэд нэлээн нухацтай суух гээд байна л даа. Тэр нь дөнгөж яригдчихсан юм. Дөнгөж яригдсан халуун дээр нь би хураалгачихсан юм. Хураалгачихъя. Тийм, хураалгачихъя. Тийм ээ, тийм. Зөв.

Тэр миний хураалгасан санал чинь бол нэг хөндөгдөөд халуун дээр нь яг хөндөгдсөн асуудал учраас ингээд зэрэгцүүлэх хураалгачих уу гэж байгаад би хураалгачихсан юм. Энэ болохоор хөндөгдөөгүй заалт, төслийн заалтыг эхэлж хураах юм. Дэгээ бүгдээрээ сайн уншаад судалчихмаар байна. Ердийн дэгээс өөр шүү гэдгээ сайн ойлгочихмоор байгаа юм.

Тэгэхээр энэ бүгд нь дээр нь та бүхэн манай ажлын хэсэг, Байнгын хорооны ажлын алба юмнуудаа үзэж байх нь байна шүү. Энэ саналууд нь хоорондоо яаж уялдаж байна гэдгээ үзэж бай, тэх үү?

Ямар ч байсан эхний санал хураалт нь болбол ийм байгаа.

22 дугаар зүйлийн 2 хэсгийг хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах гэж байгаа юм. Үндсэн хуулийн төслийн заалтын 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь Улсын Их Хурлын нийт гишүүний 2/3-с доошгүй саналаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж Улсын Их Хурал шийдвэрлэсэн бол Улсын Их Хурал тарна гэсэн заалт байгаа юм. Энэ төслийн заалт. Төслийн заалтыг дэмжье гэсэн томъёоллоор, эхлээд Содбилэг гишүүнийхийг би одоо харьцуулаад уншаад өгье.

Содбилэг гишүүнийх болохоор Улсын Их Хурлын нийт гишүүний 2/3-с доошгүй саналаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж шийдвэрлэсэн бол тухайн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх дуусгавар болсонд тооцно гэж өөрчлөн найруулах гэж байгаа юм. Үндсэндээ Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын бүрэн дуусгавар болж байгаа нь тухайн гишүүний бүрэн эрх давхар дуусгавар болж байгаа л даа, уг нь бол. Заавал энийг ингэж давхар орох шаардлагагүй л байх. Тэгэхдээ ажлын хэсэг Лувсанжав гуай тайлбар хийгээдэх дээ. 5 номерын микрофон.

**Н.Лувсанжав:** энэ 2/3-р Улсын Их Хурал тарах асуудал бол шийдэгдэнэ. Тэгэхдээ дараагийн сонгуулиа зарлаж, тэр сонгуулиар Улсын Их Хурлын гишүүн сонгогдсоноор бүрэн эрх нь дуусгавар болдог энэ заалт болбол Улсын Их Хурлын Үндсэн хуулийн 2-т байгаа. Би уншаад өгье.

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно гэж байгаа шүү дээ. Тэгээд энэ чинь тарах тухай Улсын Их Хурлын шийдвэр тогтоол батлагдангуут л гишүүн бүрэн эрхгүй болно гэж байхгүй байхгүй юу. Энэ заалтаар. Энийг харин ойлгох ёстой байх.

**С.Бямбацогт:** Тэгэхээр ерөнхийдөө ойлгомжтой боллоо шүү дээ. Их Хурал маань дараагийн гишүүн бүрэн эрхээ үргэлжилж тасралтгүй явах ёстой. Тэгэхгүй бол үндсэндээ нэг Их Хурал тарахад дараагийн Их Хурал сонгогдох хүртэл тасраад төрийн үйл ажиллагаа тасалдах ийм Үндсэн хуулиа зөрчсөн асуудал болох гээд байна, тийм ээ?

Тийм болохоор төслийн заалтаа Улсын Их Хурлын нийт гишүүний 2/3-с доошгүй саналаар, саналаа татчих уу? Содбилэг гишүүн.

**О.Содбилэг:** Би түрүүн нь тайлбарлаж байсан Улсын Их Хурлын гишүүнийг татахтай холбож ингэж оруулсан юм. Яагаад гэвэл Их Хурал татан буулгахтай хамааралтайгаар гишүүнийг бас татах энэ заалт руу оруулья гэж бодож оруулсан юм. Гэхдээ би энэ саналаа татчихъя. Яагаад гэвэл дараа нь бас энэ түрүүн Мөнхбат гишүүн яртлаа, энэ асуудлаас яг хөндөгдөөд Их Хурлын гишүүнийг эргүүлэх татах нь тусдаа орж байгаа учраас энэ саналаа татлаа.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Содбилэг гишүүн саналаа татлаа. Саналаа татаж байгаа учраас энэ санал хураалт, төслийн заалтаар санал хураалт явуулах шаардлагагүй болчихлоо. Ингээд нөгөө бид нар ажиллах шаардлагатай болоод байгаа байхгүй юу. Тэгэхгүй сая ингээд тайлбарлаад явах бол буруу болчих гээд байна шүү дээ. Тэнд тайлбар байхгүй байсан бол одоо тэгээд шал буруу ойлголтоор явах нь байна шүү дээ, бид.

Одоо ингээд дараагийн саналуудаа. Төслийн 4 дүгээр зүйлийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, гишүүд маань саналаа хураая л гээд байна л даа.

Төслийн 4 дүгээр зүйлийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт, 27.2-т 75-с доошгүй гэсний дараа ээлжит чуулганы ажлын өдрийг тухайн жилийн 3 дугаар сарын 1-ээс мөн 7 дугаарын сарын 29-с тоолно гэсэн өгүүлбэр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Содбилэг.

Үүнтэй холбоотойгоор Төслийн заалт нь хөндөгдөөгүй заалт байх. 27.2 Улсын Их Хурлын чуулган хагас жил тутамд нэг удаа 75-с доошгүй ажлын өдөр чуулна гэж орж ирсэн байгаа. Хуучин 50-с доошгүй өдөр байсныг 75-с доош гэж нэмсэн. Энэ заалт хөндөгдөөгүй. Сая ажлын хэсэг дээр бол санал гараагүй. Содбилэг гишүүн сая санал гаргаж байна. Тийм болохоор ойлгочихлоо, тийм ээ, харьцуулаад тийм ээ. Нэг нь бол 3 дугаар сарын 1-ээс нөгөөх нь 7 дугаарын сарын 29-с гэсэн тодорхой календарийн өдөртэй болгоё гэж Содбилэг гишүүн санал гаргасан.

Одоо төслийн заалт нь болбол хагас жилд нэг удаа 75-с доошгүй өдөр ингээд байж байгаа. Одоогийн хуулиар болбол 10 сарын 1, 4 сарын 5 байгаа шүү дээ. Содбилэг гишүүн тайлбарлах уу? Одоо Их Хурлын тухай хуулиар тийм заалттай байж байгаа. Үндсэн хуульд бол тийм заалт байхгүй байгаа

**О.Содбилэг:** Энэ саналын нь санаа нь ямар учиртай юм бэ гэхээр Улсын Их Хурлын чуулган 75 хоног хэрвээ хуралдах юм бол яг ингэж календарчилж зааж өгөхгүй бол 75 хоногтоо багтаж хуралдахгүй байгаад байгаа юм. Яг ингэж зааж өгөөд. Нөгөө утгаараа юу вэ гэхээр Улсын Их Хурлын үйл ажиллагааг дагаад Монголын амьдрал аягүй их хамааралтай явдаг. Янз бүрийн хуулийн шийдвэр гарахыг хүлээгдэж байдаг. Намрын чуулган 10 сард эхэлдэг байхад яг

тэр зуны буюу эсвэл намрын эхэн саруудыг гол ажил хийгддэг үеийн, үеэр Улсын Их Хурал ажиллахгүй болохоор маш олон ажил шийдэгдэхгүй байгаа учраас 7 сарын 29-с эхлүүлж байя.

Тэгснээрээ бас нөгөө 75 хоногтоо чуулган хуралдаж багтахаар ингэж тооцож байгаа юм. Энэ өдрүүдийн болбол зүгээр 3 дугаар сарын 1. Жишээлбэл Эх орончдын өдөр гэж тэмдэглэдэг өдөр байгаа. 7 дугаар сарын 29-нд Монголд анхны парламентын сонгууль, ардчилсан парламентын сонгууль явагдсан өдөр гэдгээр нь ингэж сонгож өдөр заасан юм. Заавал ийм өдрөөр байх албагүй. Тэгэхдээ ингэж хуваарьт оруулж байж 75 хоногоороо хуралдах боломж нь бүрдэнэ гэсэн санаагаар оруулсан юм.

**С.Бямбацогт:** Лүндээжанцан гишүүн тайлбар хэлье.

**Д.Лүндээжанцан:** Өргөн барихын өмнө ажлын хэсэг дээр Содбилэг гишүүн энэ саналаа гаргасан. Содбилэг гишүүний гаргасан энэ саналыг бол би зарчмын хувьд бол дэмжээд байгаа юм. Гэхдээ яг Үндсэн хуульд зааж өгөх үү гэдэг асуудал байгаад байгаа. Ер нь бол яагаад 75-г 1999, 2000 онд 50 болгон гэхээр Бямба гариг амралтын өдөр болсон учраас гэдэг үндэслэлээр орж ирсэн.

Гэхдээ Монгол Улсын парламент бол байнгын ажиллагаатай парламент учраас 150 хоног нь байна шүү дээ, тийм үү? 75 хоногт 150 хоног нь, цаана нь 365 хоног байгаа, жил бол. Тийм учраас энэ асуудлыг байна шүү дээ Үндсэн хуульдаа биш одоо яг энэ Их Хурлын хууль, Дэгийн хууль ярьж байгаа үед Их Хурлын дарга анхааралдаа аваад. Ер нь энэ байна шүү дээ, төсвийг хэлэлцэх тийм үү?, суудал эртхэн бэлтгэлд нь орох, энэ байнгын ажиллагаатай гэдэг шинжийн хангахын тулд нөгөө 7-н нэмэлт, өөрчлөлтийг яг одоо хуучнаар нь сэргээж байгаа ганц заалт байгаа байхгүй юу. Тийм учраас тэр 7 хоног гэдгийг бол буцааж сэргээх нь зүйтэй юм гэж ингэж үзсэн.

Ганбаатар гишүүн, Ж.Ганбаатар гишүүн бол 50-р байлгая гэдэг санал гаргаад тэрийгээ татаж авсан гэдгийг би бас энд нэг дахиад өчигдөр ажлын хэсэг дээр ярьсан. Тэрийгээ энд мэдэгдье гэж.

Энэ асуудлыг болбол Их Хурлынхаа хуульд болбол яг ямар оновчтой байх юм бэ гэдгийн бол одоо Их Хурлын гишүүд цөмөөрөө хоорондоо ярьж байгаад, ажлын хэсгүүд судалж байгаад тэр зуны нээрээ л 7сарын 1-с 10 сарын 1 хүртэл 4 сарын ийм зай гараад байгаа. Энийг бол яаж зохицуулах вэ гэдгийг бол сайн судалгааны үндсэн дээр энэ Содбилэг гишүүний энэ саналыг анхаарч үзээд Их Хурлынхаа хуульд бол бас бид нарын энэ 10 сарын 1, 4 сарын 5 болж байна уу, үгүй юу. Энийгээ нэг эргэж харъя гэсэн асуудал шүү дээ, ер нь бол. Ингээд явж байгаа юм.

Энэ чуулган ямар хугацаанд үргэлжлэх үү гэхээр бид нар бас энгийн хүмүүс энд бол Нэгдсэн чуулган, Байнгын хорооны хуралдаан, Бүлгийн хуралдаан цөм нийлж байж сая одоо чуулганы хугацаа гэдгийг бол тооцдог. Тийм учраас бол 75 хоног бол бид гэхэд сая байна шүү дээ, хэд хоног завсарлалчихсан. Тэрнээс биш 75-с доош хуралдаж байсан түүх байхгүй.

Энэ бусад үед нь бол одоо ёстой нөгөө Их Хурал хянан шалгах үйл ажиллагаагаа явуулж, харьяа байгууллагынхаа тайланг сонсох энэ бүх ажлуудаа бол сайтар явуулж байх, хуулийн төслийг хэлэлцэх ажил бол нэлээн

нухацтай, яаруу сандруу биш явагдаж байх энэ нөхцөл байдалд бол 75 хоног бол болж байна. Хугацаа тогтоохын бол Үндсэн хуульд бол бид бол өргөн барихад бол аваагүй, энийг болбол Органик хуулиар бол Содбилэг гишүүний энэ саналыг авах нь зүйтэй ингэж үзсэн.

**С.Бямбацогт:** Одоо тайлбар хийгээд яах вэ. Ерөнхийдөө ойлгочихлоо шүү дээ. Чуулган нь бол Улсын Их Хурлын тухай хуульд маш тодорхой заачихсан байгаа шүү дээ. Чуулган нь Нэгдсэн чуулган, Байнгын хороодын дагнасан буюу хамтарсан, түүнчлэн нам эвслийн бүлгийн хуралдаанаас тус тус бүрдэнэ гээд. Манайхан бол ойлгохдоо бол чуулган гэхээр Нэгдсэн хуралдаанаа л зөвхөн чуулган гэж ойлгоод байдаг. Байнгын хороодын хуралдаан чинь чуулган, Бүлгийн хуралдаанууд чинь чуулган. Тийм болохоор энэ хуралдаанууд бол 75-с доошгүй хоногтоо хийгдээд байх бололцоотой гэдгийг гишүүд ойлгосон байх.

Ингээд нэгэнтээ хөндөгдөж байгаа учраас хөндөгдсөн саналаар санал хураалт явуулъя. Үүний өмнө ажлын цаг дууссан байна. Энэ хэдэн саналыг хэлэлцэж дуустал хуралдаанаа сунгачихъя.

27.2 Төслийн заалт. Их Хурлын чуулган хагас жил тутамд нэг удаа 75-с доошгүй ажлын өдөр чуулна энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 90.9 хувиар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Төслийн 4 дүгээр зүйлийн 70 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт 27.2. 75-с доошгүй гэсний дараа ээлжит чуулганы ажлын өдрийг тухайн жилийн 3 дугаар сарын 1-с мөн 7 дугаар сарын 29-с эхлэн тоолно гэсэн өгүүлбэр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Содбилэг. Саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 7 гишүүн буюу 63.6 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийнх нь. Содбилэг гишүүний санал тийм ээ? 43.1 Ерөнхий сайдыг огцруулж, шинэ Ерөнхий сайд томилох асуудлыг Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцэн шийдвэрлэнэ гэсэн өгүүлбэр нэмье гэсэн. Энэ саналыг нөгөө хойшлуулсан саналуудтай агуулга нэг байгаа. Тэр үед нь хамтад нь хураана. Энийг ингээд хойшлуулаа.

Энэ Ерөнхий сайдыг огцруулж, шинэ Ерөнхий сайд томилох асуудлыг хойшлуулчихсан, тэр нь дээр яригдана. Энэ санал хойшлогдлоо.

51.3 чинь яана гэнэ ээ? 51.3 өнөөдөр яригдсан. Шүүхийн засаглалтай холбоотой асуудал байна. Авчихсан? Саналаа татчихсан уу? 51.3 дээр гаргасан саналаа татаад авчихсан. Санал хураагдахгүй юм байна.

57.2 Нутгийн удирдлагын байгууллагатай холбоотой, тийм ээ? Хоттой холбоотой асуудал байгаа. 57.2-н эхэнд хүн амын их хэмжээний төвлөрөл бий болсон нутаг дэвсгэрийг Улсын зэрэглэлтэй хот гэж үзэж нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж гэж тооцон эрх зүйн байдлыг нь хуулиар тогтооно гэсэн

томъёолол нэмье гэж байгаа. 57.2 дахь заалт нь дээр. Энэ нөгөө хөндөгдчихсэн, төслийн заалтад хөндөгдчихсэн. Ажлын хэсэгт санал хураагдчихсан. Тийм болохоор шууд санал хурааж болно. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 54.5 хувь 6 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Содбилэг гишүүний гаргасан саналууд дуусчих вуу, тийм ээ?

Одоо Болд, Батзандан нарын гишүүдийн гаргасан санал байна. Төслийн 2 дугаар зүйлийн 13 дахь заалт буюу 60 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг өөрчлөх.

Сум дүүргийн Засаг даргыг өөрчлөх гэснийг сум дүүргийн Засаг даргад тухайн аймаг нийслэлд, сум, дүүргийн Засаг даргыг гэснийг сум, дүүргийн Засаг даргад тухайн аймаг, нийслэлд сүүлийн 5-с доошгүй жил оршин сууж байгаа бөгөөд тухайн сум, дүүргийн сонгогчдын 50-с доошгүй хувийн дэмжлэгийг авсан иргэнийг нэр дэвшүүлж тухайн, 5-с доошгүй юм уу? 5-с доошгүй хувийн дэмжлэгийг авсан иргэнийг нэр дэвшүүлж тухайн сум, дүүргийн иргэд 4 жилийн хугацаагаар сонгож аймаг, нийслэлийн Засаг дарга 15хоногийн дотор батламжилна. Сум, дүүргийн Засаг даргын сонгуулийн журмыг хуулиар тогтооно гэж өөрчлөх. Санал гаргасан Болд, Батзандан гишүүн. Энэ хөндөгдсөн билүү? Өнөөдөр яригдчихсан.

Болд гишүүн тайлбар хийе.

**Л.Болд:** Түрүүн Лүндээжанцан гишүүн хэлсэн. Лүндээжанцан гишүүн хэлсэн шүү дээ. Бас нэг тийм хязгаарууд тогтоох хэрэгтэй байгаа юм гэж. Сумын дарга нарыг бол сонгож болно. Сонгохоор бид ойлголцож байна. Гэхдээ энэний цаанаа тодорхой нэг ажлын хязгаарлалтууд хийхгүй болбол маш олон гишүүд энэ асуудал дээр одоо болгоомж бол ярьж байгаа. Тэгэхээр энийг бол Байнгын хороон дээр санал хураахгүйгээр ажлын хэсэг рүү шилжүүлчхэж болно гэж Байнгын хороон даргад хэлмээр байна. Тэнд бол энэ угаасаа яригдаж байгаа сэдэв. Гол нь аль нэг Байнгын хороогоор дамжиж орж ирээгүй учраас асуудлыг хэлэлцэх бололцоогүй байсан юм. Төрийн байгуулалтын байнгын хороо руу шилжүүлчихвэл болж байна.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Нэлээн ярилцах шаардлагатай санал байна. Тийм болохоор ажлын хэсэг рүү шилжүүлээд хойшлуулж байгаад тэгээд санал хураалтаа явуулъя. Энэ саналыг хойшлууллаа.

Ингээд Байнгын хороодын гишүүдийн гаргасан саналуудаар санал хураалт явж дууслаа. Гэхдээ юу байна шүү дээ, хойшилсон саналтай холбоотойгоор саналууд хойшилчихсон байгаа. Бид нар нэлээн олон санал хойшлуулсан. Түүнтэй холбоотой манай гишүүдийн гаргасан саналууд давхар хойшлогдож байгаа шүү. Энийг бас та бүхэн зөв ойлгоорой. Ямар ч байсан өнөөдрийн Байнгын хорооны хурал дааныг түр завсарлуулж байна. Нэг дэх өдрийн 14 цагаас үргэлжлүүлж хуралдана. Тэр болтол манай ажлын хэсэг, дэд хэсгүүд маань энэ саналуудаа цэгцлэх. Жич зарлая.

Байнгын хорооны хуралдаан түр завсарлалаа. Өнөөдрийн хуралдааныг дуусгалаа.

Баярлалаа. Идэвхтэй оролцсон гишүүддээ, ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа. Байнгын хорооныхоо Тамгын газрынхаа ажилтнуудад баярлалаа бас.

Дууны бичлэгээс буулгасан:  
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ

Ц.АЛТАН-ОД

П.МЯДАГМАА

П.ОЮУНГЭРЭЛ

Д.УЯНГА

Д.ЦЭНДСҮРЭН

Д.ЭНЭБИШ /Гэрээт/

Б.БААСАНЖАВ /Гэрээт/

Б.УРАНЧИМЭГ /Гэрээт/